



БОЛОВСРОЛ СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
БОЛОВСРОЛ II
ТӨСӨЛ

ЕБС-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫН МОДУЛИЙН БҮТЭЦ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ

Захиалагч: ТХБ-II төсөл

Гүйцэтгэх байгууллага: БШУЯ-ны харьяа Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

2022

ЕБС-ИЙН ШИНЭ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫН МОДУЛИЙН БҮТЭЦ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ

**Ажлын хэсгийн
ахлагч:**

Т.Ням-Очир, Боловсролын ерөнхий газрын дарга

Нарийн бичиг:

А.Энхтогтох, ТХБ-II төслийн зохицуулагч

Гишүүд:

М.Итгэл, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн
захирал, Ph.D

Д.Мөнхжаргал, МУБИС-ийн дэд захирал, Ph.D

Х.Отгонбаатар, Боловсролын судалгааны үндэсний
хүрээлэнгийн сургалтын хөтөлбөр, сурах бичиг,
үнэлгээний судалгааны секторын эрхлэгч, Ph.D

Н.Оюунцэцэг, Судлаач, Ph.D

Х.Энхжаргал, Боловсролын судалгааны үндэсний
Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Э. Шинэцэцэг, БОМСТ-ийн гүйцэтгэх захирал

Сургалтын модуль боловсруулах, суралцах үйлийг хөнгөвчлөх зорилгоор дараах таних тэмдгийг ашигласан болно.

Таних тэмдэг



Зорилго



Хэрэгжүүлэх хугацаа



Уншиж судлах материал



Даалгавар



Бүтээгдэхүүн

ГАРЧИГ

МОДУЛИЙН ТАНИЛЦУУЛГА	5
МОДУЛЬ 5. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙН ХӨГЖИЛ	8
Үйл ажиллагаа 1. Чадавхийг хөгжүүлэх хандлага	11
Үйл ажиллагаа 2. Багшийн мэргэжил дээшлүүлэх загвар	15
Үйл ажиллагаа 4. Чадавхийг хөгжүүлэхэд багш бэлтгэх болон давтан сургах боломж	25
МОДУЛЬ 6. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ	30
Үйл ажиллагаа 1. Сургалтын хөтөлбөрийг турших загварууд	32
Үйл ажиллагаа 2. Сургалтын хөтөлбөрийг турших төлөвлөгөө	37
Үйл ажиллагаа 3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, Инноваци, туршлага	41
МОДУЛЬ 7. ҮНДЭСНИЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ҮНДЭСЛЭСЭН СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХӨГЖИЛ	45
Үйл ажиллагаа 1. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн хөгжил	49
Үйл ажиллагаа 2. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх сургуулийн менежмент	53
Үйл ажиллагаа 3. Сургуулийн суурилсан хөтөлбөрийн хяналт- шинжилгээ, үнэлгээ	56
МОДУЛЬ 8. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН БА СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ	58
Үйл ажиллагаа 1. Суралцагчийн үнэлгээ	61
Үйл ажиллагаа 2. Тодорхой судлагдахууны сургалтын үр дүнгийн үнэлгээ	65
Үйл ажиллагаа 3. Үндэсний түвшин дэх сургалтын хөтөлбөрийн үнэлгээ	74
Үйл ажиллагаа 4. Сургуулийн түвшин дэх сургалтын хөтөлбөрийн үнэлгээ	77
ДҮГНЭЛТ	81
САНАЛ	81

МОДУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, бүтэцчилсэн хүрээ нь сургалтын хөтөлбөр биш харин сургалтын хөтөлбөрийн бодлого, практикийн параметр зэргийг системтэй зохион байгуулах, удирдах, хянаж, зохицуулж болох чиглэл, стандартыг тогтоодог баримт бичиг юм. Тиймээс сургалтын хөтөлбөр нь улс орны болон сурагчийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ шаардлагад хэрхэн нийцэж байгаа, заах арга зүй, багшийн сонгон шалгаруулалт, үнэлгээ—зэрэг сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд шууд нөлөө үзүүлэх олон асуудлыг хамарна.

Бодлого боловсруулагчид сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ямар нөөц шаардлагатай болохыг анхаарч үзэх хэрэгтэй. Тухайлбал:

- Үндэсний сургалтын хөтөлбөрт үндэслэн орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн судлах сургалтын хөтөлбөр, эсвэл сургалтын үйл ажиллагааг төлөвлөсөн, чөлөөтэй сонгож судлах сургалтын хөтөлбөрийг боловсруулсан эсэх;
- Орон нутгийн тулгамдсан асуудал, сургуулийн онцлогт нийцсэн цагийг сургалтын төлөвлөгөөнд тусгасан эсэх;
- Сурагчид заавал судлах хичээлээс илүүтэйгээр өөрийн сонирхол, хэрэгцээнд нийцсэн хичээлийг сонгож судлах боломжийг бүрдүүлсэн эсэх гэх мэт

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөгжүүлэх үйл явц, үе шатууд

Сургалтын хөтөлбөрийг боловсруулсны дараа хэрэгжүүлэх хүний нөөцийг чадавхжуулахын тулд дараах асуултуудын хариултад анхаарал хандуулах хэрэгтэй. Үүнд:

Асуултууд:

- Боловсролын тогтолцооны бүх салбарууд сургалтын хөтөлбөрийн шинэ үзэл баримтлал, бүтэцчилсэн хүрээ, тэдгээрийн үр нөлөөг ойлгож байна уу?
- Сургалтын хөтөлбөрийн шинэ үзэл баримтлал, бүтэцчилсэн хүрээг хэрэгжүүлэх сургалтын байгууллагуудын төлөвлөлтүүд бэлэн болсон уу?
- Сургалтын хөтөлбөрийн шинэ үзэл баримтлал, бүтэцчилсэн хүрээг хэрэгжүүлэх нөөц (санхүүгийн болон хүний, материалын нөөц) ямар байна вэ?
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах бүтэц (хороод, ажлын хэсэг, эрх бүхий хүмүүс гэх мэт) бий болсон уу?
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжихийн тулд ямар арга, хэрэгслийг ашиглаж болох вэ?

Анхаарал хандуулах асуудал:

- Тухайн улс орон, орон нутаг, сургуулийн өргөн хүрээний асуудлыг харгалзан үзэх;
- Өнгөрсөн хугацаанд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн туршлагад тулгуурлах;
- Одоо байгаа үйл явц, шинэ сургалтын хөтөлбөрийн үзэл санааг ойлгож, хүлээн авах;
- Боловсролын янз бүрийн түвшний удирдлагын үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрөх;
- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний, санхүүгийн, материалын нөөцийг тооцох гэх мэт

Сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх олон онол, загварууд байдаг. Бид сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, сургалтын хөтөлбөрийг боловсруулах хүний нөөцийг чадавхжуулах сургалтын модулын бүтцийг боловсруулахдаа ADDIE загвар ашиглахыг санал болгон зөвлөж байсан бол сургалтын хөтөлбөрийг турших, хэрэгжүүлэх хүний нөөцийг чадавхжуулахад PDCA загварыг хэрэглэж болохыг зөвлөж байна.

Сургалтын хөтөлбөрийн шинэ үзэл баримтлал, бүтэцчилсэн хүрээг хэрэгжүүлэх үйл явц

1. Plan буюу төлөвлөх эхний үе шат нь нотлох баримт цуглуулах "урьдчилсан шат" гэж үзэж болно. Сургалтын хөтөлбөрийг турших, хэрэгжүүлэх хэрэгцээ, хамрах хүрээ, цаг хугацаа, нөөцийг төлөвлөсөн байна. Эдгээр төлөвлөгөө нь практикт хэрэгжих боломжтой, гарах зардлыг санхүүжүүлсэн байх ёстой бөгөөд бодит цаг хугацаатай байх ёстой.
2. Do буюу хэрэгжүүлэх үе шатанд сурагчийн эзэмших чадвар, заах арга зүй, суралцахууд суурилсан боловсролын стратегийг туршиж, хэрэгжүүлнэ. Энэ үе шатанд дараах үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд:
 - Боловсролын мэргэжилтэн, туршилтын сургуулийн багш, удирдах ажилтнуудад сургалт явуулах
 - Шинэ санаа, саналыг турших, таниулах
 - Зөвлөх үйлчилгээ үзүүлэх
 - Туршлага судлах
 - Түгээн дэлгэрүүлэх сургалт явуулах
 - Хичээлийн болон үйл ажиллагааны хэлэлцүүлэг, форум зохион байгуулах
 - Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх
 - Хэвлэл мэдээллийнхэнд цогц мэдээлэл өгч, олон нийтэд таниулан сурталчилах гэх мэтҮүний тулд оролцогч талуудад сургалтын хөтөлбөрийн онцлог шинж чанаруудыг таниулах товхимол, зурагт хуудсыг боловсруулан хүргэж болно. Үүнд:
 - Багш нарт зориулсан мэдээллийн зурагт хуудсыг бүх сургуулийн ажлын байранд байрлуулах;
 - Сурагчид хэрхэн суралцах ёстойг тайлбарласан товхимол, ангийн шинэ динамикийг дүрсэлсэн/зурагласан товхимолыг эцэг эхчүүдэд тараах;
 - Шаардлагатай бол төгсөгчид ямар мэдлэг, чадвар, хандлагатай болсон байхыг харуулсан товхимолыг ажил олгогчдод танилцуулж болох юм.
3. Check, Study буюу хянах, судлах үе шатанд хичээлийн ажиглалт хийх, сургуулийн болон орон нутаг, үндэсний түвшний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн гүйцэтгэлд анализ хийх, сайн хичээл үйл ажиллагааны зөвлөгөөн зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийх, амжилт, бэрхшээлийг тодорхойлох нь чухал юм.
4. Action буюу сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах энэ үе шатанд эргэх холбоонд үндэслэсэн арга зүйн сургалтууд зохион байгуулах болон сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Энэ удаа сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үнэлэх үе шатны модуль 5-8-ын бүтцийг жишиг болгон боловсруулж, зөвлөмжид тусгалаа.

X

үснэгт 1.1. Сургалтын модуль

Сургалтын хөтөлбөрийн хөгжлийн үе шат	Сургалтын модуль
Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Модуль 5. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөцийн чадавхийн хөгжил Модуль 6. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явц Модуль 7. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн хөгж
Сургалтын хөтөлбөрийг үнэлэх	Модуль 8. Сургалтын хөтөлбөрийн ба суралцагчийн үнэлгээ

Өөр хоорондоо нягт уялдаа бүхий дээрх модулийг хэрэгжүүлэх оролцогчид дараах арга хэлбэрээр сургалтын үйл ажиллагаанд оролцоно.

Зураг 1.1. Оролцогчдын үйл ажиллагаа



Санал болгосон модулийн бүцийн дагуу хүний нөөцийг чадавхжуулах сургалтын арга хэрэгсэлийг боловсруулахдаа мэргэжлийн байгууллагууд дараах зүйлд анхаарал хандуулах хэрэгтэй. Үүнд:

- Өмнө нь хэрэгжүүлж байсан сургалтын хөтөлбөрийн туршлага, сургамж, судалгааны үр дүнг эргэцүүлэн бодох;
- Шинэ сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, шинэлэг санаа, кейс судалгааг уншиж судлан багаар хамтран туршиж хэрэгжүүлэх;
- Шинэ санаа, инновацийг бий болгох;
- Сургуулийн болон орон нутаг, үндэсний түвшний хэлэлцүүлэг форум зохион байгуулж, сайн туршлагаудыг бусдад түгээн дэлгэрүүлэх чиглэлээр ажлын хуудас боловсруулж, сургалт зохион байгуулахыг зөвлөж байна.

МОДУЛЬ 5. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙН ХӨГЖИЛ



Модулийн зорилго

Энэхүү модуль нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх, зорилтот оролцогч талуудыг чадавхжуулах тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох, суралцахуйн шинэ хандлага, стратегийг шинэчлэх арга барилыг судлан тогтооход оршино.



Хэрэгжүүлэх хугацаа:

Сургалтын хөтөлбөрт өөрчлөлт/шинэчлэл хийсний дараа турших, хэрэгжүүлэх хугацааны туршид багшийг чадавхжуулах сургалтыг тасралтгүй, үе шаттайгаар зохион байгуулна.



Хүний нөөцийг чадавхжуулах нь сургалтын хөтөлбөрийг өөрчлөх/шинэчлэхэд оролцож буй хувь хүн, бүлгүүдийн мэдлэг, ур чадвар, ойлголтыг хөгжүүлж, бодлого боловсруулах, удирдах, дүгнэх, шинэчлэх талаар мэдээлэлтэй шийдвэр гаргах боломжийг олгох үйл явц юм. Энэхүү модулийн санал болгож буй үйл ажиллагаа нь сургалтын хөтөлбөр боловсруулагчдад сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх чадавхийг хөгжүүлэхтэй холбоотой гол асуудлуудын талаарх ойлголтоо нэмэгдүүлэх боломжийг олгоно. Модулиар дараах асуудлыг судална:

1. Хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх арга барил нь мэргэжил дээшлүүлэх байнгын тасралтгүй асуудал.
2. Багшийн мэргэжил дээшлүүлэх загварууд
3. Шинэчлэлийн зайлшгүй нөхцөл болох сургалтын хөтөлбөр боловсруулагчдын чадавхийг бэхжүүлэх.
4. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан багш нарыг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын явцад суралцах боломж, тэдгээрийн хувилбар.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхийг хөгжүүлэхэд анхаарах зүйлс

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төлөвлөсөн (intended) болон хэрэгжүүлсэн "implemented" сургалтын хөтөлбөрийг ялгаж сурах нь хөтөлбөр боловсруулагчдад хоёр чиглэлийн тэнцвэрийг барихад тустай.

Төлөвлөсөн (эсвэл албан ёсны) сургуулийн сургалтын хөтөлбөрийг бодлогын баримт бичиг, сургалтын хөтөлбөрийн удирдамж, стандарт болон үнэлгээний систем, сургалтын хөтөлбөр, сурах бичиг болон бусад сургалтын хэрэглэгдэхүүнд тусгадаг. Энэ нь суралцахаар төлөвлөж буй туршлагын бүтэц, агуулга, аргыг тодорхой тодорхойлно. Сургуулийн багш, сурагчдын харилцан хамтын бүхий үйл ажиллагаагаар төлөвлөсөн сургалтын хөтөлбөр хэрэгждэг. Хэрэгжүүлсэн сургалтын хөтөлбөр нь суралцагчдын суралцах туршлагыг бодитоор бүрдүүлж, тэдний сургалтын үр дүнг тодорхойлоход чухал хувь нэмэр оруулдаг хөтөлбөр юм.

Сургалтын хөтөлбөрийг өөрчлөлт нь (үр дүн, амжилт) бүх оролцогч талуудын хамтын алсын хараа, эерэг хандлага, амлалт өгөх чадвартай байх зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг динамик бөгөөд бэрхшээлтэй үйл явц юм. Иймд сонирхогч, оролцогч талуудын сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлийн төрөл бүрийн асуудлыг шийдэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх нь чухлаар тавигдана.

Ийм нөхцөлд чадавхийг хөгжүүлэх гэдэг нь асуудлыг шийдвэрлэх, өөрчлөлт/шинэчлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ойлголт, мэдлэг, ур чадвар, туршлага, эерэг хандлагыг олж авахад хувь хүн эсвэл бүлэгт туслах үйл явц юм. Энэ нь хөтөлбөр боловсруулагчид болон оролцогч талуудыг бодлого боловсруулах, сургалтын

хөтөлбөр боловсруулах, сурах бичиг боловсруулах, үнэлэх, туршилт, инноваци, хэрэгжилт, сургалтын хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ зэрэг чиглэлээр сургах чадавхжуулах гэсэн үг юм.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхийг хөгжүүлэх нь дараах гурван чухал хэмжигдэхүүн (чиглэл)-тэй.

- Цогц чадамжийн түвшинг дээшлүүлж, эерэг хандлагыг төлөвшүүлэх;
- Сурган хүмүүжүүлэх шинэлэг арга барил, загваруудыг хөгжүүлэх зэрэг
- Олон нийтийн оролцоо, нөөцийг бүрдүүлэх.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцож буй хүмүүс чадавхийг хөгжүүлэх олон төрлийн үйл ажиллагаанд хамрагдана. Тухайлбал, сургалт семинарын дадлага ажил, дараагийн тогтвортой үйл ажиллагаа, сургуульд суурилсан чадавхийг хөгжүүлэх санаачлагыг мэргэжлийн хөгжлийн хөтөлбөрт тусгах гэх мэт. Эдгээр үйл ажиллагаа хувь хүнд дутагдаж байгаа эсвэл хэрэгцээтэй ур чадваруудыг онцлон харуулахаас илүүтэй давуу талыг бий болгоход чиглэнэ. Энэ нь хувь хүний цогц чадамж/чадавх/ур чадвар гэхээсээ илүү сул талыг сайжруулахад чиглэсэн суралцахуйн “хомсдол”-ын загвараас татгалзаж байгааг харуулж байна. Хувь хүмүүст бие биеээсээ суралцах боломжийг олгох нь чухал бөгөөд энэ явцад үе тэнгийнхнийхээ чадавхийг хөгжүүлнэ.

Сургууль бүрт байнгын хамтын ажиллагааны харилцан солилцоог хангадаг дэмжлэгийн сүлжээг бий болгох нь багш нарын тусгаарлагдмал мэдрэмжийг бууруулж, сургалтын хөтөлбөрийг өөрчлөх үйл явцыг хөнгөвчлөхөд тусална. Цаашилбал, хамтран ажиллагсдын сүлжээ нь бие биенээсээ суралцаж, бие биенээ дэмжиж байгаа нь практик хамтын нийгэмлэгийг бий болгоход чухал ач холбогдолтой төдийгүй өөрчлөлтийн үйл явцыг тогтвортой байлгахад тусална.

Хүснэгт 5.1. Модуль 5-ын үйл ажиллагаа ба хэрэгжүүлэх даалгавар

Үйл ажиллагаа	Даалгавар	Бүтээгдэхүүн
1. Чадавхийг хөгжүүлэх хандлага	Даалгавар 1. Багш нарт тулгарах бэрхшээлийг тодорхойлох	1. Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш нарт тулгарах бэрхшээлийн жагсаалт
	Даалгавар 2. Багшийн мэргэжил дээшлүүлэх арга замуудыг тодорхойлох	2. Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн мэргэжил дээшлүүлэх арга замуудын жагсаалт
	Даалгавар 3. Багш нарт үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох	3. Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш нарт үзүүлэх дэмжлэг, тухайн дэмжлэгийг хэрэгжүүлэх арга замуудыг харуулсан хүснэгт
	Даалгавар 4. Багш нарын МХХТ-ийн чадавхийг дээшлүүлэх чиглэлийг тодорхойлох	4. Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш МХХТ-ийн чадавхийг дээшлүүлэх чиглэл
	Даалгавар 5. Тодорхой сургалтын хөтөлбөрийн хүрээнд чадавхийг хөгжүүлэх боломжуудыг тодорхойлох	5. Тухайн судлагдахууны сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих арга барил, чадавхийг хөгжүүлэх боломжуудыг тодорхойлсон тайлан

2 Багшийн мэргэжил дээшлүүлэх загвар	Даалгавар 1. Үр дүнтэй багшлах суралцахуйн орчинг бүрдүүлэх	6. Багшийн мэргэжил дээшлүүлэх үзэл баримтлал, үр дүнтэй багшлах суралцахуйн орчны дүр зураг 7. Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй, загварын жагсаалт, товч тайлбарын хамт 8. Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн сургуульд суурилсан багшийн хөгжлийн загварууд, товч тайлбар 9. Өөрийн нөхцөл байдалд багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, хэрэгжүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нэр, тэдгээрийн эрэмбэ. 10.Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих вэбэд суурилсан сургалтын хөтөлбөрийн бүтэц, элементүүд 11.Тогтвортой хөгжлийн төлөөх багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих арга замууд 12.Манай орны өвөрмөц стратеги шаарддаг нөхцөл байдал, багш, эцэг эхчүүдийн эрэлт шаардлага нарын чадавхийг хөгжүүлэх
	Даалгавар 2. Үр дүнтэй багшлах арга зүйг тодорхойлох	
	Даалгавар 3. Сургуульд суурилсан багшийн хөгжлийн загварыг дэвшүүлэх	
	Даалгавар 4. Багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд нөлөөлдөг хүчин зүйлсийг тодорхойлох	
	Даалгавар 5. Багшийн мэргэжлийн хөгжлийг вэб (online эх сурвалж)-эд суурилан дэмжих	
	Даалгавар 6. Тогтвортой хөгжлийн төлөөх багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих	
3. Чадавхийг хөгжүүлэх шаардлагатай бусад оролцогчид	Даалгавар 1. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд оролцох мэргэжилтнүүдэд шаардагдах мэдлэг, ур чадварыг тодорхойлох	13.Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлд оролцоход зайлшгүй шаардагдах мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадваруудын жагсаалт 14.Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлд оролцоход мэргэжилтнүүдийн шинээр шаардагдах мэдлэг, ур чадваруудын жагсаалт 15.Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлд оролцоход мэргэжилтнүүдийг чадавхжуулах арга хэмжээний жагсаалт, эрэмбэ
	Даалгавар 2. Сургалтын хөтөлбөрийг шинэчлэлд оролцох мэргэжилтэнүүдэд шинээр шаардагдах мэдлэг, ур чадварыг тодорхойлох	
	Даалгавар 3. Сургалтын хөтөлбөрийг шинэчлэлд оролцох мэргэжилтэнүүдийн чадавхийг хөгжүүлэх	
4. Чадавхийг хөгжүүлэхэд багш бэлтгэх болон давтан сургах боломж	Даалгавар 1. Багш бэлтгэхэд ашиглах арга замуудыг тодорхойлох	16.Багш бэлтгэхэд ашиглах аргуудын жагсаалт 17.Багш бэлтгэхэд боломжит арга замуудыг ашиглах боломжийг судласан товч тайлан
	Даалгавар 2. Багш бэлтгэх боломжит арга замуудыг ашиглах боломжийг судлах	

	Даалгавар 3. Багш бэлтгэх сургалтад нэвтрүүлж болох стратегиудыг тодорхойлох	18.Багш бэлтгэх сургалтад нэвтрүүлж болох стратегиудын жагсаалт.
	Даалгавар 3. Шинэ зууны багшийн эрхэмлэх үнэт зүйлсийг тодорхойлох	19.Шинэ зууны багшийн эрхэмлэх үнэт зүйлсийн жагсаалт
	Даалгавар 4. Багшийн компетенцийг тодорхойлох, загварчлах	20.Шинэчилсэн сургалтыг хэрэгжүүлэх багшийн компетенцийн загвар (зурагт хуудас)
	Даалгавар 5. Багшийн компетенци/ур чадварыг олгож буй багш бэлтгэх хөтөлбөрийг судлах	21.Манай орны багш бэлтгэх тэргүүлэх сургуулиудын хөтөлбөрт багшийн компетенци/ур чадваруудыг тусган олгож буй төлөв байдлын товч тайлан (юуг чадаж , юуг нь чадахгүй байгаа зэрэг орно),
		22.Багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг өөрчлөн/шинэчлэхэд тусгах санаа, саналын жагсаалт.
4 үйл ажиллагаа	5+7+3+5 = 20 даалгавар	22 бүтээгдэхүүн

Модуль 5-ын үйл ажиллагааны даалгавруудын бүтээгдэхүүнийг нэгтгэн боловсруулж өөрийн нөхцөл байдалд тохирсон чадавхийг хөгжүүлэх хандлага, стратегийг тодорхойлох; багшийн мэргэжил дээшлүүлэх загварыг сонгох бий болгох; сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлд оролцох бусад оролцогчдыг хөгжүүлэх; багш бэлтгэх болон давтан сургах боломжуудыг дэвшүүлнэ.

Үйл ажиллагаа 1. Чадавхийг хөгжүүлэх хандлага



Зорилго. Энэхүү үйл ажиллагаа болон санал болгож буй даалгаврууд нь оролцогчдод тодорхой нөхцөл, нөхцөл байдалд тохирсон чадавхийг хөгжүүлэх өөр стратегийн талаар хэлэлцэхэд нь туслахад оршино.



Сургалтын хөтөлбөрийг өөрчлөх/шинэчлэх үйл явц нь оролцогч талууд боловсролын болон сургалтын хөтөлбөрийн зорилгын талаар нийтлэг итгэл үнэмшилтэй байж суралцагчдын суралцахуйн өнөөгийн олон талт хэрэгцээг хангахаас гадна нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчин, соёлын хөгжлийн үндэсний өргөн зорилтуудад ч үйлчлэнэ. Боловсролын тогтолцоо нь багш, ажилтнаас төрөл бүрийн ур чадвар шаарддаг томоохон, нарийн төвөгтэй бүтэц юм. Чадавхийг хөгжүүлэх олон үйл ажиллагаа ерөнхий шинж чанартай байж болох боловч хувь хүн, бүлгүүдийн онцлог хэрэгцээг холбогдох тохиолдол, нотолгоонд суурилсан амжилтын түүх, төвлөрсөн туршлага судлах үйл ажиллагаанд тулгуурласан зорилтот сургалтын хөтөлбөрөөр дамжуулан шийдвэрлэнэ.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд чадавхийг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн боловсролын бодлого боловсруулагчид, сургалтын хөтөлбөрийн мэргэжилтэн, багш, сурган хүмүүжүүлэгч нарт хамгийн үр ашигтай байхаар зохион байгуулна. Эдгээр бүлгийн чиг үүрэг, чадавхийг хөгжүүлэх хэрэгцээг тус бүрээр тодорхойлсон мэдээллийг ЮНЕСКО ба ИББ (IBE) байгууллагын сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх нөөц материалын 125-р талаас үзнэ үү.

Багшийн мэргэжлийн хөгжил гол төлөв дараах гурван үе шаттайгаар явагддаг.

- Сургуулиудад томилогдох, томилогдохын өмнө бэлтгэл буюу багшаар бэлтгэгдэх;
- Албан ёсоор ажиллах (ихэвчлэн багшлах эхний гурван жил)
- Багшийн мэргэжлийн карьерын туршид явагддаг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах.

Багш бэлтгэх, давтан сургах үйл ажиллагааг хамгийн үр дүнтэй зохион байгуулахад багшийн хөгжлийн гурван үе шат бүрийг өмнөх үе шатны сургамж, багшийн мэргэжлийн туршлага дээр үндэслэх, уялдуулах нь чухал. Чадавхийг хөгжүүлэх нь нэг удаагийн сургалт биш, тасралтгүй явагдах үйл явц байна. Нийгмийн бодит шаардлагын дагуу сургуулийн сургалтын хөтөлбөр, багшлах арга зүй, туршлага өөрчлөгдөж байгаа тул багш нар мэдлэг, ур чадвараа үргэлж шинэчлэх шаардлагатай.

Багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг утга учиртай, тогтвортой байлгахад сургууль, сургалтын төв, их дээд сургуулиудын үүрэг оролцоо чухал байдаг. Мөн шинэ зуунд багшийн чадавхийг хөгжүүлэх нь хамтран хичээлийн судалгаа (lesson study)-г явуулах зэргээр сургуульд суурилсан суралцахуй (school based training) буюу ажлын байран дээрээ мэргэжлээ дээшлүүлэх нь рүү шилжиж, сургууль/анги мэргэжил дээшлүүлэх талбар болж байна.



Даалгавар 1. Багш нарт тулгарах бэрхшээлийг тодорхойлох

Сургалтын хөтөлбөр өөрчлөгдөнө гэдэг нь агуулгаас илүүтэй суралцахуйн арга зүй, стратеги, үнэлгээний арга зүйн өөрчлөлт болно. Иймд сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй, стратегийг хөтөлбөрт дэлгэрэнгүй зааж өгөхийн зэрэгцээ, түүний дизайн, загваруудыг санал болгосон байдаг. Хорин нэг дүгээр зууны тэдгээр ур чадвар/компетенцийг төлөвшүүлэх шинэ арга зүй нь багш нарын хувьд цоо шинэ зүйл байх болно. Энэхүү даалгавраар сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлтэй уялдуулан санал болгосон арга зүй, загвартай танилцаж шинээр орж ирсэн арга зүйн гол өөрчлөлт, өөрчлөлтөөс үүдэн багш нарын сурган хүмүүжүүлэх үйл явц, суралцахуйд тулгарах хамгийн гол бэрхшээлүүдийг тодорхойлно.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- Бусад орны багш нарт тохиолдсон кейс, бэрхшээл
- UNESCO, IBE. (2013). Training Tools for Curriculum Development A Resource Pack
- Сургалтын хөтөлбөрийг өөрчлөн шинэчилж хэрэгжүүлж ирсэн манай орны түүхэн сургамж



Даалгавар 2. Багшийн мэргэжил дээшлүүлэх арга замуудыг тодорхойлох

Өмнөх даалгавар 1-ийн бүтээгдэхүүнд суурилан багш нарын мэргэжил дээшлүүлэх арга замуудыг дэвшүүлнэ. “ЭЗХАБ-ын “Өндөр чанартай багшийн мэргэжлийг төлөвшүүлэх нь: дэлхийн өнцөг булан бүрээс авсан сургамж” илтгэлийг судлуулж гол арга замуудын тоймыг бэлтгэхээс гадна жишиг болох улсуудын туршлагыг судална. Орчин үед албан сургалт гэхээс илүүтэй сургуульд суурилсан, зайн сургалтаар мэргэжил дээшлүүлэх гэх мэт арга замууд үр дүнтэй, түгээмэл хэрэглэгдэж байна. Даалгавраар сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замуудыг санал болгоно.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- Capacity-building and knowledge management.
- Approaches to capacity-building: developing capacity for continuing teacher development in renewing curriculum.
- Schleicher, A. (2011). Building a High-Quality Teaching Profession: Lessons from around the World, OECD Publishing.
- Technologies for implementing open and distance learning with teachers.
- Сонгосон улс орнуудын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш нарыг бэлтгэсэн, мэрэгжил дээшлүүлсэн туршлага, арга замууд
- Zhou, N. Z., Shinohara, F. and Majumdar, S. 2005. Regional Guidelines on Teacher Development for Pedagogy– Technology Integration. Bangkok, UNESCO Asia and Pacific Regional Bureau for Education. <http://unesdoc.unesco.org/images/0014/001405/140577e.pdf> (Accessed 13 September 2013.)



Даалгавар 3. Багш нарт үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох

Энэхүү даалгавар шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарах бэрхшээл (бүтээгдэхүүн 1)-ийг зөөллөх буюу багш нарт шинээр ямар тодорхой дэмжлэг хэрэгтэй болох, түүнийг ямар ямар арга зам (бүтээгдэхүүн 2)-аар хэрэгжүүлэхийг тодорхойлно. Багшийн чанарыг дэмжих нь бага, дунд боловсролыг сайжруулах гол элемент гэдгийг ерөнхийд нь хүлээн зөвшөөрдөг. Үнэхээр ч “нэг ч хүүхдийг ардаа орхихгүй” сургалтын хөтөлбөрийн зорилтуудыг хангах “өндөр чадвартай багш”-тай болох нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн нэг гол зорилт юм.

Хэдийгээр олон арван жил судалгаа хийсэн ч ямар хүчин зүйл багшийн чанарыг сайжруулж, бүр дохио өгдөг талаар зөвшилцөлд хүрээгүй байна.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- Capacity-building and knowledge management.
- Approaches to capacity-building: developing capacity for continuing teacher development in renewing curriculum.
- Creating environments for effective teaching and learning: First results of TALIS (Part 1).
- The professional development of teachers (Chapter 3).
- Teacher professional development: an international review of literature (Chapter 4).
- Guidelines and recommendations for reorienting teacher education to address sustainability (UNESCO) (Section 3, pp. 17–28).
- Multigrade teaching: comparative situation in some developing countries Technologies for implementing open and distance learning with teachers.



Даалгавар 4. Багш нарын МХХТ-ийн чадавхийг дээшлүүлэх чиглэлийг тодорхойлох

МХХТ-ийн ач холбогдлыг хязгаарлах боломжгүй бөгөөд байнгын хувьсан өөрчлөгдөж үзэл баримтлал, арга, хэрэглээний динамик шинж чанартай байдаг. МХХТ нь өдөр

тутмын амьдралын бараг бүх салбарт нэвтэрч насан туршийн суралцахуй, насан туршийн боловсролын тэргүүлэх чиглэл болжээ. МХХТ-ийн гол зорилго нь нийгмийг улам боловсронгуй болгох, хувь хүмүүсийн бие даасан байдал, хараат бус байдлыг бий болгох явдал юм. МХХТ-ийн нөлөөнд автсан соёл нь нийгэмшүүлэх уламжлалт хэв маягийг өөрчилж, тодорхой хэмжээгээр солигдох орчинг бүрдүүлдэг. Өнөөгийн ертөнцөд МХХТ нь гэр, сургууль гэхээсээ илүү нийгэмшүүлэх хүчтэй хүч болж байна. Технологи нь бүх нийтийн ердийн хэрэгсэл биш харин ашиглалтын түүх, нийгэм, соёлын нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай үр дагавар бүхий хэрэгсэл болсон байна. Боловсролын салбарын аливаа үйл ажиллагаа эрчимтэй цахимжсаар байна. Энэхүү даалгавраар багш нарын МХХТ-ийн чадавхийг дээшлүүлэх чиглэлийг тодорхойлно.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- Approaches to capacity-building: developing capacity for continuing teacher
- development in renewing curriculum
- Technologies for implementing open and distance learning with teachers.
- ICT professional development for teacher educators, organisations, regions and countries.
- Multigrade teaching: comparative situation in some developing countries Technologies for implementing open and distance learning with teachers.



Даалгавар 5. Тодорхой сургалтын хөтөлбөрийн хүрээнд чадавхийг хөгжүүлэх боломжуудыг тодорхойлох

Үндэсний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарах бэрхшээл, тэдгээрийг даван туулах арга зам, дэмжлэгийг өөрийнхөө хариуцдаг судлагдахууны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрхэн бууж хэрэгжих боломжийг тодорхойлно. Иймд тодорхой судлагдахууны сургалтын хөтөлбөрийн сонгон авч, хамтдаа хэлэлцэнэ. Энэ нь өмнөх даалгавруудаар тодорхойлсон зарчим, чанар, арга зам нь сонгосон сургалтын хөтөлбөр, тухайн багшийн өөрийн нөхцөл байдалд хамааруулан авч үзэж байгаа хэрэг юм.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл



Бүтээгдэхүүн

1. Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш нарт тулгарах бэрхшээлийн жагсаалт
2. Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн мэргэжил дээшлүүлэх арга замуудын жагсаалт
3. Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш нарт үзүүлэх дэмжлэг, тухайн дэмжлэгийг хэрэгжүүлэх арга замуудыг харуулсан хүснэгт
4. Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш МХХТ-ийн чадавхийг дээшлүүлэх чиглэл
5. Тухайн судлагдахууны сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих арга барил, чадавхийг хөгжүүлэх боломжуудыг тодорхойлсон тайлан

Үйл ажиллагаа 2. Багшийн мэргэжил дээшлүүлэх загвар



Зорилго. Энэхүү үйл ажиллагаа болон санал болгож буй даалгаврууд нь багшийн мэргэжлийн хөгжлийн үзэл баримтлалыг гаргах, боломжит стратегиудыг судлах, өөр өөр улс оронд хэрэгжиж буй янз бүрийн загваруудыг танин мэдэж, тодорхой төрлийн загварыг сонгоход оролцогчдод дэмжлэг үзүүлэхэд оршино.



Боловсролын чанарыг сайжруулахын тулд сургалтын хөтөлбөрийг боловсруулах нь хангалтгүй, харин сургалтын хөтөлбөр, багшийн хөгжлийг сайжруулах нь боловсролын чанарыг сайжруулахад үр дүнтэй нөлөө үзүүлнэ. Иймд урт хугацааны багшийн мэргэжил дээшлүүлэх бодлого хэрэгтэй. Багш нар өөрсдөө хөгжлийнхөө идэвхтэй субъект гэж тодорхойлдог. Учир нь:

1. Багшлахуйн мэдлэг ухаан нь анги танхимд тохиох олон талт, давхцсан, ээдрээтэй үйл явцтай нүүр тулах, тэдгээрийг удирдан чиглүүлэхэд үнэ цэнэтэй, чухал ач холбогдолтой бөгөөд сургуульд үндэслэж, соёолдог нийгмийн үзэл баримтлалын үр жимс юм.
2. Уламжлалт чадавхийг хөгжүүлэх стратегиуд нь сургалтын стратегийг шинэчлэх, суралцагчдын олон талт байдлыг хангах, сургалтын чанарыг сайжруулах, мэдлэг, түгээмэл соёлыг ойлгох, боловсруулахад тус дөхөм үзүүлэх, ардчиллын үнэт зүйлийг сурталчлах, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх, хүмүүжүүлэх, сургуулиудын оролцоог дэмжих талаар тааруу үр дүнд хүрсэн.
3. Байгууллагын хувьсагч болон соёл нь багш нарын гүн гүнзгий практикт өөрчлөлт оруулах боломж эсвэл саад тотгор гэж үздэг.
4. Сургуулийн түвшний төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой хамтарсан баг дээр суурилсан сургуулийн зохион байгуулалтын шинэ загваруудыг бий болгох.

Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжилд хувь хүн болон жижиг бүлгүүдэд янз бүрийн стратеги ашиглаж болно. Гэвч ч мэргэжлийн ерөнхий хөгжлийн санаачлагын хувьд байгууллагууд янз бүрийн арга барилыг ашигладаг.

- Их дээд сургууль, багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулдаг, зайн болон нүүр тулсан сургалттай зуны сургууль эсвэл мэргэжил дээшлүүлэх курс;
- Янз бүрийн холбоодууд сайн туршлага, агуулгын талаарх мэдлэг, заах аргын шинэчлэлийн талаарх мэдээлэл солилцох зорилгоор сүлжээ үүсгэн байгуулдаг субъект буюу зохион байгуулттай мэргэжлийн бүлгүүд;
- Их, дээд сургууль, багш бэлтгэх институтууд олон төрлийн тасралтгүй үйл ажиллагааг дэмжих зорилгоор хамтран ажиллах гэрээ, харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан байгууллага хоорондын хамтын ажиллагааны бусад хэлбэрүүдийг ашигладаг. Жишээлбэл, мэргэжлийн хөгжлийн арга (жишээлбэл, үйл ажиллагаанд чиглэсэн судалгаа, мэдээлэл цуглуулах, заах практик, хяналт, үе тэнгийн суралцах);
- Байгууллага болон ТББ, багшийн үйлдвэрчний эвлэл, хувийн болон төрийн боловсролын түншүүд хоорондын түншлэлийн гэрээ, болон бусад
- Албан ба албан бус сургууль, багшийн сүлжээ.

Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах үйл ажиллагааг төлөвлөхдөө анхаарах зарим чухал асуудал:

- Сургалтын зохицуулалт, бодлого, багш нарын удирдлага, байршуулалт зэрэг боловсролын тогтолцооны хэд хэдэн хэмжигдэхүүнд нэгэн зэрэг хөндлөнгөөс оролцох. Үүнд: багшийг хариуцсан байгууллагуудын тоног төхөөрөмж, материал,

боловсон хүчин, сургалтын хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, багшийн ажиллах нөхцөл, урам зориг, мэргэжлийн байдал, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, багшийг мэргэжлээрээ хэвээр үлдээхэд түлхэц өгөх цалин хөлс.

- Багшийн мэргэжил дээшлүүлэлтийг багшлахуйн шинэлэг стратеги, нөөцийн хэрэгжилтийг хянах арга хэрэгсэл болгохоос зайлсхийх
- Үйл ажиллагаа явуулах сургагч багш, зөвлөхийн тоо. Сургуульд суурилсан мэргэжлийн хөгжил нь тодорхой тооны багшид олон тооны сургагч багшийг шаарддаг. Эдгээр хүний нөөцийг холбогдох байгууллагууд урьдчилан бэлтгэсэн байх, эсвэл их, дээд сургуулийн багш сурган хүмүүжүүлэгчдийг ажиллуулах, үүнд шаардагдах цаг хугацаа, зардлыг тооцох
- Санал, дэс дараалсан хичээлийн төлөвлөгөө бүхий материалууд нь ялангуяа албан ёсны мэргэжлийн сургалт багатай багш нарын хувьд туслах механизм болох нь дамжиггүй. Гэвч ч багш нарт ирээдүйд бие даан хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх, боловсролын зорилго, ангидаа хамгийн хэрэгтэй арга, нөөцийг сонгоход туслах үүднээс уг материалын үндэслэлийн талаар дэлгэрэнгүй тайлбарласан байх
- Захирлуудын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжих, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг анги танхимд бодитоор хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх байгууллагын нөхцөл байдал гэх мэт.



Даалгавар 1. Үр дүнтэй багшлах суралцахуйн орчинг бүрдүүлэх

Багш нар ихэвчлэн захирал, менежерүүдийн удирдлагад багшилдаг. Багш нарын ажлын амьдралын нөхцөл байдал нь захирлуудын зүгээс үзүүлж буй удирдлага, манлайллаас ихээхэн хамаардаг. Өөрөөр хэлбэл, сургуулийн удирдлага нь багш нарын үр ашиг, сурагчдын амжилтын үр дүнд шууд нөлөөлдөг гэж үздэг. Өөрчлөгдөж буй өнөөгийн ертөнцөд шаардлагатай мэдлэг, ур чадвар бүхий хүүхэд залуучуудыг бэлтгэхийн тулд сургуулийн удирдагчдын үүрэг, түүнтэй холбоотой хүлээлт эрс өөрчлөгдсөн. Сургуулийн үр дүнтэй манлайлал нь боловсролын томоохон шинэчлэл, боловсролын үр дүнг сайжруулахад чухал гэж үзэж байна. Энэхүү шинэ орчинд сургуульд улам хариуцлагатай үүрэг даалгавар оногдож, түүнийг төвлөрлийг сааруулах замаар сургуулийн бие даасан байдал, сургууль болон сурагчдын үр дүнгийн хариуцлагыг нэмэгдүүлэх, боловсрол, сурган хүмүүжүүлэх үйл явцын мэдлэг, чадварыг илүү сайн ашиглахтай уялдуулан хөгжиж байна. Шинэ орчинд “Доороос дээш” чиглэсэн бодлого, санал, үйлчилгээг дэмжиж байна. Сургуулийн орчин, багш нарын хичээлийн орчин, суралцах сургуулийн уур амьсгалын талаар TALIS-ийн материалд тусгаж өгсөн байгаа. Иймд даалгавраар сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд чухал нөлөөтэй үр дүнтэй багшлах суралцахуйн тэрхүү орчинг бүрдүүлэх арга замуудыг тодорхойлно.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- Бусад орны багш нарт тохиолдсон кейс, бэрхшээл
- OECD. Creating environments for effective teaching and learning: First results of TALIS” (Part I).
- Creating Effective Teaching and Learning Environments: First Results from TALIS – Leading to Learn: School Leadership and Management Styles



Даалгавар 2. Үр дүнтэй багшлах арга зүйг тодорхойлох

Одоо хэрэгжиж буй 2019 онд сайжруулсан сургалтын хөтөлбөрийн “Арга зүй” хэсэгт хангалтгүй цөөн тооны арга зүй стратегийг судлагдахуун бүр харилцан адилгүй зөвлөсөн байна. Жишээлбэл, суурь боловсролын сургалтын хөтөлбөрт “Асуудал шийдвэрлэх сургалтын загвар” (БУ, НУ), “Шинжлэн судлах арга” (БУ, НУ), “Тохиолдол шинжлэх арга” (НУ), “Мэдээлэл боловсруулах арга” (НУ), “Түүхийг тайлбарлан судлах арга” (НУ), даалгаварт суурилсан арга зүй (гадаад хэл, хими), Оролцооны арга (ЭМ) зэрэг аргыг санал болгожээ. Суралцахуйн тодорхой арга зүйг зөвлөөгүй сургалтын хөтөлбөр ч бас бий. Сургалтын хөтөлбөрт арга зүй, стратеги, арга, загвар гэх мэтчилэн өөр өөр нэр томъёог судлагдахуунууд хэрэглэсэн тул тэдгээрийг багш нар ялган тодорхойлж хэрэгжүүлэхэд бэрхшээл учрахаар байна. Энэ байдал нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд сөрөг нөлөөлж буй нэгэн хүчин зүйл юм. Иймд энэхүү даалгавраар шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд голлон хэрэглэх түгээмэл (судлагдахууны онцлогтой биш) арга зүй, загварыг нэрлэн тайлбарлана. Ингэхдээ өөрсдийн мэдлэг, туршлагыг ашиглахын зэрэгцээ гадаад орнуудын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй арга зүй, загварыг судална. Жишээлбэл, Япон улс шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн гурван арга зүй, загварыг санал болгосныг модулийн эхний буюу онол арга зүйн зөвлөмжийн бүлэгт өгүүлсэн билээ. Даалгавраар шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үр дүнтэй багшлах арга зүйг тодорхойлж, үндэслэлийг тайлбарлана.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- Бусад улс орны шинэ зууны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санал болгосон арга зүй, загвар
- 2019 оны үндэсний сургалтын хөтөлбөр
- Perrenoud, P. 2006. Dix nouvelles compétences pour enseigner : invitation au voyage [Ten new competencies to teach: start the journey]. 5th edn. Paris, ESF.
- Organisation for Economic Cooperation and Development (OECD). 2009. The professional development of teachers. Creating environments for effective teaching and learning: First results of TALIS. Paris, Organisation for Economic Cooperation and Development (OECD). <http://www.oecd.org/berlin/43541636.pdf> (Accessed 13 September 2013.)



Даалгавар 3. Сургуульд суурилсан багшийн хөгжлийн загварыг дэвшүүлэх (school-based professional development model)

Даалгавраар сургуульд суурилсан багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих арга замууд, загварыг санал болгоно. Манай орны боловсролын салбарт сүүлийн хэдэн арван жил сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотойгоор төвлөрсөн чиг баримжаатайгаар хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх аргыг түгээмэл ашигласаар иржээ. Энэ нь зуны сургалтаар цөөн хоногт сургалтын хөтөлбөрийг таниулах төдийгөөр багшийн хөгжлийг мэдлэг дамжуулахад үндэслэсэн арга хэлбэрээр явагдаж ирсэн гэсэн үг юм. Энэ загвар нь нэгэн төрлийн, богино хугацааны, олон нийтийн сургалт бөгөөд өөрчлөлтийг тасралтгүй дэмжих боломжтой дэмжлэгийг орхигдуулдаг талтай. Мөн хоёр, тав, арав

дахь жилийн багш нарын албан сургалт, бусад төрлийн олон сургалт, хурал, хэлэлцүүлэг байдаг ч сургуульд суурилсан багшийн тасралтгүй хөгжлийн загварыг бий болгож, тасралтгүй ажиллуулахад дорвитой дэмжиж чадаагүй байна. Багшийн ур чадварын уралдаан, илтгэл мэт ажлуудын сэдэв нь жил бүр зарлагддаг тул ганц удаагийн арга хэмжээнд зориулан багш нар ажиллах, шагналын төлөө ажиллах зэрэг сөрөг үр дагаврууд бүхий ажлууд болж хувирсаар байна. Жайка-тай хамтран 2006 оноос хэрэгжүүлсэн төслийн үр дүн болох сургуульд суурилсан мэргэжил дээшлүүлэх хамгийн үр дүнтэй загвар болох “Хичээлийн судалгааны арга зүй”-г үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх ажлууд хийгдэж байгаа ч төрийн дэмжлэг сул, өргөн хүрээг хамарч чадахгүй хэвээр байна. Гадаадын зарим улс орнууд багшийн Мэргэжлийн хөгжлийн бүлэг (Professional learning community)-г судлан хөгжүүлсэн нь үр дүнтэй байна. Судлаачид Мэргэжлийн хөгжлийн бүлэг гэдэг ойлголтыг “*хамтын оролцоо ба эргэцүүлэлд суурилсан, суралцахуй болон мэргэжлийн өсөлтийг дэмжсэн арга замаар өөрийн үйл ажиллагааг бүтээлчээр эргэцүүлэн эрэл хайгуул хийх бүлэг хүмүүс*”, “*бүх гишүүд нь шинэ ойлголт буюу тулгамдсан тухайн нэг асуудалд төвлөрч, шийдлийг хамтдаа эрэлхийлж, нээлттэй хэлэлцэж, шийдэлд хүрэх арга замыг боловсруулж, хүрэх үр дүнг төсөөлөн харилцан бие биеэ дэмжин ажилласны эцэст практик үр дүнд хүрдэг өндөр хариуцлагатай бүлэг*” гэх мэтчилэн тодорхойлж байна.

Багшийн хөгжих орчныг тухайн багш ажиллаж буй сургалтын байгууллага гэж үзэх бөгөөд тэдэнд ажлын байрандаа хамт олноороо тасралтгүй хөгжих шинэ арга хэлбэрийг санал болгох нь чухлаар тавигдаж байна. Сургуульд суурилсан мэргэжлийн хөгжлийн загвар нь багш нарын өдөр тутмын сургалтын үйл ажиллагааны явцад практик мэдлэгийг олж авах, түүнийгээ баталгаажуулахыг чухалчилдаг. Энэ загвар нь орон нутаг, сургуульд суурилсан бөгөөд багш нарын удирдаж буй тодорхой нөхцөл байдал, сургалтын бодит асуудал, өдөр тутмын практик, тодорхой нөөцийг харгалзан явагдаж, практикт тодорхойлсон асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдлэгийг хөгжүүлэхэд нь тусалдаг давуу талтай. Энэхүү зорилтыг хэрэгжүүлснээр багш нар боловсролын онол, судалгаанаас хуримтлуулсан шинжээчдийн мэдлэгтэй ч болох боломжтой. Үүний тулд сургагч багш нарыг боловсролын асуудлыг тодорхойлох, ангилах, түүнчлэн тэдгээрийг шийдвэрлэх стратеги боловсруулахад нь туслах зорилгоор багш нартай хамтран зөвлөхөөр ажиллуулдаг. Модуль боловсруулахдаа ЮНЕСКО, байгууллагын материалын 129 талд Мэргэжлийн хөгжлийн арга зүйг жишээлэн өгсөн (Villegas, E. R. (2003).) Хүснэгт 6.2-тай танилцана уу.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- Бусад улс орны сургуульд суурилсан багшийн хөгжлийн арга зүй, загвар
- Манай орны сургуульд суурилсан багш нарын хөгжлийн үр дүнтэй ажлын туршлага (төрийн ба төрийн бус байгууллага, нийгэмлэгүүдийн явуулж буй ажил)
- Ментор багш нарын туршлага
- UNESCO, IBE. (2013). Training Tools for Curriculum Development A Resource Pack
- Schleicher, A. 2011. Building a high-quality teaching profession: lessons from around the world. Organisation for Economic Cooperation and Development (OECD). (Document presented at the International Summit on the Teaching Profession, New York, 16 and 17 March 2011.)
- Vezub, L. F. 2010. El desarrollo profesional docente centrado en la escuela: concepciones, políticas y experiencias [School-based teacher professional development:

Ideologies, policies and experiences]. Buenos Aires, UNESCO International Institute for Educational Planning (IIEP). (In Spanish).



Даалгавар 4. Багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд нөлөөлдөг хүчин зүйлсийг тодорхойлох

Энэ даалгавраар багшийн мэргэжил дээшлүүлэх санаачлагыг амжилттай хэрэгжүүлэх нийтлэг хүчин зүйлсийг дэвшүүлнэ. Энэ үйл ажиллагаанд нөлөөлөх олон хүчин зүйлс байгаа нь тодорхой. Жишээлбэл, тогтвортой, эрчимтэй олон төрлийн үйл ажиллагаа; зардал; сургуулийн сургалтын хөтөлбөртэй уялдуулах багшийн туршлага; үйл явц ба хүргэх тогтолцоо; багш, удирдлагууд сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд нухацтай хандаж тодорхойлсон үйл ажиллагаа нь орон нутгийн хэрэгцээ, сорилт, шийдлийг хүлээн зөвшөөрсөн байдал; орон нутгийн түвшний манлайлал; бодлого ба багшийн хэрэгцээ; сайн, урт хугацааны төлөвлөлт; хяналт-шинжилгээ, үнэлгээний байгууллагын бүтэц; дадлага хийх цаг хугацаа ба дагаж мөрдөх байдал, байнгын хяналт, дэмжлэг; багшийн чадавхийн түвшин; ажил мэргэжлийн өгсөх шат; эцэг эхчүүдийн байнгын дэмжлэг зэрэг.

Багшийн мэргэжлийг үр дүнтэй хөгжүүлэх нь хэд хэдэн шинж чанартай: Үүнд:

Багшийн карьерын туршид үргэлжилдэг байнгын дэмжлэг; мэргэжлийн соёлын улбаатай; хамтын оролцоо; сургуульд суурилсан, хамтын ажиллагаатай байх; туршлага, эргэцүүлэн бодох, дагаж мөрдөх хангалттай хугацаа; суралцагчид болон багш нар, түүнчлэн багш нарын хооронд харилцах хангалттай боломж; багш нарыг идэвхтэй, насанд хүрсэн суралцагч гэж хүлээн зөвшөөрөх; хуучин болон шинэ туршлагын талаар багшийн эргэцүүлэн бодох боломж; тодорхойлсон чухал хэрэгцээ болон сургалтын хөтөлбөрийн зорилгууд дээр анхаарлаа төвлөрүүлэх; конструктивист сургалтын арга барил; гүйцэтгэлээр мэдлэг, туршлага, хандлага, ур чадвар дээшилдэг; сургалтын стратеги, суралцагчийн танхимын дадлагыг сайжруулах, суралцах үйл явцыг хөнгөвчлөхөд чиглэсэн сурагчийн сурах, сэтгэхүйд илүү их анхаарал хандуулах; үндэсний болон сургуулийн бодлогын хүрээнд үзэл баримтлал; сургуулийн түвшинд болон гадны бүлэг, агентлагуудад манлайллын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх; багшийн мэргэжил дээшлүүлэх хувь хүний хэрэгцээ, итгэл үнэмшлийг нэгтгэх; багш нарын өмнөх суралцаж байсан туршлагыг хүлээн зөвшөөрөх; бүх нийтийн үйлчилгээний нөхцөл болох бие биенийхээ мэргэжил дээшлүүлэх байдал зэрэг.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- Бусад улс орны багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд нөлөөлөх нийтлэг хүчин зүйлс
- UNESCO, IBE. (2013). Training Tools for Curriculum Development A Resource Pack
- Organisation for Economic Cooperation and Development (OECD). 2009. The professional development of teachers. Creating environments for effective teaching and learning: First results of TALIS. Paris, Organisation for Economic Cooperation and Development (OECD). <http://www.oecd.org/berlin/43541636.pdf> (Accessed 13 September 2013.)
- Douglas N. Harris, Tim R. Sass., 2007. Teacher training, Teacher quality and Student Achievement. Calder. Urvan Institute.



Даалгавар 5. Багшийн мэргэжлийн хөгжлийг вэб (online эх сурвалж)-д суурилан дэмжих

Веб хуудас (цахим хуудас) гэдэг нь HTML (Hypertext Markup Language) тэмдэглэгээт хэл (скрипт хэл) ашиглан үүсгэгдсэн, текст, зураг болон бусад график, видео дүрс, дуу авиа агуулсан баримт юм. HTML нь дэлхийн вэб хуудсанд үсгийн фонто, өнгө, график, холбоосын нөлөө үзүүлэхийн тулд текст файлуудыг шошголох стандарт систем юм. Харин тодорхой нэг домэйн нэр, интернэтэд байршсан хост, сэдэв, дизайн загвар, мэдээллийн сан болон холбоосуудаар (линк) өөр хоорондоо холбогдсон вэб хуудсуудын нэгдлийг вэб сайт (Website) гэдэг. Вэб-ийг хувь хүн эсвэл байгууллагын интернэт дэх төлөөлөгч гэж ойлгож болно. Өнөөдөр багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих маш олон веб хуудас, сайт ажиллаж байна. Тэдгээр нь мэдээллийн хэмжээ, бүтэц, хэрэглэгчдэд хүрч байгаа байдал, зорилгоор ялгаатай байдаг. Энэ даалгаврын зорилго нь өөрчлөн/шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшид шаардагдах болсон тэрхүү шинэ мэдлэг, ур чадвар, хандлагыг хэрхэн Вэб-ээр дамжуулан дэмжих хөтөлбөрт зорилго, агуулга, арга зүй, үнэлгээ зэргийг тусгах боломжийг тодорхойлоход чиглэнэ.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- Бусад улс орны вэбэд суурилсан багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн сургалтын хөтөлбөр, туршлага, жишээ нь “Web-based learning program to support professional development in China”
- Al-Sarraf, Q. 2005. The experience of educational reform in Kuwait. Reform of General Education in the Arab Countries. A. El Amine (ed.), Beirut, UNESCO Office in Beirut – Regional Bureau for Education in the Arab States, pp. 123–44. <http://unesdoc.unesco.org/images/0014/001407/140702mb.pdf> (Accessed 13 September 2013.)
- UNESCO, IBE. (2013). Training Tools for Curriculum Development A Resource Pack
- Al-Jarf, R. 2006. Teachers' online discussion forums in Saudi Arabia. I-Manager's Journal of Educational Technology, July 2006.
- UNESCO. 2002. Las tecnologías de la información y la comunicación en la formación docente: Guía de planificación [Information and communication technologies in teacher education: a planning guide]. P. Resta (ed.), Paris, UNESCO. (In Spanish.) <http://unesdoc.unesco.org/images/0012/001295/129533e.pdf> (Accessed 13 September 2013.)
- UNESCO. 2002. Teacher education guidelines: using open and distance learning. Technology – Curriculum Cost – Evaluation. R. Kvaternik (ed.), Paris, UNESCO. g. Technology – Curriculum <http://unesdoc.unesco.org/images/0012/001253/125396e.pdf> (Accessed 13 September 2013.)
- UNESCO. 2006. HIV and AIDS education: teacher training and teaching. A Web-based desk study of 10 African countries. Paris, UNESCO. <http://unesdoc.unesco.org/images/0014/001436/143607E.pdf> (Accessed 13 September 2013.)



Даалгавар 6. Тогтвортой хөгжлийн төлөөх багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих

Шинэ зууны дэлхий ертөнцийн өнгө төрх, зөрчилдөөн тэмцэл зэрэг нийгэм түүхийн бодит байдалтай холбоотойгоор монгол иргэний болон дэлхий иргэншлийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, тэгш хамруулан сургах боловсрол, ХДХВ, ДОХ-ын боловсрол зэрэг боловсролын олон чиглэлүүд, тэдгээрийн интеграцийн асуудал чухлаар дэвшигдэж байна. Үүнтэй холбоотойгоор тогтвортой хөгжлийн төлөөх багшийн боловсрол, хөгжлийг дэмжих шаардлага улам бүр хүчтэй тавигдах боллоо. Тухайлбал, соёлын олон талт байдал ба түүнийг хүлээн зөвшөөрөх; боловсролд жендерийн тэгш байдлыг хангах; хүний эрхийн боловсрол; энх тайван ба үл хүчирхийлэл; уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол; хүрээлэн буй орчны тогтвортой байдал; хүн төрөлхтний сайн сайхан байдал, амьд үлдэх; тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл зэрэг агуулга, сэдвүүд аливаа судлагдахуунд чухал байр суурийг эзлэх болжээ. Иймд тогтвортой хөгжлийн төлөөх чиглэлээр багшийн хөгжлийг дэмжих арга замуудыг дэвшүүлэх нь энэ даалгаврын зорилго юм.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- Бусад улс орны туршлага
- “Guidelines and recommendations for reorienting teacher education to address sustainability (UNESCO)” (Section 3, pp. 17–28)
- UNESCO, IBE. (2013). Training Tools for Curriculum Development A Resource Pack
- Berry, C. 2000. Multigrade teaching: comparative situation in some developing countries. Institute of Education, University of London. (Document presented at the Commonwealth Secretariat Regional workshop on multigrade teaching, Gaborone, 19–21 July 2000.) <http://www.ioe.ac.uk/multigrade/fulltext/fulltextBerry.pdf> (Accessed 13 September 2013.)
- Sinclair, M. et al. 2008. Learning to Live Together: Design, Monitoring and Evaluation of Education for Life Skills, Citizenship, Peace and Human Rights. Eschborn, Germany, German Agency for Technical Cooperation (GTZ) <http://tandis.odihp.pl/documents/hre-compendium/rus/CD%20SECT%205%20EVAL/PR%20SEC%205/UNESCO%20Learning%20to%20Live%20Together.pdf> (Accessed 13 September 2013.)
- UNIT WIN, UNESCO and the International Network of Teacher Education Institutions. 2005. Guidelines and recommendations for reorienting teacher education to address sustainability. Paris, UNESCO. (Technical paper No. 2.) <http://unesdoc.unesco.org/images/0014/001433/143370E.pdf> (Accessed 13 September 2013.)



Даалгавар 7. Өвөрмөц стратеги шаарддаг нөхцөл байдал дахь багшийн чадавхийг хөгжүүлэх

Өвөрмөц стратеги шаарддаг нөхцөл байдал гэдэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, цагаач иргэдийн, олонхийн хэлээр ярьдаггүй хүүхдүүд, дайны улмаас дүрвэсэн хүүхдүүд төдийгүй авьяаслаг, онцгой чадвартай зэрэг тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ажиллах арга барил орно. Даалгавраар манай орны нөхцөл байдалд ямар тусгай хэрэгцээт хүүхдүүд

байгаа, цаашид бий болж болзошгүй талаар мэдээлэл бий болгож, улмаар багш, захирал, төдийгүй эцэг эхийн чадавхийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлно.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- Манай оронд энэ чиглэлээр хэрэгжүүлж буй төслийн тайлан, жишээлбэл, Жайкагийн төсөл
- Энэ чиглэлийн сургууль багш нарын туршлага
- Бусад улс орны өвөрмөц стратеги шаарддаг нөхцөл байдлын чиглэлээр багш нарыг хөгжүүлж буй туршлага
- UNESCO, IBE. (2013). Training Tools for Curriculum Development A Resource Pack



Бүтээгдэхүүн

1. Багшийн мэргэжил дээшлүүлэх үзэл баримтлал, үр дүнтэй багшлах суралцахуйн орчны дүр зураг
2. Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй, загварын жагсаалт, товч тайлбарын хамт
3. Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн сургуульд суурилсан багшийн хөгжлийн загварууд, товч тайлбар
4. Өөрийн нөхцөл байдалд багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, хэрэгжүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нэр, тэдгээрийн эрэмбэ.
5. Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих вэбэд суурилсан сургалтын хөтөлбөрийн бүтэц, элементүүд
6. Тогтвортой хөгжлийн төлөөх багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих арга замууд
7. Манай орны өвөрмөц стратеги шаарддаг нөхцөл байдал, багш, эцэг эхчүүдийн эрэлт шаардлага нарын чадавхийг хөгжүүлэх

Үйл ажиллагаа 3. Чадавхийг хөгжүүлэх шаардлагатай бусад оролцогчид



Зорилго. Энэхүү үйл ажиллагаа болон санал болгож буй даалгаврууд нь оролцогчид сургалтын хөтөлбөр, боловсролын мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг техникийн түвшинд судалж багш бэлтгэх, тэдний мэргэжлийн үүрэг, хүлээлт хоёрын хооронд байгаа чадавхийн зөрүүг тодорхой ойлгох, багш бэлтгэх боловсролыг ажил мэргэжлийн өсөлттэй нягт уялдуулах боломжит арга замыг судлахад оршино.

Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг ерөнхий утгаар нь чадавхийг хөгжүүлэх замаар шийдвэрлэх шаардлагатай мэргэжлийн багуудын гүйцэтгэдэг нарийн төвөгтэй үйл явц гэж ойлгодог. Шинэчлэлийн үйл явцад оролцож буй сурган хүмүүжүүлэх болон улс төрийн олон асуудал нь сургалтын хөтөлбөрийн үр дүнтэй мэргэжилтнүүдийг бэлтгэдэг сургалтын тасралтгүй мөчлөгийн хүрээнд тодорхой хэрэгцээ гарсан үед хөгжүүлэх эсвэл нэвтрүүлэх шаардлагатай тодорхой ур чадварын багцыг бий болгохыг шаарддаг. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явцыг эхлүүлэхийн өмнө эзэмших эдгээр бүх ур чадваруудын хувьд шийдвэрлэх шаардлагатай асуудал байгаа эсэхийг тодорхойлох чадавхийн хэрэгцээний урьдчилсан үнэлгээ хийлгүйгээр сургалтын хөтөлбөрийг



шинэчлэх үйл явцыг хугацаанаас нь өмнө эхлүүлэх эрсдэлтэй. Сургалтын хөтөлбөр боловсруулагчдын ур чадварын түвшинг дээшлүүлэхэд шаардагдах цаг хугацаа, нөөцийг шинэчлэлийн урьдчилсан нөхцөл болгон авч үзэх шаардлагатай байж магадгүй юм.

Олон тооны хөтөлбөр боловсруулагчид зөвхөн нэг сургалтын хөтөлбөрийн хүрээнд, голчлон тодорхой агуулга, заах арга зүйн талаар бэлтгэгдсэн байдаг бөгөөд тухайн судлагдахууны өнөөгийн чиг хандлагын талаар харьцангуй мэдлэгтэй байгаа. Гэвч баримт бичиг, ном, кейс хэд хэдэн хэлбэр, хэлээр байгаа нь олон улсын чиг хандлага, энэ чиглэлээр одоо байгаа судалгааг судалж, дүн шинжилгээ хийх өргөн боломжийг хөтөлбөр боловсруулагчдад олгож байна. Тэдгээр боломж нь сургалтын хөтөлбөрийн мэргэжилтнүүдэд МХХТ-ийг ашиглах, орчуулгын үйлчилгээнд хамрагдах эсвэл гадаад хэлний чадвараа сайжруулах боломжийг олгодог. Сургалтын хөтөлбөрийн бүтээгдэхүүнийг бүх оролцогч талууд сайн ойлгохын тулд тодорхой, бүтээлч бичгийн болон аман харилцааны ур чадварыг хөгжүүлэхэд анхааралтай хандах хэрэгтэй.

Сургалтын хөтөлбөр боловсруулах, турших, үнэлэх, хэрэгжүүлэх үйл явц нь ихэвчлэн төлөвлөлт, хэлэлцээр хийх ур чадвар шаарддаг тул хөтөлбөр боловсруулагчдаас гадна хэд хэдэн мэргэжлийн хүмүүсийг оролцуулснаар сургалтын ажлын хэсэг үр дүнтэй ажиллана. Эдгээр чиглэлээр ахисан түвшний чадвартай сургалтын хөтөлбөр боловсруулагчдыг ажиллуулах, ажилд авах нь бэрхшээлтэй хэцүү байдаг. Гэвч гадны зөвлөхүүдэд хэт их найдах нь одоо байгаа мэргэжлийн багуудын чадавхийг хөгжүүлэх үйл явцад сөргөөр нөлөөлж болзошгүй тал бий. Тиймээс үндсэн багийг бүрдүүлдэг сургалтын хөтөлбөр боловсруулагчдад зориулсан чадавхийг хөгжүүлэх үйл ажиллагааг багтаасан зөвлөх боломжуудыг тодорхойлох нь зүйтэй.

Бодлого боловсруулагчдад сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үйл явцыг зохион бүтээх, удирдах тусгай сургалт шаардлагатай байна. Тодруулбал, сургалтын хөтөлбөрийн үйл явц нь нийтлэг ойлголтод үндэслэсэн байх шаардлагатай тул сурталчлан таниулах ур чадвар зайлшгүй шаардлагатай юм. Бодлого боловсруулагчид шийдвэр гаргах үйл явцад ур чадвартай, тодорхой зорилго тавьж чаддаг, түүнийг хэрэгжүүлэхээс өмнө бүтээгдэхүүн, үйл явцын улс төрийн үнэлгээг хэрхэн хийх талаар мэддэг байх үүрэгтэй. Мөн сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд уулзалт, фокус групп, хэлэлцүүлэг, мэтгэлцээн зохион байгуулах чадвартай, практик ур чадвартай хүмүүс шаардлагатай. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, туршилтын чиглүүлгийн явцад сургууль, багш нарт техникийн дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөхүүдийн чадварыг хөгжүүлэх зэрэг орно.



Даалгавар 1. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд оролцох мэргэжилтэнд шаардагдах мэдлэг, ур чадварыг тодорхойлох

Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлийн үйл явцад оролцогч талуудын тухай өмнөх модулиудад авч үзсэн байгаа. Энэ даалгавраар тэдгээр оролцогчдын чадавхийг хөгжүүлэх хэрэгцээг судална. Үүний тулд сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлд оролцоход зайлшгүй шаардагдах мэргэжилтэн бүрийн мэдлэг, ур чадваруудыг тодорхойлж гаргана. Жишээлбэл, яамны бодлого боловсруулагч, хөтөлбөрийн зөвлөлийн гишүүн, хөтөлбөр боловсруулагч, менторууд гэх мэт.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- 21 дүгээр зууны сургалтын хөтөлбөр боловсруулагчдын ур чадвартай холбоотой бусад улс орны хуримтлуулсан туршлага
- Энэ чиглэлээр манай оронд хийгдсэн судалгааны тайлан



Даалгавар 2. Сургалтын хөтөлбөрийг шинэчлэлд оролцох мэргэжилтнүүдэд шинээр шаардагдах мэдлэг, ур чадварыг тодорхойлох

Даалгавар 1-ийн бүтээгдэхүүнд суурилан сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлд оролцох мэргэжилтнүүдэд одоо байгаа эсвэл байсан мэдлэг, ур чадвар, мөн энэхүү сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлээр шинээр шаардагдах буюу дутагдах мэдлэг, ур чадваруудыг салган ялгаж тогтооно.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- 21 дүгээр зууны сургалтын хөтөлбөр боловсруулагчдын мэдлэг, ур чадвартай холбоотой бусад улс орны кейс
- Энэ чиглэлээр манай оронд хийгдсэн судалгааны тайлан



Даалгавар 3. Сургалтын хөтөлбөрийг шинэчлэлд оролцох мэргэжилтнүүдийн чадавхийг хөгжүүлэх

Даалгавар 2-ийн бүтээгдэхүүнд суурилан сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлд оролцох мэргэжилтнүүдийн чадавхийг хөгжүүлэх хамгийн үр өгөөжтэй арга хэмжээнүүдийн жагсаалтыг гаргана. Тодорхойлсон мэдлэг, ур чадваруудыг эхний бэлтгэлийн жилд гэх мэтээр хэрэгжүүлэх хугацаагаар нь зэрэглэхээс гадна хамгийн чухал, нэн тэргүүнд эзэмших гэдгээр нь эрэмбэлнэ.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- 21 дүгээр зууны сургалтын хөтөлбөр боловсруулагчдын мэдлэг, ур чадварыг хөгжүүлж буй бусад улс орны арга хэмжээ, кейс, төлөвлөгөө гэх мэт

Бүтээгдэхүүн

1. Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлд оролцоход зайлшгүй шаардагдах мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадваруудын жагсаалт
2. Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлд оролцоход мэргэжилтнүүдийн шинээр шаардагдах мэдлэг, ур чадваруудын жагсаалт
3. Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлд оролцоход мэргэжилтнүүдийг чадавхжуулах арга хэмжээний жагсаалт, эрэмбэ

Үйл ажиллагаа 4. Чадавхийг хөгжүүлэхэд багш бэлтгэх болон давтан сургах боломж



Зорилго. Энэхүү үйл ажиллагаа болон санал болгож буй даалгаврууд нь оролцогчдод багш бэлтгэх, тэдний мэргэжлийн үүрэг, хүлээлт хоёрын хооронд байгаа ялгааг сайтар ойлгох, багш бэлтгэх боловсролыг хувийн карьерын хөгжилд илүү нийцүүлэх боломжит арга замыг тодорхойлоход туслахад оршино.



Багш нар бол боловсролын өөрчлөлт/шинэчлэлд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдний оролцоо нь дараах гурван хүчин зүйлээс хамаардаг.

Үүнд:

- Сургалт;
- Ажиллах, амьдрах нөхцөл болон бусад
- Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх.

Сүүлийн хоёр хүчин зүйл нь сургалтын хөтөлбөрийн шийдвэрийн хамрах хүрээнээс гадуур байдаг ч чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулахдаа тэдгээрийг анхаарч үзэх шаардлагатай.

Зөвхөн мэдээлэл давтах, сургалтын нэгдсэн арга техникийг эзэмших, нэг хэлээр ажиллах зэргээс бүрдсэн багшийн сургалт хязгаарлагдмал юм. Мэргэжлийн шинэчлэл нь боловсролын чанар, ач холбогдлыг дээшлүүлэх хурдасгуур байхын тулд бүх багш нар боловсролын инновацийн төлөөлөгч болох өөрийгөө танин мэдэхүйн мэдээлэлтэй, системтэй үйл явц байх ёстой.

Энэ үйл явцыг хөнгөвчлөхийн тулд багш нарыг практик нөхцөлд нь дэмжих бөгөөд ингэснээр тэд суралцахуйг өөрсдийн нөхцөл байдалд нийцүүлэн, илүү өргөн зарчим, мэдлэг, сэдвийн хүрээнд харилцан ярилцаж, орон нутгийн соёл, бүх нийтийн мэдлэгийг тэнцвэржүүлэх боломжтой болно.

Багшийн сургалт нь боловсролын талаарх хүртээмжтэй хэтийн төлөв, технологид суурилсан сургалтын практикийг байнга өөрчлөх зэрэг шинэ, олон янзын сорилтод анхаарлаа хандуулах шаардлагатай.



Даалгавар 1. Багш бэлтгэхэд ашиглах арга замуудыг тодорхойлох

Багш бэлтгэх, тасралтгүй мэргэжил дээшлүүлэхэд талаар олон арга барилуудыг нэвтрүүлсэн байдаг. Тухайлбал:

- **Мэргэжил дээшлүүлэх сургууль:** Энэхүү загвар нь менторын удирдлаган дор практик сургалтыг чухалчилдаг. Үүнд багш бэлтгэдэг их дээд сургууль/коллежийн багш нар, удирдлагууд болон гишүүдийн хамтын ажиллагааны зохион байгуулалтын бүтэц орно.
- **Багшийн мэргэжлийн ур чадвар:** Энэхүү загвар нь багш бэлтгэгчдэд хичээлийн мэдлэг, мэргэжлийн ноу-хау, заах ур чадвар, суралцагчийн сэтгэл зүйн талаарх ойлголт өгөхөд чиглэгддэг.
- **Хувь хүний өсөлт хөгжил:** Энэ загвар нь ирээдүйн багш нар өөрсдийнхөө талаар илүү их ойлголттой (өөрийгөө ойлгох) байвал илүү үр дүнтэй, сайн багш болж чадна гэдгийг онцолж багш нарыг илүү эргэцүүлэн бодох, мэдрэмжтэй болгодог чанаруудыг хөгжүүлэхэд чиглэгддэг.

- **Мэргэжлийн соёл болгон нийгэмшүүлэх:** Энэхүү загвар нь ирээдүйн багшийн итгэл үнэмшил, үзэл санаа, үйл ажиллагаа, үнэт зүйлд сургуулийн соёл, бодлого нөлөөллийг онцолж өгдөг.
- **Техникийн мэдлэг, ур чадвар:** Сургалтын үйл явцыг дэмжихийн тулд багшид дадлагажигчид заах арга зүй, хичээлийн хичээл зэрэг олон төрлийн чиглэлээр мэдлэг, ур чадвар эзэмших шаардлагатай (анги удирдах, сургалтын технологи, хүүхдийн сурах үйл явц, үр дүнтэй суралцах стратеги зэрэг).
- **Багшлах нь ёс суртахууны хүчин чармайлт:** Энэ загварын дагуу багш нар анги болон сургуулийн хамт олны удирдагчид гэж тооцогддог. Мэргэжлийн ёс суртахууны хяналтан дээр суурилсан сургуулийн сургаал, манлайллыг чухалчилдаг.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- 21 дүгээр зууны багш бэлтгэж буй бусад улс орны кейс, туршлага гэх мэт
- “Teacher education guidelines: using open and distance learning” баримт бичиг



Даалгавар 2. Багш бэлтгэх боломжит арга замуудыг ашиглах боломжийг судлах

Даалгавар 1-т тодорхойлсон арга зам, загваруудаас манай орны нөхцөл байдалд тохирохыг сонгоно. Тэдгээр сонгосон арга замууд нь манайд багшийг үр дүнтэй бэлтгэхэд хэр зэрэг ашиглагдаж ирсэн байдлыг судална. Урд өмнө манай оронд багш бэлтгэхэд ашиглаж байгаагүй загваруудад гол анхаарлаа хандуулна. Тэрхүү арга зам, загварыг манай орны нөхцөлд хэрэгжүүлэхэд гарах улс төр, эдийн засаг, сургалтын хөтөлбөр, практик үр дагавар юу байгааг тогтоож, дүгнэлт гаргана.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- 21 дүгээр зууны багш бэлтгэж буй бусад улс орны кейс, туршлага гэх мэт
- “Teacher education guidelines: using open and distance learning” баримт бичиг



Даалгавар 3. Багш бэлтгэх сургалтад нэвтрүүлж болох стратегиудыг тодорхойлох.

Багш нарын мэдлэг, чадвар, хандлагын түвшин нь сургуулийн сургалтын хөтөлбөрийг хэр амжилттай хэрэгжүүлэх, эцсийн дүндээ зорьсон зорилгодоо хүрэхэд ихээхэн нөлөөлдөг. Багш нар боловсролын салбарт шинэчлэлийг илүү сайн хэрэгжүүлэхийн тулд мэдлэг, ур чадвараа тасралтгүй шинэчилж, сайжруулна. Үүнийг дэмжих бүтэц манай улсад тодорхой хэмжээгээр бий болсоор байгаа ч гэсэн тэдний үйл ажиллагаанд дэмжлэг дутаж хүндрэл бэрхшээл байсаар байна. Боломж:

- Багш нарын холбоо/нийгэмлэг: Сургалтын хөтөлбөртэй холбоотой асуудлууд, мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн талаар мэдээлэл өгдөг тул багш нарт мэдлэгийн сайн эх сурвалж болдог.
- Зайны боловсрол/нээлттэй сургалт/уламжлалт сургалтын хувилбарууд/уян хатан сургалт/насанд хүрэгчдийн боловсрол: Алсын зайн боловсролын хөтөлбөрүүд нь уламжлалт нүүр тулсан харилцааны бүрэлдэхүүн хэсэгтэй хэрэгжиж байгаа нь багш

бэлтгэх хоёр хэлбэрийг ялгахад хүндрэл учруулж байгаа ч багш нар энэ аргыг ашиглан мэдлэг, ур чадвар, мэргэшлээ шинэчлэх бүрэн боломжтой.

- Уламжлалт нүүр тулсан боловсрол (Traditional face-to-face education): Энэ арга нь байгууллагууд мэдлэг, мэдээллээ дамжуулах, багш нарт санал, ур чадвараа хуваалцах боломжийг олгодог.
- Нэг талын болон хоёр талын холбоо харилцааны технологи (One-way and two-way communication technologies): Энэ технологийн олон арга хэлбэрийг ЮНЕСКО ба ИББ (IBE) байгууллагын сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх нөөц материалын 139-140-р талаас үзнэ үү.

Энэхүү даалгавраар багш бэлтгэх сургалтад шинээр нэвтрүүлж болох стратегиүдийг тодорхойлно.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- 21 дүгээр зууны багш бэлтгэх буй бусад улс орны кейс, туршлага гэх мэт
- “Teacher education guidelines: using open and distance learning” баримт бичиг
- UNESCO, IBE. (2013). Training Tools for Curriculum Development A Resource Pack



Даалгавар 3. Шинэ зууны багшийн эрхэмлэх үнэт зүйлсийг тодорхойлох

Багшийн хандлага, төлөвшил, үнэт зүйл, үнэлэмж, зөөлөн ур чадвар багшлахад чухал. Эдийн засгийн өсөлт нь хөгжил дэвшлийг жинхэнэ утгаар бий болгогч үндсэн хүчин зүйл биш гэдгийг 20 дугаар зууны сүүлчээр хүлээн зөвшөөрсөн (тэгш бус байдал, шударга бус байдал, баялгийн тэгш бус хуваарилалт зэрэг хөгжлийн хүчин зүйлсийн хоцрогдол, завхрал). Шинэ зуунд хүний хөгжил гэдгийн дор эрүүл биетэй, эрдэм боловсролтой, орлого олох чадвартай, ёс суртахуунтай, өв соёл, үнэт зүйлсээ дээдэлдэг иргэнийг бий болгохыг авч үздэг болсон. Үнэт зүйл нь даяаршиж буй дэлхий ертөнцөд дангаарчлалыг бий болгоход чухал үүрэгтэй. Үнэт зүйл бол:

- Нийгмийн оюун санааны нэгдмэл байдлыг хангаж, чиглүүлж байдаг гол хүчин зүйл
- Хүний мэдрэмж, хэрэгцээнд тулгуурласан амьдралыг чиглүүлэх, идэвхжүүлэх, утга төгөлдөр болгож хөтлөх хүч
- “Зүрх сэтгэл”, “дотоод ертөнц”-ийг хөгжүүлэх тухай асуудал бөгөөд хүний дотоод зүрх сэтгэлээс бий болдог
- Үзэл бодол, итгэл үнэмшилд тогтвортой орших оюун санааны хүч юм. Үнэт зүйл нь юуг чухалчилж, хүсч буйн талаарх бат итгэл үнэмшилийг илэрхийлнэ.
- Хувь хүний тэмүүлж буй зорилго, өөрийгөө сайжруулах сэдлийн эх үүсвэр

Үнэт зүйлийн хэрэгжилтэд хэм хэмжээ, дүрэм гэсэн ойлголт чухал үүрэгтэй. Хүмүүний гүйцэтгэх үйлд үнэт зүйл бол ерөнхий, хэм хэмжээ (норм) нь тодорхой зохицуулалтын үүрэг гүйцэтгэдэг. Үнэт зүйл, хэм хэмжээ нь хоёулаа шийдвэр гаргах үйл явцад чиг баримжаа болдог. Хэм хэмжээ бүрд түүгээр дамжин хэрэгжих ёстой тодорхой үнэт зүйл агуулагдаж байдаг. Үүгээрээ эдгээр ухагдахуун нь нийгмийн нэгдмэл байдлыг хангахад нөлөөлдөг ажээ. Хэм хэмжээ нь аль нэг салбар буюу салбар хоорондын хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага, түүний удирдах зөвлөл/хорооноос гаргасан дүрэм, журам юм.

Энэхүү даалгаврын зорилго нь сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн эрхэмлэх үнэт зүйлсийг тодорхойлж нэрлэхэд оршино.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- 21 дүгээр зууны багш бэлтгэж буй бусад улс орны кейс, туршлага гэх мэт
- ТХБ төсөл, МУБИС. 2021. Багшийн цогц чадамжийн судалгааны тайлан.
- БХ. (2021). Хэлний суурь цогц чадамж/БХ., “Хорин нэгдүгээр зууны монгол суралцагчийн цогц чадамжийг боловсролын түвшнээр тогтоох нь”. БСУЯ-ны захиалгат, ШУТ сангийн төслийн тайлан
- БХ. (2020). Цогц чадамжийг эзэмшүүлэх агуулга/Суралцагчийн цогц чадамжийг тодорхойлох, хэрэгжүүлэх арга зүй
- Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл MON-3243. 2016. Бүрэн дунд боловсролын химийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэл. Мэргэжилтэн Н.Оюунцэцэгийн эцсийн тайлан/ Байгалийн ухааны багшийн мэдлэг, чадварт тавигдах шаардлагыг боловсруулсан үйл ажиллагаа. 20-25 тал
- Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл MON-3243. 2016. Бүрэн дунд боловсролын математик сургалтын хөтөлбөрийн шинэчлэл. Мэргэжилтэн М.Итгэлийн эцсийн тайлан/ Математикийн багшийн мэдлэг, чадварт тавигдах шаардлагыг боловсруулсан үйл ажиллагаа. 20-25 тал



Даалгавар 4. Багшийн компетенцийг тодорхойлох, загварчлах

Даалгавраар шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн компетенцийг тодорхойлж, бүлэглэн, түүний загварыг санал болгоно. Энэ нь үндэсний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай багшийн мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлд суурилсан багшийн суурь, манлайллын (soft skills) болон ажлын байр (hard skills)-ны компетенцийг тодорхойлно гэсэн үг. Энэ нь хүүхэд, залуучуудыг шинэ зууны нийгмийн сайн сайхан, үр бүтээлтэй амьдралд бэлтгэх боловсролын салбарын хүлээлт буюу насан туршийн суралцахуйн эрэлт хэрэгцээ, зорилго болсон компетенцийг суралцагчдад эзэмшүүлэх буюу компетенцид суурилсан боловсрол хэрэгжүүлэх суралцахуйг удирдах багш бэлтгэх тухай асуудал юм. Багшийн цөм, суурь компетенци нь багшлах талбар, амьдрал ахуйдаа амжилт гаргахад чухал чадавх (сарабилити) юм. Цөм, суурь компетенци нь амьдралын бүхий л нөхцөлд хэрэг болох хувь хүний нөөц бололцоо бөгөөд нэг контекстоос нөгөө рүү шилжиж, бүхий л амьдралын туршид хөгжиж байдаг. Жишээлбэл, багшлахад эх хэл болон гадаад хэлний, түүх өв соёлын, шинжлэх ухааны, санаачилга ажил хэргийн суралцахуй ба шинэчлэхүйн зэрэг бүх ажил мэргэжлийн хүнд хамааралтай компетенци шаардагдана. Багшийн манлайллын компетенцид хүүхдийг энэрэн хайрлах, багийг удирдах, зөрчилдөөнийг шийдвэрлэхэд дэм өгөх, оролцооны стратегийг хэрэгжүүлэх, зөвлөх зэрэг манлайлах авьяас, чадварууд чухал. Харин багшийн ажил мэргэжлийн компетенцид суралцахуй ба хичээлийг төлөвлөх, удирдах, үнэлэх зэрэг багшийн ажлын байранд гүйцэтгэдэг үндсэн ур чадварууд багтдаг.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- 21 дүгээр зууны багшлахуйн компетенци, түүний загварын талаарх бусад улс орны судалгаа, туршлага гэх мэт

- Багшийн компетенцийн чиглэлээр манай оронд хийгдсэн төсөл, судалгааны ажлуудын үр дүн
- Багшийн стандартуудын төслүүд
- БХ. (2021). “Хорин нэгдүгээр зууны монгол суралцагчийн цогц чадамжийг боловсролын түвшнээр тогтоох нь”. БСУЯ-ны захиалгат төслийн тайлан
- UNESCO-USAID. 2006. Strategic Framework for Teacher Education and Professional Development in Pakistan. Paris, UNESCO.
[http://www.unesco.org.pk/education/documents/step/StrategicFramework-forTeacher Education and Professional Development.pdf](http://www.unesco.org.pk/education/documents/step/StrategicFramework-forTeacherEducationandProfessionalDevelopment.pdf) (Accessed 13 September 2013.)



Даалгавар 5. Багшийн компетенци/ур чадварыг олгож буй багш бэлтгэх хөтөлбөрийг судлах

МУБИС, МУИС зэрэг төрийн ба хувийн хэвшлийн багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт шинжилгээ хийж өмнөх даалгаварт дэвшүүлсэн багшийн компетенци/ур чадваруудыг тусган олгож буй төлөв байдлыг тогтооно. Мөн багш бэлтгэж буй үйл явц, хичээл, дадлагын байдалд ажиглалт хийнэ. Энэхүү судалгаанаас багшийн ямар компетенци/ур чадварыг олгож чадаж буй, мөн алийг нь олгож чадахгүй байгаа болон багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг цаашид шинэчлэх чиглэл тодорхой болно. Мөн улс орнуудын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчилж буй арга туршлага, кейс, бэрхшээлийг судална. Даалгавраар багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг өөрчлөн/шинэчлэхэд тусгах санаа, санал гаргана.



Уншиж судлах материал:

- Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн төсөл
- 21 дүгээр зууны багшийг бэлтгэж буй улс орнуудын сургалтын хөтөлбөр, бусад холбогдох баримт бичгүүд
- Багш бэлтгэх их, дээд сургуулиудын өөрчлөлт/шинэчлэлийн туршлага, хийгдсэн төсөл, судалгааны ажлуудын үр дүн
- Alfaro Palacios, E. B. 2003. La investigación-acción en el aula universitaria. La observación sistemática como herramienta para mejorar nuestra práctica pedagógica [University classroom action-research. Systematic observation as training to improve pedagogy]. Lima, Sedes Sapientiae Catholic University. Geneva, Switzerland, UNESCO International Bureau of Education, Community of Practice in Curriculum Development. (In Spanish.)
- Arnaut, A. 2004. El sistema de formación de maestros en México. Continuidad, reforma y cambio [Teacher training in Mexico. Continuity, reform and change]. Mexico City, Secretary of Public Education. (Working paper.) (In Spanish.)
- Villegas, E. R. 2003, Teacher Professional Development: an International Review of Literature. Paris, UNESCO International Institute for Educational Planning (IIEP). http://www.iiep.unesco.org/fileadmin/user_upload/Research_Challenges_and_Trends/133010e.pdf (Accessed 13 September 2013.)
- Wang, Y. and Liu, B. 2007. Problem-orientation as decisive principle for web-based learning to support professional development (Asia Pacific Knowledge Base on Open and Distance Learning). Beijing, UNESCO and Open University of Malaysia. <http://asiapacific-odl2.oum.edu.my/C15/F568.doc> (Accessed 13 September 2013.)



Бүтээгдэхүүн

1. Багш бэлтгэхэд ашиглах аргуудын жагсаалт
2. Багш бэлтгэхэд боломжит арга замуудыг ашиглах боломжийг судласан товч тайлан
3. Багш бэлтгэх сургалтад нэвтрүүлж болох стратегиудын жагсаалт, тайлбар
4. Шинэ зууны багшийн эрхэмлэх үнэт зүйлсийн жагсаалт
5. Шинэчилсэн сургалтыг хэрэгжүүлэх багшийн компетенцийн загвар (зурагт хуудас)
6. Манай орны багш бэлтгэх тэргүүлэх сургуулиудын хөтөлбөрт багшийн компетенци/урчдваруудыг тусган олгож буй төлөв байдлын товч тайлан (юуг чадаж, юуг нь чадахгүй байгаа зэрэг орно),
7. Багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг өөрчлөн/шинэчлэхэд тусгах санаа, саналын жагсаалт.

МОДУЛЬ 6. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ



Модулийн зорилго

Энэхүү модуль нь сургалтын хөтөлбөрийн туршилтын загвар, түүнийг системийн хүрээнд хэрэгжүүлэх үйл явц болон тулгарах бэрхшээл, сорилтуудыг бүх түвшний хэрэгжүүлэгчдэд таниулахад оршино.



Хэрэгжүүлэх хугацаа

Шинэ сургалтын хөтөлбөрийг боловсруулах явцад /буюу үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхийн өмнөх жилд/ туршилт хийнэ.



Модуль нь сургалтын хөтөлбөрийг дэс дараатай хэрэгжүүлэх арга барилын талаарх мэдлэг, ойлголтоо бататгах боломжийг хэрэгжүүлэгчдэд олгодог. Үүнд:

1. **Туршилтын загварууд:** Туршилтын хэд хэдэн боломжит загваруудын талаар авч үзнэ.
2. **Туршилтын загвар сонгох:** Туршилтын загваруудаас сонгож, турших явцад анхаарах ёстой хувьсагчдыг тодорхойлно.
3. **Туршилтаас бодлого руу:** Инновацийг нэвтрүүлэх-Хөтөлбөрийн туршилтыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэхэд үүсч болох саад бэрхшээлийг тодорхойлоход оролцогчдод тусална.

Сургалтын хөтөлбөрийг турших, хэрэгжүүлэх үйл явцтай холбоотой анхаарах зүйлс

Шинэ сургалтын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд амжилттай нэвтрүүлэхэд түүний давуу болон сул талуудыг тодорхойлох зорилгоор туршилтын үе шатыг зайлшгүй хэрэгжүүлэх ёстой.

Сургалтын хөтөлбөрийг өөрчлөх шинэчлэлийн үйл явцыг богино хугацаанд, яаравчлан хийх оролдлогууд нь үл ойлголцол бий болгох, олон нийт, оролцогч талуудын дунд сөрөг хариу үйлдэл үзүүлэх, эсэргүүцэл нэмэгдэх гэх мэт олон эрсдлийг дагуулж болзошгүй юм. Хөтөлбөрийн шинэчлэлийг эерэг үр дүнд хүргэхийн тулд сургалтын хөтөлбөрийн санал болгож буй загвар, туршилт нь үр дүнтэй, сонирхол татахуйц байвал

зохино. Ингэснээр бодлого боловсруулагчдад шинэ хөтөлбөрийг туршиж, давуу талыг нь олж харсан оролцогчдын дэмжлэгт түшиглэн системийн бусад хэсэгт өргөжүүлэн нэвтрүүлэх, боломжийг олгох юм.

Сургалтын хөтөлбөр боловсруулах чухал хэрэгсэл болохын хувьд туршилт нь дараах байдлаар хэд хэдэн түвшинд мэдэгдэхүйц үр өгөөжийг өгч чадна:

- санал болгож буй сургалтын хөтөлбөрийг өөрчлөх боломжийг тодорхойлоход туслах;
- сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийн талаар эмпирик нотолгоог бий болгох;
- сонгосон янз бүрийн нөхцөл байдалд сургалтын хөтөлбөрийн хамаарлыг онцлон харуулах;
- шинэ сургалтын хөтөлбөрийг бодит хувилбараар боловсруулах;
- туршилт, бүтээлч байдлыг дэмжих;
- бодлогын өөрчлөлтийн үйл явцыг дэмжих буюу нөлөөлөх;
- өөрчлөлтөд учирч болзошгүй саад бэрхшээлийг тодорхойлох;
- санал болгож буй бодлогын өөрчлөлтийн хүрээнд зөвшилцөл бий болгох;
- загвар боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх чадавхийг хөгжүүлэх

Туршилтыг үр дүнтэй явуулахын тулд тохирох загварыг сонгох, стратеги төлөвлөлт хийх шаардлагатай. Туршилтын бүлгүүд болон үнэлгээний аргуудыг сонгох, оролцогч талуудтай харилцаа тогтоож, үр дүнг амжилттай сурталчлах нь гол анхаарах зүйл юм. Туршилтын төсөлд оролцогчид хувийн болон мэргэжлийн хувьд өсч хөгжихийн зэрэгцээ, санал болгож буй өөрчлөлтөд илүү идэвхтэй оролцох боломжтой болдог. Туршилтаас авсан сургамж, үр дүн нь оролцогчдын сэтгэлгээний арга барилд нөлөөлж, “тэг” таамаглалыг үгүйсгэж, практикт сайжруулах судалгаа, онолын түвшинг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг талаар чухал ойлголтыг ч мөн авч чадна. Практикт туршилтууд нь ихэвчлэн жижиг хэмжээний төслүүд байдаг тул шинэ санааг туршихаас илүүтэй өргөн хүрээтэй, нийтлэг хэрэгжилт рүү шилжих боломж, нөхцлийг бий болгох, тулгарч буй бэрхшээлийг даван туулах шаардлагатай болно. Үүнд хамтын төлөвлөлт, бодлого боловсруулагчдын урт хугацааны үүрэг, амлалт чухал нөлөө үзүүлдэг.

Хүснэгт 6.1. Модуль 6-ын үйл ажиллагаа ба хэрэгжүүлэх даалгавар

Үйл ажиллагаа	Даалгавар	Бүтээгдэхүүн
Үйл ажиллагаа 1. Шинэ сургалтын хөтөлбөрийг турших загвар	Даалгавар 1. Сургалтын хөтөлбөрийг турших, хэрэгжүүлэхтэй холбоотой үндэсний болон олон улсын туршлага, сургамжийг судлах	1. Сургалтын хөтөлбөрийг турших, хэрэгжүүлэхтэй холбоотой үндэсний болон олон улсын туршлага, сургамжийн жагсаалт
	Даалгавар 2. Шинэ сургалтын хөтөлбөрийг турших загвар боловсруулах	2. Шинэ сургалтын хөтөлбөрийг турших загвар, стратеги 3. Сургалтын хөтөлбөрийг турших зардлын тооцоолол
Үйл ажиллагаа 2. Шинэ сургалтын	Даалгавар 1. Шинэ сургалтын хөтөлбөрийг турших стратеги төлөвлөлт боловсруулах	4. Шинэ сургалтын хөтөлбөрийг турших стратеги төлөвлөлт

хөтөлбөрийн туршилт	Даалгавар 2. Шинэ сургалтын хөтөлбөрийн турших	5. Шинэ сургалтын хөтөлбөрийг туршсан сайн туршлага (Хичээлийн судалгаа, сайн хичээл гэх мэт)
	Даалгавар 3. Шинэ сургалтын хөтөлбөрийн туршилтын явц, үр дүнгийн танилцуулга бэлтгэх	6. Шинэ сургалтын хөтөлбөрийг туршсан үйл явц, үр дүн бүхий сургуулийн танилцуулга 7. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар
Үйл ажиллагаа 3. Шинэ сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, инноваци, туршлага	Даалгавар 1. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөлт боловсруулах	8. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөлт
	Даалгавар 2. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	9. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үйл явц, үр дүн бүхий сургуулийн танилцуулга
	Даалгавар 3. Сурагчийн сурлагын амжилтын үнэлгээ болон сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа хийж, баримт нотолгоо цуглуулах	10. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн нөхцөл байдал (сурагчийн сурлагын амжилт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн хүчин зүйлс гэх мэт) 11. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөр
3 үйл ажиллагаа	2+3+3=8 даалгавар	11 бүтээгдэхүүн

Үйл ажиллагаа 1. Сургалтын хөтөлбөрийг турших загварууд



Зорилго. Энэхүү санал болгож буй үйл ажиллагаа нь туршилтын бүтэц, хэмжээ, хамрах хүрээ, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үйл явцын талаар оролцогчдод туслах болно. Туршилтын багийн үүрэг бол тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай удирдлага, дэд бүтцийг бий болгох явдал юм. Туршилтын баг нь сургалтын хөтөлбөр боловсруулах туршлага, хэрэгцээнд суурилсан үр дүнтэй харилцаа холбоог санал болгох замаар сургууль, бодлого боловсруулагчид болон бусад оролцогч талуудад дэмжлэг үзүүлдэг.

Туршилтын хамрах хүрээг тодорхойлох нь сургалтын хөтөлбөрийг өөрчлөх үйл явцын харьцангуй эхэн үе шатанд хийгддэг боловч туршилтын явцад сургалтын хөтөлбөрийг үнэлэх, боловсруулах үед ч дээрх үйл ажиллагааг хийх тохиолдлууд элбэг байдаг. Сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах туршилтууд нь өөр өөр зорилго, хамрах хүрээтэй байж болно, үүнд;

- Сургалтын хөтөлбөрийг боловсруулах явцад ялгаатай нөхцлүүдийг тооцож, үнэлгээ өгөх туршилт;
- Санал болгож буй сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх туршилт;
- Сургалтын хөтөлбөрийг өөрчлөх явцад бүтээлч байдал, инновацийг дэмжих туршилт.



Туршилт ба судалгаа

Шинэ сургалтын хөтөлбөрийг боловсруулах явцад (i) хөтөлбөрийн өөрчлөлт нь ашиг тустай юу; (ii) өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлэх боломжтой юу гэсэн хоёр асуултыг авч үзэх ёстой: Эдгээр асуултад хариулахдаа санал болгож буй сургалтын хөтөлбөр нь багш нарын хэрэгжүүлж байгаа одоогийн хөтөлбөрөөс хэр ялгаатай болохыг анхаарч үзэх хэрэгтэй. Учир нь шинэ сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт амжилтгүй болсон ихэнх тохиолдолд багш нарт тулгардаг бэрхшээл их байсан нь анхаарвал зохих тодорхойлогч хүчин зүйл болдог байна. Үүнээс гадна нийгэм, улс төрийн эсэргүүцэл, сургалтын хөтөлбөрт оруулах санхүүгийн нөөц гэх мэт бусад хүчин зүйлийг тооцож шийдвэрлэх шаардлагатай.

Шинэ сургалтын хөтөлбөрийн санал, хувилбаруудыг нарийвчлан шинжилж, боловсролын тогтолцооны хүрээнд болон гаднаас оролцогч талуудын саналыг авч үзэх судалгааны арга хэрэгсэлд албан бус хэлбэрийн үнэлгээний даалгавруудыг ашиглаж болно.

Судалгаа нь сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй боловсруулах, хэрэгжүүлэх зардлыг тодорхойлоход онцгой чухал юм. Зарим тохиолдолд боловсролын систем “хэт ачаалал”-д өртсөнөөс багш нар өөрчлөлтийн олон удаагийн давтамжид дасан зохицохгүй байх, залхах, ёс суртахууны талаар доголдох зэрэг үзэгдэл ажиглагдаж болно. Ийм үзэгдэл манай орны боловсролын шинэчлэлийн түүхэнд ч гарч байсан бөгөөд “Бага, дунд боловсролд хамрагдах нас 8 байсныг 7, 7 байсныг 6 болгож, суралцах хугацааг сунгасан нь тухайн дэд систем өргөсөх үндсэн шалтгаан болсон. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бага, дунд боловсролын үндсэн баримт бичгүүдийн өөрчлөлтүүд нь багшийн бэлтгэл, сурах бичгийн боловсруулалтад хугацаа шаардаж байсан боловч дараа, дараагийн хөтөлбөрүүдийн өөрчлөлт хийгдсэнээр сургалтын тогтвортой үйл ажиллагааны горимыг алдагдуулж, түүний чанар, үр дүнд сөргөөр нөлөөлсөн” гэж “Бага, дунд боловсролын дэд салбарын судалгааны тайлан”-д дурджээ. Иймээс шинэ сургалтын хөтөлбөрийг туршин судлах судалгаа зайлшгүй шаардлагатай бөгөөд сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтийн үнэ цэнийг үр дүнтэй тогтоож, хэрэгжүүлэх боломжит асуудлуудыг тодорхойлж чадах юм.

Туршилт ба үнэлгээ

Сүүлийн жилүүдэд үндэсний түвшний өргөн хүрээнд шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн өмнө түүнийг туршсан эмпирик мэдээллийн эрэлт хэрэгцээ нэмэгдэх болсон. Сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхэд өндөр өртөг зардал шаарддаг боловч шинэчлэлийг чанартай гүйцэтгэх үүднээс бодит нөхцөлд түүний практик, ашигтай байдлыг туршиж үзэх, эмпирик мэдээлэл цуглуулах нь нэн чухал ач холбогдолтой юм. Энэ утгаараа туршилтын ажил нь сургалтын хөтөлбөрийн үнэлгээний хэмжүүр болно.

Lewy¹ сургалтын хөтөлбөрийн туршилтыг гурван шатны шалгалт буюу "сорил" гэж тодорхойлсон. Энэхүү шалгалтын үе шат бүрт найдвартай, баталгаатай дүгнэлт гаргахын тулд албан ёсны үнэлгээний аргуудыг түлхүү ашигладаг байна:

1. Лабораторийн сорил: Энэ үе шат нь сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцыг үнэлэх үнэлгээнээс эхэлдэг ба сургалтын хөтөлбөрийн элементүүд (жишээ нь,

¹ Lewy, A. 1990. Curriculum tryout. The International Encyclopedia of Educational EVALUAtion. H. J. Walberg and G. H. Haertel (eds), Oxford, United Kingdom, Pergamon Press, pp. 2

сургалтын материал)-ийг хувь хүн эсвэл жижиг бүлгүүд дээр туршин шалгаж, сурагчдын хариу үйлдлийн үр дүнг ажиглах замаар сургалтын материалд оруулах өөрчлөлтүүдийг санал болгодог.

2. Туршилтын сорил: Энэ үе шатны зорилго нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой эсэх, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх, амжилтад хүрэхийн тулд ямар нөхцөл шаардлагатайг тодорхойлох явдал юм. "Туршилтын сорил"-ыг хийхээс өмнө хичээлийн урьдчилсан хувилбарыг боловсруулж, сургуулийн орчинд эхлүүлж болно. Сургалтын хөтөлбөр боловсруулах багийн гишүүд багшийн үүргийг гүйцэтгэж болно.

3. Талбайн сорил: Туршилтын үр дүнд үндэслэн шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн хувилбарыг боловсруулж дуусмагц "талбайн сорил"-ыг багш нар өөрсдийн анги танхимд туршилтын багийн шууд оролцоогүйгээр явуулж болно. Энэ дасгал нь тухайн хөтөлбөрийг хөндлөнгийн багийн байнгын дэмжлэггүйгээр ашиглаж болох эсэхийг тогтоох бөгөөд хэрэглэгчдэд хөтөлбөрийн ач тусыг харуулахад чиглэдэг.

Эдгээр үе шатыг туршилт, үнэлгээ болгонд нэг бүрчлэн ашиглах албагүй. Тухайлбал, "талбайн сорил" нь ихэвчлэн бие даасан байдлаар хийгдэж болно.

Сургалтын хөтөлбөрт инновацийг нэвтрүүлэх стратегийг доороос дээш чиглэсэн хамтын үйл явц болгон хэрэгжүүлбэл туршилтын төсөл ашигтай байх болно.

Орон нутаг, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх туршилтын хамтын ажиллагааны загварт оюутан сурагч, багш, сургуулийн захирал, хөтөлбөр боловсруулагч, сэдвийн мэргэжилтнүүд, төрийн албан хаагчдыг хамруулах нь зүйтэй. Энэ нь бүлэг бүрээс гарсан сургалтын хөтөлбөрийг өөрчлөх өвөрмөц санал, санаачилгуудыг туршилтын үйл явцад харгалзан үзэх замаар тэдний оруулах хувь нэмрийг үр дүнтэй ашиглахад тустай байдаг. Тухайлбал, багш нар сурагчидтай харилцах өдөр тутмын харилцаандаа тулгуурлан хичээл, заах арга зүйн талаар шууд санал бодлоо илэрхийлж байхад захирлууд болон сургуулийн удирдлагын бусад түвшний хүмүүс төлөвлөлт, боловсон хүчин, төсвийн асуудалд илүү анхаарлаа хандуулдаг. Сургалтын хөтөлбөр боловсруулагчид сургалтын хөтөлбөрийн шинэ зорилтуудыг боловсруулахад боловсролын судалгаа юуг харуулж байгаа талаар онол, арга зүйн мэдлэг, чадвараар өөрсдийн хувь нэмрээ оруулдаг. Бодлого боловсруулагчид хүлээгдэж буй улс төрийн үр дүн, санхүүжилтийн асуудал, сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт, хэрэгжилтээс үүсч болох асуудлуудыг зохицуулахад анхаарлаа төвлөрүүлэх хандлагатай байдаг. Иймээс эдгээр оролцогч талуудын гишүүн бүр туршилтын бүх үе шатанд бие бидэсээ суралцах, дэмжлэг авах, бүлгийн бусад гишүүдтэй хамтран ажиллах хэрэгцээ үүсдэг байна.

Хамтран ажиллах загвар нь шийдвэр гаргах ардчилсан хэв маягтай нийцдэг учраас сургалтын хөтөлбөрийг турших, хэрэгжүүлэх явцад үүсэх маргаантай, эмзэг сэдэв, асуудлуудыг шийдвэрлэхэд тохиромжтой байдаг. Зөвшилцсөн шийдвэр гаргах замаар тохиролцоонд хүрэхийн тулд сайн манлайлал хэрэгтэй. Сайн манлайлал нь сургалтын хөтөлбөрийг өөрчлөх үйл явцыг боловсролын системийн бүх түвшинд үр дүнтэй, уялдаатай, тогтвортой явуулах боломжийг олгодог.

Инноваци ба туршилт

Сургалтын хөтөлбөр боловсруулагчид шинэчлэн боловсруулсан бүтээгдэхүүнээ багш нараар дамжуулан сурагчдад хүргэдэг учраас сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд түүнийг турших арга техникийн талаар багш нарт мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт явуулах, шаардлагатай нөөцүүдийг зөв хуваарилах гэх мэт бэлтгэл ажлуудыг хангалттай сайн зохион байгуулах шаардлагатай байдаг. Сургалтын хөтөлбөрийн туршилтын үр дүнг амжилтад хүргэх бас нэг арга нь багш, бусад сонирхогч

талуудын мэдлэг чадварыг ашиглах замаар инновацийг хөгжүүлж, сургалтын хөтөлбөрийг өөрчлөхөд туслах хэрэгсэл болгон ашиглах явдал юм. Туршилтын энэхүү аргыг "доороос дээш чиглэсэн хамтын ажиллагаа"-ны хандлага гэж тодорхойлдог бөгөөд дээр дурдсан "Туршилт ба судалгаа", "Туршилт ба үнэлгээ" загваруудад хамаарах чиг үүргийг багтаан авч үзэж болно. Энэ нь туршилт судалгаа, сургуульд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцыг үнэлэх стратегийг ашиглан багш нарт шууд оролцох боломжийг олгож байгаа хэрэг юм. Эцэст нь дүгнэхэд, сургалтын хөтөлбөрийн үр дүнтэй загваруудыг бий болгож, практикт туршсан сайн үр дүнд тулгуурлан чанарыг сайжруулах ажлыг эхлүүлэх нь боловсролын бодлогод эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой билээ.



Даалгавар 1. Сургалтын хөтөлбөрийг турших, хэрэгжүүлэхтэй холбоотой үндэсний болон олон улсын туршлага, сургамжийг судлах

Сургалтын хөтөлбөрийн өмнө нь хэрэгжүүлж байсан туршилтын загвар, сургамж болон бусад улс орнуудын сургалтын хөтөлбөрийн туршилтын загваруудыг уншиж судална.



Уншиж судлах материал:

- "Инновацийн үйл явцын талаар олж авсан сургамж" баримт бичиг
- "Португалийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш нарын үзүүлэх хариу үйлдэл"
- "Япон дахь сургуулийн хөтөлбөрүүдийн судалгаа, хөгжил" (R&D)
- Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал
- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал, ЖАЙКА
- Бага, суурь боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилт: Хүүхэд бүрийн хөгжил – туршлага, амжилт, үр дүн, УБ 2016
- БСШУЯ, Азийн Хөгжлийн банк, "Бага, дунд боловсролын дэд салбарын судалгааны тайлан", УБ 2019
- Lewy, A. 1990. Curriculum tryout. The International Encyclopedia of Educational EVALUAtion. H. J. Walberg and G. H. Haertel (eds), Oxford, United Kingdom, Pergamon Press
- Maruyama, A. 2011. Research and development of school programs (R&D) in Japan. (Diploma in Curriculum Design and Development [IBE/UCU/OREALC] Cohort 2010/11.) Geneva, Switzerland, UNESCO International Bureau of Education.



Даалгавар 2. Шинэ сургалтын хөтөлбөрийг турших загвар боловсруулах

Ерөнхий боловсролын сургуулийн байршил, хэв шинж, бүлгийн тоо, бүлэг дүүргэлт, мэргэжлийн багшийн хүрэлцээ, сургалтын орчин зэрэг нөхцөл байдлыг харгалзан төлөөлөх түүврээр сургуулиудыг сонгож, үндэсний онцлогтой туршилтын загварыг боловсруулна. Үүнд дараах нөхцөлүүдийг харгалзан үзнэ;

- Боловсролын янз бүрийн түвшний удирдлагын үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрөх

- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшлах боловсон хүчин, санхүү, материалын нөөцийг тооцох
- Сургалтын хөтөлбөрийг туршихад ямар аргууд тохиромжтой болохыг тодорхойлох
- Эдгээр аргыг хэрэглэх боломж, учирч болох эрсдэл, давуу, сал талуудыг тодорхойлох,
- Боловсролын салбарын мэргэжилтэн, туршилтын сургуулийн удирдах ажилтан, багш нарт сургалт явуулах
- Туршилтын үр дүнгээс гарсан шинэ санаа, арга зүйг тусган сайжруулах, турших
- Туршлага судлах
- Түгээн дэлгэрүүлэх сургалт явуулах
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх
- Хичээлийн болон үйл ажиллагааны хэлэлцүүлэг, форум зохион байгуулах
- Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх
- Хэвлэл мэдээллийнхэнд цогц мэдээлэл өгч, олон нийтэд таниулан сурталчлах



Уншиж судлах материал:

- “Гүрж: сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг эхлүүлэх нь (анхны сургамж)” баримт бичиг
- “Умард Ирланд дахь иргэний боловсрол: инновацийг турших” доороос дээш чиглэсэн хамтын үйл ажиллагааны сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцын жишээ
- “ЕБС-ийн бүтэц, байршил, хэв шинж” ШУТС-ийн төслийн тайлан, БХ 2013
- Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцын тайлан, ЖАЙКА, УБ 2018
- Бага боловсролын шинэчлэл: Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих сургалтын арга зүй, технологи, 2014
- Хичээлийн судалгаа; видео хичээл, Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл 2014
- Janashia, S. 2006. Georgia: starting curriculum implementation (first lessons learned). *Current and Future Challenges in Curriculum Development: Policies, Practices and Networking for Change*. A. Crisan (ed.), Bucharest, Editura Educatia 2000+/Humanitas Educational/UNESCO International Bureau of Education.
- Flores, M. A. 2005. Teachers’ views on recent curriculum changes: tensions and challenges. *The Curriculum Journal*, Vol. 16, No. 3, September 2005, pp. 401–13.
- Ssereo, F. E. 2011. An account of curriculum process in Ethiopia. Geneva, Switzerland, UNESCO International Bureau of Education. (Diploma in Curriculum Design and Development [IBE/UCU/OREALC] Cohort 2010/11.)
- Ssereo, F. E. 2011. An account of curriculum process in Ethiopia. Geneva, Switzerland, UNESCO International Bureau of Education. (Diploma in Curriculum Design and Development [IBE/UCU/OREALC] Cohort 2010/11.)



Бүтээгдэхүүн.

1. Сургалтын хөтөлбөрийг турших, хэрэгжүүлэхтэй холбоотой үндэсний болон олон улсын туршлага, сургамж бүхий жагсаалт
2. Сургалтын хөтөлбөрийг турших загвар, стратеги
3. Сургалтын хөтөлбөрийг турших зардлын тооцоолол

Үйл ажиллагаа 2. Сургалтын хөтөлбөрийг турших төлөвлөгөө



Зорилго. Энэхүү санал болгож буй үйл ажиллагаа нь оролцогчдод туршилтын загвар боловсруулахдаа гаргах шийдвэрүүдийг судлахад туслах болно.

Туршилтыг төлөвлөхдөө түүний зорилгыг тодорхой томъёолж, үйл явцын төгсгөлд шаардагдах мэдээллийг оновчтой сонгох нь чухал юм.

Туршилт судалгааг төлөвлөхдөө анхаарах зарим хүчин зүйлүүд:

1. Судалгаанд оролцох сургууль, багш нарын түүврийг гаргахдаа сургуулийн байршил, хэв шинж, суралцагчийн тоо, сурлагын амжилт, багшийн туршлага зэргийг харгалзах;
2. Судалгаанд оролцогчдоос хүлээгдэж буй оролцооны төрөл, хэлбэрүүдийг урьдчилан тооцох;
3. Үнэлгээний аргууд туршилт судалгааны зорилготой нийцэж буй байдлыг харгалзах.



Туршилтын сургууль, багш нарыг сонгох

Практикт цөөн тооны сургуулийг туршилтад хамруулдаг. Туршилтын бүлгийн хэмжээг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, санхүү, улс төрийн хүчин зүйлээс гадна оновчтой аргачлалыг хэрэгжүүлэх хэрэгцээнээс хамааруулан тодорхойлдог. Тухайлбал, Хойд Ирландын Нийгэм, Иргэний болон Улс төрийн боловсролын төслийн хүрээнд 25 сургуулийг сонгож, туршилт судалгаанд хамруулсан нь Хойд Ирландын боловсролын жижиг тогтолцооны 10 хувийг бүрдүүлж байв. Иймээс тус түүвэр нь судалгааны түвшинд бага боловч тухайн системийг төлөөлөх чадвар хангалттай юм.

Түүвэрт сонгогдох сургуулиуд нь төрийн болон хувийн хэвшил, шашны болон иргэний харьяалал, хот ба хөдөөгийн байршил гэх мэт үзүүлэлтээр бүхэл бүтэн тогтолцоог төлөөлөх нь чухал юм. Түүврийн бүлэг нь холбогдох бүрэлдэхүүн хэсгүүдийн төлөөлөл биш л бол аль нэг талыг барих хандлага нэмэгдэнэ. Түүнчлэн түүвэрт сонгогдсон бүлгийн хэмжээ нь нийгмийн бүлэгтэй харьцуулахад пропорционал байх нь чухал байдаг.

Боловсролын тогтолцоонд инновацийг дэмждэг хүмүүс байхад зарим нь эсэргүүцэх хандлагатай байдаг. Иймд сургалтын хөтөлбөрийн тодорхой өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй бэрхшээлийг урьдчилан тодорхойлохын тулд шинэчлэлийн консерватив болон дэвшилтэт хандлагыг хоёуланг нь авч үзэх нь чухал юм.

Хэрэв албан ёсны хүчтэй дэмжлэгтэй бол туршилтын бүлгийг бүрдүүлэхэд сургууль, багш нарыг шууд нэр дэвшүүлж оролцуулж болно, бусад тохиолдолд оролцогчдын сайн дурын үндсэн дээр зохион байгуулна. Сайн дураар оролцох хүсэл эрмэлзэлтэй захирал хүсэл эрмэлзэл багатай багш нарыг элсүүлж болно. Гэвч шинэ сургалтын хөтөлбөрийн туршилтын гол зорилго нь ямар ч ойлголт, сонирхолтой байсан хүсэл эрмэлзэлтэй, тууштай оролцогчидтой байх нь давуу талтай байдаг.

Талуудын оролцооны хэлбэрүүд

Оролцогч талуудыг туршилтад татан оролцуулах, тулгарч буй асуудал, бэрхшээлийг даван туулах арга замыг хайх, шийдвэр гаргах үйл явцад талуудын зөвшилцөлд хүрэх нь нэн тэргүүний асуудал юм. Иймд янз бүрийн түвшний оролцогч талуудыг татан оролцуулах хэд хэдэн аргын тухай товч авч үзье.

- *Орон нутгийн болон үндэсний түвшний өндөр албан тушаалтнуудыг оролцуулах:* Энэ бүлэгт эрдэмтэн судлаачид, ТББ, улс төрийн нам, шашны болон эцэг эхийн бүлэг, багш нарын холбоо, сургуулийн төлөөлөл ордог. Эдгээр нөлөө бүхий бүлгүүдтэй сургалтын хөтөлбөрийн туршилтын явцын талаар шуудан, цахим шуудангаар холбоо барих, мэдээлэл, санал солилцоход тэднийг урьж оролцуулах замаар оролцооны түвшинг нэмэгдүүлж болно.
- *Тогтмол оролцогч талуудыг дэмжих:* Энэ бүлэгт туршилтын хөтөлбөрийг боловсруулах бүхий л үе шатанд анхаарлаа төвлөрүүлж, идэвхтэй, тогтмол оролцох багш нар, бодлого боловсруулагчид, сургалтын хөтөлбөрийн мэргэжилтэн, судлаачдыг багтаадаг. Иймээс туршилтын талаар бодлогын шийдвэр гаргах, цаашдын боловсруултад оролцох, мэдээлэл солилцох, санал хүсэлт гаргахад нь дэмжлэг үзүүлэх, олон талын түншлэлийг хөгжүүлэх боломжийг дэмжинэ.
- *Хэвлэл, мэдээллийг татан оролцуулах:* Олон нийтийн арга хэмжээ, танилцуулга, эрдэм шинжилгээний хурал, сэтгүүлийн нийтлэл гэх мэт хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж, туршилтын талаар сурталчилна. Түүнчлэн нийт ажилтан, эцэг эх, сурагчдыг мэдээллээр хангах, үйл ажиллагаанд татан оролцуулах нь туршилтын хүрээнд сургуулийн амьдралд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх боломжтой.
- *Багш нарыг татан оролцуулах:* Туршилтад хамгийн чухал оролцогч тал бол багш нар байдаг. Багш нарын оролцоо нь дараах онцлогтой, үүнд:
 - (i) Хамтран ажиллаж, мэдлэгээ хуваалцаж, үйл явцад тэгш хувь нэмэр оруулж буй багш, сургалтын хөтөлбөр боловсруулагч нарын хооронд гүйцэтгэх үүргийн ялгаа бараг байдаггүй,
 - (ii) Багш нар сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, туршлага, ур чадварыг ойлгохын тулд туршилтын үйл явцад оролцдог,
 - (iii) Багшийн оролцоо улам бүр түгээмэл болж байгаа боловч даван туулахад хэцүү, эсвэл боломжгүй хязгаарлалтууд байдаг. Үүнд, хөтөлбөрийн мэргэжилтний дэмжлэггүйгээр ажиллах боломжгүй, цаг хугацаа хязгаарлагдмал байх, нэмэлт үүрэг хариуцлага хүлээхэд ажлын ачаалал ихсэх, сургалтын хөтөлбөр боловсруулах бусад үйл ажиллагаанд саад болдог захиргааны дарамт, шахалт гэх мэт.
 - (iv) Инновац туршилтын төсөлд оролцож буй багш хувь хүний болон мэргэжлийн хувьд хөгжиж, санал болгож буй өөрчлөлтүүдийн талаар гүн гүнзгий ойлголттой болж чаддаг.
- Албан болон албан бус хэлбэрээр санал болгож буй сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтийн үнэ цэнэ, сурагчдын оруулах хувь нэмрийг ойлгуулах нь тэднийг сургалтын хөтөлбөрийг өөрчлөх туршилтад татан оролцуулах, дэмжих үйл ажиллагаа болно.

Үнэлгээ, судалгаа

Үнэлгээний талаар Модуль 8-д илүү дэлгэрэнгүй авч үзэх болно; Гэвч энд тусад нь авч үзэх шаардлагатай үнэлгээ, судалгааны хэд хэдэн асуудал бий. Үүнд, гадаад ба дотоод үнэлгээ, үнэлгээний арга хэрэгсэл болон үнэлгээний үр дүнг тайлагнах асуудлуудыг товч авч үзнэ.

Энэ модульд дурдсан хэд хэдэн тохиолдлуудад үнэлгээний үүрэг маш чухал болохыг тодорхой илэрхийлсэн билээ. Үнэлгээг дотоод болон хөндлөнгийн экспертүүд хийж гүйцэтгэдэг. Дотоод үнэлгээ нь ирээдүйн хэрэгжилтийг сайжруулах арга барилын давуу болон сул талуудыг тодорхойлох шинж чанартай байдаг бол гадаад буюу хөндлөнгийн үнэлгээ нь туршилтын үр нөлөөг үнэлэх шинж чанартай байдаг.

Үнэлгээний хэрэгсэлд санал асуулга, зорилтот бүлэгт чиглэсэн ярилцлагын аргыг ашигладаг. Үнэлгээний үйл явц, хэрэгслийг боловсруулахдаа туршилтын үр дүнд нөлөөлж болох тэгш байдал (хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг гэх мэт)-ын асуудлуудыг анхаарч, боловсролын болон нийгмийн өргөн хүрээнд үйлчлэх хэтийн төлөвийг авч үзэх хэрэгтэй юм. Мөн тухайн нөхцөл байдалд тохирсон үнэлгээний төрлийг сонгох, үнэлгээг үр дүнтэй ашиглах төлөвлөгөө боловсруулах, үнэлгээний найдвартай байдлыг хангах, оролцогч талуудын үнэлгээнд итгэх итгэлийг бий болгох нь анхаарвал зохих гол асуудлууд юм.

Үнэлгээний эксперт, төслийн багийн хооронд үл итгэх, уур амьсгал үүсэх нь харилцаанд төдийгүй туршилтын үйл явцад сөрөг нөлөө учруулж болзошгүй юм. Ийм байдлаас урьдчилан сэргийлэхийн тулд үнэлгээний эксперт болон туршилтын багуудын хооронд уулзалт, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж байх ёстой.

Үнэлгээ, судалгааны үр дүнг тайлбарлах чадвар нь тэдгээрийг ашиглахад чухал нөлөө үзүүлдэг. Тодруулбал, зорилтот бүлгийн хэрэгцээг харгалзсан байх, боловсролын бодлогод нөлөөлөх үр дүнг үнэн зөв тайлбарлах шаардлагатай байдаг.



Даалгавар 1. Шинэ сургалтын хөтөлбөрийг турших стратеги төлөвлөгөө боловсруулах

Шинэ сургалтын хөтөлбөрийг турших үндэсний, орон нутгийн болон сургуулийн стратеги төлөвлөгөө боловсруулна. Сургалтын хөтөлбөрийг турших стратеги төлөвлөлтөд туршилт хийх түүврийн төлөөлөл, туршилтын үе шатууд, хугацаа, туршилтын үе шат бүрт хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгах бөгөөд дараах нөхцөлүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

- Туршилтын сургууль, бүлэг ямар хэмжээтэй байх вэ?
- Туршилтын бүлэг нь түүврийн төлөөллийг хангаж байна уу?
- Туршилтад өөр ямар оролцогч талууд оролцох ёстой вэ, тэд ямар үүрэгтэй оролцох вэ?
- Туршилт нь ямар үндсэн үйл ажиллагааг явуулах ёстой вэ?
- Туршилтын үнэлгээнд ямар зохицуулалт хийх ёстой вэ?
- Туршилтын үнэлгээнд тэгш байдлын ямар асуудал (жишээ нь, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг гэх мэт)-ыг авч үзэх шаардлагатай вэ?
- Туршилтын үйл ажиллагаанаас ямар үр дүн, нотлох баримт гарах ёстой вэ?
- Туршилтын үр дүнгээс ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байна вэ?
- Туршилтын санхүүгийн үр нөлөө, боловсролын нөхцөл байдлаас бодитой хүлээлт бий юу? гэх мэт



Уншиж судлах материал:

- “Катар дахь шинэ сургуулиуд” кейс судалгаа
- “Уэльс – Суралцаж буй орон: Суурь 3-7-р шатны үйл ажиллагааны төлөвлөгөө” кейс судалгаа болон “Эустасийн бие даасан сургуулийн сургалтын төлөвлөгөө” баримт бичиг
- Монгол Улсын бага, дунд боловсролын статистик эмхэтгэл, 2013-2014
- Монгол Улсын бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн туршилтын тайлан, Боловсролын хүрээлэн, 2013-2014
- БСШУЯ 2016, Суралцахуйг дэмжсэн хичээл, үйл ажиллагааны төлөвлөлт: Сайн хичээл, үйл ажиллагааны Улсын зөвлөгөөн (бага боловсрол)
- БСШУЯ 2016, Суралцахуйг дэмжсэн хичээл, үйл ажиллагааны төлөвлөлт: Сайн хичээл, үйл ажиллагааны Улсын зөвлөгөөн (суурь боловсрол)
- Brewer, D. J. et al. 2007. *Education for a New Era – Design and Implementation of K–12 Education Reform in Qatar*. Qatar, RAND/Qatar SEC.
http://www.rand.org/content/dam/rand/pubs/monographs/2007/RAND_MG548.sum.pdf (Accessed 13 September 2013.)
- National Assembly for Wales (NAfW). 2001. *Wales – The Learning Country: Foundation Phase 3-7 Action Plan*. Cardiff, National Assembly for Wales.
http://new.wales.gov.uk/docrepos/40382/4038232/4038211/learning_pathways2/ActionPlan_-_English_-_Nov1.pdf?lang=en (Accessed 13 September 2013.)



Даалгавар 2. Шинэ сургалтын хөтөлбөрийг турших

Туршилтын явцад бий болсон нотлох баримтад дүн шинжилгээ хийж, туршилтыг сайжруулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг дахин төлөвлөнө.



Уншиж судлах материал:

- Монгол Улсын бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн туршилтын тайлан, Боловсролын хүрээлэн, 2018-2019
- БСШУЯ, Азийн Хөгжлийн банк, “Бага, дунд боловсролын дэд салбарын судалгааны тайлан”, УБ 2019
- Бага боловсролын сургалтын хөтөлбөр: сайжруулсан 2 дахь хэвлэл, УБ2019
- БШУЯ, АХБ, Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, хэрэгжилтийн өнөөгийн байдал
- Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцын тайлан, ЖАЙКА, УБ 2018



Даалгавар 3. Шинэ сургалтын хөтөлбөрийн туршилтын явц, үр дүнгийн танилцуулга бэлтгэх

Шинэ сургалтын хөтөлбөрийн туршилтын явц, үр дүнгийн танилцуулга бэлтгэхдээ дараах зүйлд анхаарна. Үүнд,

- Туршилтад сонгогдсон сургууль, бүлгийн хэмжээ нь түүврийн төлөөллийг хангасан байдал
- Туршилтад оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг

- Туршилтын үндсэн үйл ажиллагааг төлөвлөсөн байдал
- Туршилтын үнэлгээнд тэгш байдлыг хангасан эсэх (жишээ нь, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг гэх мэт)
- Туршилтын үйл ажиллагааны үр дүн, нотлох баримтууд
- Туршилтын үр дүнгээс гарах саналууд



Уншиж судлах материал:

- Монгол Улсын бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн туршилтын тайлан, Боловсролын хүрээлэн, 2013-2014
- Монгол Улсын бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн туршилтын тайлан, Боловсролын хүрээлэн, 2018-2019
- Бага боловсролын сургалтын хөтөлбөр: сайжруулсан 2 дахь хэвлэл, УБ2019
- Суурь боловсролын сургалтын хөтөлбөр, УБ2019
- Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, сайжруулсан 2 дахь хэвлэл, УБ2019



Бүтээгдэхүүн

1. Шинэ сургалтын хөтөлбөрийг турших стратеги төлөвлөлт
2. Шинэ сургалтын хөтөлбөрийг туршсан сайн туршлага (Хичээлийн судалгаа, сайн хичээл гэх мэт)
3. Шинэ сургалтын хөтөлбөрийг туршсан үйл явц, үр дүн бүхий сургуулийн танилцуулга
4. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар

Үйл ажиллагаа 3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, Инноваци, туршлага



Зорилго. Энэхүү санал болгож буй үйл ажиллагаа нь туршилтын үр дүнд системийн ерөнхий бодлого болгон хэрэгжүүлж буй шинэчлэлийн үйл явцад тулгарч болох бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилготой. Сургалтын хөтөлбөрийн туршилтын явцын танилцуулга (мэргэжлийн багш, туршилтын сургуулиуд)-д үндэслэн бүх сургуулиудад хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. Хэрэгжилтийн явцад сурагчдын мэдлэг, чадвар, хандлагад гарч байгаа ахиц өөрчлөлт болон сургууль, орон нутаг, үндэсний түвшний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлж байгаа хүчин зүйлийн судалгааг үе шаттай хийж, үр дүнгээр мэдээллийн сан бүрдүүлнэ.



Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт гэдэг нь туршилт судалгааг амжилттай туршсан үр дүнд тулгуурлан шинэ сургалтын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх үйл явцыг хэлнэ. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд хөтөлбөр боловсруулагчийн тодорхойлсон өөрчлөлтийг хатуу баримтлах, эсвэл сургалтын хөтөлбөрийг орон нутгийн нөхцөлд тохируулан хэрэглэж болно. Сургалтын хөтөлбөрийн зарим загвар нь дүүрэг, сургууль, багш нарт өөрсдийн сурагчдын онцлогт тохируулан өөрчлөн хэрэгжүүлэхийг дэмждэг.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн нь дараах хүчин зүйлүүдээс хамаарна.

- Санал болгож буй өөрчлөлтийн мөн чанар;
- Өөрчлөлтийн талаарх үндэслэлтэй тайлбар, тодорхой байдал;

- Боловсролын тогтолцооны өөрчлөлтийг хэрэгжүүлэх бүх оролцогчдын хүсэл эрмэлзэл, чадавх;
- Сургалт, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, санхүүжилт болон бусад эх үүсвэрээр үзүүлж буй дэмжлэгийн хэмжээ, чанар.

Олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, дэмжлэг үзүүлэх, янз бүрийн нөхцөл байдалд туршиж шалгах нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг. Хэрэв сургалтын хөтөлбөр нь албан ёсоор шалгагдаагүй бол туршилтаас үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд хүндрэл үүсдэг. Үүнд, хамгийн тохиромжтой гэж үзсэн туршилтын хэмжээ нь үндсэн тогтолцоонд тохирохгүй байх, туршилтад сайн дураар оролцсон оролцогчдын гүйцэтгэл нь тогтолцооны хэмжээнд бүх багш, сургуулийн боломжит хэмжээнээс давсан үзүүлэлттэй байх, энэ нь туршилтад хамрагдаагүй бүлгийн хувьд дарамт болох зэрэг хүндрэлүүд гарч болно.

Инноваци туршилтууд нь туршилтын бүлэг, оролцогч талуудад мэргэжлийн хувьд өсч хөгжих өргөн боломжийг санал болгодог. Мөн илүү их үүрэг амлалт авч хэрэгжүүлэхийг шаарддаг учраас сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж, бэрхшээлийг хоёуланг нь туулах шаардлагатай болдог. Зүй нь, туршилтын багш нар сайн бэлтгэгдэж, сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах үндэслэл, агуулга, аргачлалд суралцах ёстой. Энэ бол багшийг ажлын байран дээрх сургагч багш, сургалтын хөтөлбөрийг дэмжих ажилтан гэх мэт олон төрлийн үүргийг гүйцэтгэх чадварлаг мэргэжилтэн болгож хөгжүүлдэг.



Даалгавар 1. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах

Энэ модульд авч үзсэн төрөл бүрийн инноваци, туршилтын туршлага, сургамж, асуудлууд дээр үндэслэн үндэсний, орон нутгийн, сургуулийн түвшинд шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулна. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах баг дараах асуултуудад анхаарал хандуулна. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийн туршилтын үр дүнгээс ямар сургамж авсан бэ?
- Эдгээр туршлага нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд ямар нөлөө үзүүлэх вэ?
- Бодлогын өөрчлөлтийг сургуулийн сургалт, үйл ажиллагаанд хэрхэн тусгах вэ?
- Захирал болон сургуулийн бусад удирдах ажилтны арга барилыг юунд чиглүүлэх вэ?
- Багш нар сургалтын үйл ажиллагааг хэрхэн хувирган өөрчлөх вэ?
- Сурагчдын суралцах үйл явцыг хэрхэн удирдан чиглүүлэх вэ?
- Эрүүл, аюулгүй сургалтын орчныг хэрхэн бүрдүүлэх вэ?
- Үнэлгээний боломжит зохицуулалтыг хэрхэн хийх вэ?
- Санхүүгийн эх үүсвэр, нөөц хангалттай юу?



Уншиж судлах материал

- Монгол Улсын бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн туршилтын тайлан, Боловсролын хүрээлэн, 2013-2014
- БСШУС-ын сайдын 2019 оны А/419 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт
- “ЕБС-ийн бүтэц, байршил, хэв шинж” БХ 2013, БШУЯ, ШУТС-ийн төслийн тайлан
- Боловсролын чанарын үнэлгээний тайлан, УБ 2016, БҮТ
- “Сургалтын орчны стандартын хүрээ”, БХАН, АХБ-ны төслийн тайлан, УБ 2008



Даалгавар 2. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний төслийг нэгдсэн хэлэлцүүлэгт танилцуулж, хэрэгжүүлэх стратегийн нийтлэг элементүүдийг тодорхойлно.

Үндэсний, орон нутгийн, сургуулийн түвшинд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөлтөд дараах асуудлуудыг тусгана. Үүнд:

- Хэрэгжүүлэх сургуулийн тоо, хэв шинж, байршил
- Хэрэгжүүлэх үе шат, цаг хугацаа
- Туршилтын үр дүнд үндэслэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа
- Суралцагчийн сурлагын амжилтын үнэлгээ
- Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх дэмжлэгийн тогтолцоо гэх мэт



Уншиж судлах материал

- Монгол Улсын бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн туршилтын тайлан, Боловсролын хүрээлэн, 2013-2014
- БСШУС-ын сайдын 2019 оны А/419 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт
- “ЕБС-ийн бүтэц, байршил, хэв шинж” БХ 2013, БШУЯ, ШУТС-ийн төслийн тайлан
- Боловсролын чанарын үнэлгээний тайлан, УБ 2016, БҮТ
- “Сургалтын орчны стандартын хүрээ”, БХАН, АХБ-ны төслийн тайлан, УБ 2008



Даалгавар 3. Сурагчийн сурлагын амжилтын үнэлгээ болон сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа хийж, баримт нотолгоо цуглуулах

Сургалтын хөтөлбөр хэрэгжих хугацаанд жил бүр сурагчдын сурлагын амжилтын үнэлгээ хийх тул үнэлгээний түүврийн хүрээ (ямар хичээл судлагдахуун, ямар анги бүлэг, нийт хамрагдах сурагчдын тоо)-г стратеги төлөвлөгөөнд тусган, үнэлгээ хийх багш, хүний нөөцийг тодорхой давтамжтайгаар чадавхжуулах сургалтад хамруулна.

Сурагчийн сурлагын амжилтын үнэлгээ хийхийн тулд шинэ сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, агуулга, арга зүй, үнэлгээний шинэ хандлагыг даалгавар боловсруулагчдад таниулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.



Уншиж судлах материал:

- “Турк: сургалтын хөтөлбөрийг өөрчлөх, хэрэгжүүлэх менежмент”
- “Этиоп дахь сургалтын хөтөлбөрийн үйл явцын тойм”
- “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт – хязгаарлах, хөнгөвчлөх хүчин зүйлүүд” баримт бичиг
- “Унгар дахь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт”, “Исламын Бүгд Найрамдах Иран улсын урлагийн шинэ, анхан шатны сургалтын хөтөлбөр боловсруулалт, хэрэгжүүлэлт” болон “Тринидад ба Тобаго Улсын бага сургуулиудад нийгмийн интеграцчиллыг дэмжих нь, 1972–2000: сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд багш нарын гүйцэтгэх үүрэг” багц судалгаа
- Бага боловсролын сургалтын хөтөлбөр: сайжруулсан 2 дахь хэвлэл, УБ2019
- Суурь боловсролын сургалтын хөтөлбөр, УБ2019

- Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, сайжруулсан 2 дахь хэвлэл, УБ2019
- Karip, E. 2006. Turkey: management of curriculum change and implementation. *Current and Future Challenges in Curriculum Development: Policies, Practices and Networking for Change*. A. Crisan (ed.), Bucharest, Editura Educatia 2000+/Humanitas Educational/UNESCO International Bureau of Education.
- Bognár, M. 2006. Curriculum changes in Hungary – Challenges of continuous learning. *Current and Future Challenges in Curriculum Development: Policies, Practices and Networking for Change*. A. Crisan (ed.), Bucharest, Editura Educatia 2000+/Humanitas Educational/UNESCO International Bureau of Education.
- Kataro, A. 2011. Curriculum review of advanced level secondary education in Tanzania. Geneva, Switzerland, UNESCO International Bureau of Education. (Diploma in Curriculum Design and Development [IBE/ UCU/OREALC] Cohort 2010/11.)



Бүтээгдэхүүн

1. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөлт
2. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үйл явц, үр дүн бүхий сургуулийн танилцуулга
3. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн нөхцөл байдал (сурагчийн сурлагын амжилт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн хүчин зүйлс гэх мэт)
4. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөр

МОДУЛЬ 7. ҮНДЭСНИЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ҮНДЭСЛЭСЭН СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХӨГЖИЛ



Модулийн зорилго

Боловсролын шийдвэр гаргагчид, сурган хүмүүжүүлэгчид, мэргэжилтнүүд, сургалтын хөтөлбөр боловсруулагчид, хэрэгжүүлэгчид, сургалтын хөтөлбөрийн оролцоотой бусад хэрэглэгчдэд үндэсний сургалтын хөтөлбөрт үндэслэн сургуулийн хөтөлбөрийг хөгжүүлэх, боловсруулахад жишиг санаа, дэмжлэг үзүүлэхэд оршино.



Хэрэгжүүлэх хугацаа

Үндэсний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсний дараагийн жилээс сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх менежмент зохион байгуулалт хийгдэнэ.



Энэхүү модулаар шинэ сургалтын хөтөлбөрийг тодорхой нөхцөл байдалд нутагшуулах, сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг удирдах, төвлөрлийг сааруулах үйл явц зэрэг хүчин зүйлс, сургуулийн практикт сургалтын хөтөлбөрийг боловсруулах боломжит загваруудыг санал болгоно.

Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөр гэдэг нь үндэсний хөтөлбөрөөр олгох боловсрол, сургалтыг дэмжих үйл ажиллагаа, сургууль дотооддоо зохицуулах цаг, сургуулийн арга хэмжээ зэргийг бүгдийг хамруулан ойлгоно.

“Hidden Curriculum” /Далд сургалтын хөтөлбөр/ сургуулийн орчин, соёлын нөлөөгөөр суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар, үнэт зүйлсийг илэрхийлэх сургалтын хөтөлбөр юм.

Жишээлбэл, хоггүй сургууль нь гэр орон, өрөөндөө цэвэрхэн суух хэвшилтэй, байгаль орчинд санаа тавьдаг суралцагч болж хүмүүжихэд нөлөөлнө. Хэрэв сургууль хогтой бол хог хаях зуршилтай болж гэрийн болон өрөөний цэвэрлэгээнд хойрго, байгаль орчин сүйтгэсэн ч санаа зовдоггүй хүн болж магадгүй. Энэ ч гэсэн сургуулиас олгож буй боловсролын нэг хэлбэр юм.

Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөр яагаад хэрэгтэй вэ?

Үндэсний хэмжээнд мөрддөг сургалтын хөтөлбөр нь зарим суралцагчийн эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чаддаггүй. Тэдэнд амьдарч буй газар нутгийнхаа байгаль орчин, цаг уур, нийгэм, соёлын өвөрмөц онцлог, хөгжлийн тулгамдсан асуудлыг судлах хэрэгцээ сонирхол байдаг. Тухайн сургууль байгууллагад бий болсон соёл, багш нарын бүтээсэн арга зүйн онцлог, туршлагыг уламжлан хөгжүүлэх хэрэгцээ үүсдэг.

Орон нутгийн түвшинд сургууль нь төрийн болон иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй өргөн хүрээнд түншлэн, хамтарч ажиллах хэрэгцээ бий болдог.

Сурагчдын суралцахуйг зөвхөн анги танхимын уламжлалт сургалт гэж үзэх өрөөсгөл болсон. Анги танхимаас гадуур суралцах өргөн боломж байдаг.

Энэхүү сургалтын модулийн үйл ажиллагаа нь сургалтын хөтөлбөр боловсруулагчид, хэрэгжүүлэгчдэд сургуулийн засаглал, менежменттэй холбоотой бодлого, үйл явцын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэхэд тусална. Тухайлбал,

1. Үндэсний болон орон нутгийн хэрэгцээ, ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх: Янз бүрийн оролцогч талуудын хэрэгцээ, ашиг сонирхлыг тусгаж, дэмжлэг авч, сургалтын хөтөлбөрийг хүлээн зөвшөөрөгдөхүйц хэрэгжүүлэхэд чиглүүлнэ.

2. Сургалтын хөтөлбөрийг нутагшуулах, сорилт, боломжууд: Нутагшуулалтын үйл явцыг хязгаарлаж буй хязгаарлалтууд болон боломжит шийдлүүдийн талаар эргэцүүлэн бодох.
3. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах: Сургууль бүр өөрийн дагаж мөрдөх үзэл баримтлалд тулгуурлан сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх.
4. Сургалтын хөтөлбөрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх: сургуулийн хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой баримт бичиг, кейс судалгаа, нэмэлт унших материалыг агуулсан баримт нотолгоо байна.

Судлаачдын зарим бүтээлээс үзэхэд: Сургуулийн сургалтын хөтөлбөрийг сургууль дээр төвлөрч боловсруулж, хэрэгжүүлдэг боловч нийгмийн хүрээг хамардаг. Тухайлбал, төв болон орон нутгийн байгууллага, засаг захиргаа, сургуулиудын дунд үүрэг хариуцлагыг хуваарилах замаар, сургууль, багш нар сургуулийн хүрээнээс гадуурх нөөц, хүн хүчийг ашиглаж болдог (Huang Zhengjie, 1985). Сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах нь "доод түвшнээс эхлэн" "оролцоо"-нд тулгуурладаг онцлогтой. Энэ нь багш, сурагчдын туршлага дээр суурилсан хамтын бүтээл, шийдвэр бөгөөд үүгээрээ боловсролын философи болохын зэрэгцээ сургалтын удирдлага, сургалтын шинэчлэлийн арга юм (Марш нар, 1990). Иймд сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхэд янз бүрийн оролцогч талууд (орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгэм, эцэг эх, орон нутгийн хамт олон)-ыг өргөнөөр оролцуулах шаардлагатай нь харагдаж байна. Орон нутаг, сургуулийн нөхцөл байдалд үндэслэн алсын хараа, сургалтын үндсэн чиглэлийг боловсруулах замаар стратеги төлөвлөгөөг боловсруулж, бие даасан байдлаа хадгалж, агуулгыг хэрхэн заах талаар шийдвэр гаргахын тулд багш бүрийн оролцоо, хамтын үйл ажиллагаанд тулгуурлан хөгжүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох нь чухал юм. Энэ нь тухайн сургуулийн туршлагыг нэвтрүүлэхэд багшийг манлайлалтай оролцох боломжийг бүрдүүлж өгөхөд оршино.

Практикаас харахад зарим улс оронд үндэсний сургалтын хөтөлбөрт суурилсан орон нутгийн болон сургуулийн түвшинд хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах санаачилгыг дэмждэг. Боловсролын нарийн зохицуулалт бүхий тогтолцоо нь сургуулиудад сургалтын хөтөлбөрийн асуудлаар тодорхой хэмжээний бие даасан байдлыг олгодог ба орон нутгийн болон сургуулийн түвшинд шийдвэр гаргахыг хүлээн зөвшөөрдөг. Сургуулиудын бие даасан байдлынхаа хүрээнд боловсруулж хэрэгжүүлэх хөтөлбөрүүд хоорондоо ялгаатай байдаг. Зарим сургууль ердийн хичээлийн судлах хугацааг сунгахыг илүүд үздэг бол зарим нь тухайн орон нутгийн сонирхсон сэдэвтэй холбоотой салбар дундын сэдвийг судалж хөгжүүлдэг. Сургуулийн түвшинд сургалтын хөтөлбөр боловсруулахдаа дараах хувилбарыг ашиглаж болно: Үүнд:

- Одоо байгаа боловсролын хөтөлбөрүүдийг сонгох, өөрчлөх, ижил төрлийн хичээлүүдээс судлах сэдвүүдийг нэг хичээлд нэгтгэх,
- Тодорхой үзэгдэл, асуудлыг салбар дундын хандлагаар судлах, шинээр бий болгох,
- Сургалтын нэгжүүд нь одоо байгаа сургалтын хэрэглэгдэхүүнд нэмэлт, эсвэл шинэ сургалтын нэгж бий болгох,
- Орон нутгийн сонирхлыг татсан сэдвүүдийг тодорхой нэг сэдвийн хүрээнд, эсвэл хэд хэдэн төрөл зүйлийн нэгдмэл хичээлээр авч үзэж болно.

Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулахад нөлөөлдөг зарим хүчин зүйлүүд нь:

1. Үндэсний боловсролын зорилго, философи: сургуулиуд нь боловсролын үндэсний бүтэцчилсэн хүрээ, түүний зорилгыг тусгасан сургалтын хөтөлбөрийг боловсруулах, боловсролын философи, улс төрийн үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрдөг.
2. Төвлөрсөн сургалтын хөтөлбөрийн тодорхойлолт: сургуулиудад сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийг оруулахгүй байх, эсвэл албан ёсоор

зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөрийг өөрчлөн зохион байгуулах эрх мэдэл байдаггүй. Тэд шаардлагатай нэмэлт нөөцийг авч үзэх ёстой бөгөөд энэ нь улсын сургуулиудад ихэвчлэн боломжгүй байдаг.

3. Сургуульд байгаа нөөцүүд: сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагааны сонголт нь өрөөний зай, материал, боловсон хүчин зэрэг нөөц боломжоор хязгаарлагддаг. Өрөөний орон зай нь лаборатори, номын сан, нөөцийн төвүүдийг хэлдэг бол материаллаг нөөц гэдэгт сурах бичиг, багаж хэрэгсэл, компьютер хамаарна. Хүний нөөц гэдэг нь сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан зорилтод нийцсэн тодорхой чадамжтай багш нар, сургагч нарыг багтаан ойлгоно.

Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх менежментийн загварууд байдаг. Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд сургалтын байгууллагын менежментийг сайжруулах зорилгоор “Сургуулийн менежментийн нэгдсэн зураглал”-ыг PDCA (Plan-Do-Check-Action) загварын дагуу боловсруулж хэрэгжүүлэхийг санал болгосон. PDCA нь бизнест үйл явц, бүтээгдэхүүнийг хянах, тасралтгүй сайжруулахад ашигладаг давтагдах загвар, удирдлагын арга юм. Харин боловсролын салбарын хувьд сургалтын байгууллагын тухайн жилд дэвшүүлсэн зорилго, зорилт, одоогийн нөхцөл байдал, дэвшүүлсэн зорилгод хүрэхийн тулд гүйцэтгэх үйл ажиллагаа зэргийг тодорхой илэрхийлсэн зураглал юм.

Сургуулийн менежментийн өөр нэг загвар бол ЮНЕСКО-оос санал болгосон Whole school approach (WSA) буюу сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага (СБААХ) юм. “Тогтвортой хөгжлийн боловсрол-2” төсөлд хамрагдан жижиг төсөл хэрэгжүүлж байгаа 30 сургууль нь СБААХ-ыг сургуулийнхаа менежментэд нэвтрүүлэн “Тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургууль” болохыг зорин ажиллаж байна.

Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага нь тогтвортой байдлыг сургуулийн амьдралын бүхий л хүрээнд, үйл ажиллагааны салаа мөчир бүрд бий болгох зориулалттай. Тухайлбал, энэ арга хандлага нь сургуулийн засаглал, менежмент, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааг хянан зохицуулах механизмууд, судалгаа шинжилгээ, хүний нөөцийн хөгжил болон сургалтын хөтөлбөр, сургуулийн дэд бүтцийн ажиллагаа, суралцагчдын оролцоо, олон нийттэй харилцах харилцаа, түншлэл, хамтын ажиллагаа, байгууллагын соёл, үнэл зүйлс зэрэг бүх зүйлийг хамарна. (ЮНЕСКО, 2014а)

СБААХ-ыг сургуулийн менежментэд нэвтрүүлнэ гэдэг нь сургуулийн менежментэд зөвхөн тогтвортой байдлыг интеграцчилах төдийгүй илүү их цар хүрээтэй үйл ажиллагаанд шилжихийг шаардана. СБААХ нь орон нутгийн болон дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн сорилт бэрхшээл, тэдгээрийг даван туулах арга ухааныг бүх хичээлийн хөтөлбөрт тусган суралцахуйг эрэл хайгуул, бүтээлч үйлийн шинжтэй болгох; сургуулийн болон орон нутгийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд суралцагч, багш ажилтан, эцэг эх, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх; барилга байгууламж, кампусын тогтвортой ажиллагааг хангаж, суралцахуйн тогтвортой орон зайг бий болгох, тухайлбал нөөцийг үр ашигтай ашиглах, эрүүл хоол хүнс, ногоон байгууламж бий болгох зэрэг харилцан хамааралтай, цогц үйл ажиллагаа юм.

Хүснэгт 7.1. Модуль 7-ын үйл ажиллагаа ба хэрэгжүүлэх даалгавар

Үйл ажиллагаа	Даалгавар	Бүтээгдэхүүн
Үйл ажиллагаа 1. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн хөгжил	Даалгавар 1. Сургуулийн нөхцөл байдлыг тодорхойлох	1. Сургуулийн өөрийн үнэлгээний хуудас
	Даалгавар 2. Сургуулийн тулгамдсан асуудлыг тодорхойлох	2. Сургуулийн тулгамдсан асуудлыг эрэмбэлсэн жагсаалт
	Даалгавар 3. Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго тодорхойлох	3. Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго
	Даалгавар 4. Сургуулийн менежментийн загвар, агуулгын залгамж холбоо гаргах	4. Судлагдахууны агуулгын залгамж холбооны матриц
	Даалгавар 5. Хичээл үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт хийх	5. Судлагдахуун хоорондын агуулгын залгамж холбооны матриц
	Даалгавар 6. Хүний нөөцийн чадавхийн хөгжлийг дэмжих	6. Хүний нөөцийн чадавхийг дэмжих сургуулийн менежментийн зураглал, сургуулийн хөгжлийн төлөвлөгөө
Үйл ажиллагаа 2. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх сургуулийн менежмент	Даалгавар 1. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах	7. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн бүтэц дизайн
	Даалгавар 2. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургууль ба сургалтын орчныг зураглах	8. Сургуулийн орчны зураглал
	Даалгавар 3. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшлахуйг хувирган өөрчлөх	9. Жил, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөгөө
	Даалгавар 4. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтын ажиллагаа, түншлэлийн чиглэл гаргах	10. Сургуулийн гадаад дотоодын байгууллагатай хамтран ажиллах чиглэл
Үйл ажиллагаа 3. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн хяналт-шинжилгээ үнэлгээ	Даалгавар 1. Сургуульд суурилсан хичээлийн судалгаа	11. Хичээл ажиглалтын хуудас
	Даалгавар 2. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	12. Багш нар хамтран ажиллахад зориулсан аргачлал
	Даалгавар 3. Сургуулийн соёл бий болгох	13. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн танилцуулга
		14. Сургуулийн тайлангийн загвар
3 үйл ажиллагаа	6+4+3=13 даалгавар	12 бүтээгдэхүүн

Үйл ажиллагаа 1. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн хөгжил



Зорилго. Сургуулийн хөгжлийн түүх, сургамж, давуу болон сул талуудыг судалж дүгнэх, тулгамдсан асуудлыг тодорхойлж, алсын хараа, эрхэм зорилгоо тодорхойлох, grand design болон хичээл үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт гаргахад дэмжлэг үзүүлэхэд оршино.



Даалгавар 1. Сургуулийн нөхцөл байдлыг тодорхойлох

Сургууль бүр гарааны цэгээ тодорхойлох нь дараагийн зорилго, зорилтоо төлөвлөх эхний алхам юм.

Энэхүү даалгавраар сургуулийн нөхцөл байдлыг тодорхойлох асуулга боловсруулна. Сургуулийн нөхцөл байдлыг тодорхойлох асуулгад сургуулийн манлайллын нөхцөл байдлын талаар эргэцүүлэн бодох, ярилцах, цаашдын чиг хандлагын талаарх асуултуудыг агуулсан байна. Санал асуулгад сургуулийн манлайллыг сайжруулахын тулд сургуулийн одоогийн нөхцөл байдал болон тэдний чухал гэж үзэж буй зүйлсийн хоорондын зөрүүг шинжлэх, давуу, сул тал болон цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлж тусгана.

Санал асуулгын үр дүнд тулгуурлан сургууль бүр өнгөрсөн хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагаа, сурагчдын сурлагын үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж гаргана.

Сургалтын үйл ажиллагаа, суралцагчийн суралцахуй, багшийн заах арга зүйд гарсан нөхцөл байдлыг илрүүлэхийн тулд илүү нарийвчилсан хяналтын хуудсыг боловсруулан хэрэглэж болно.

Санал асуулгыг боловсруулахдаа СБААХ-ын өөрийн үнэлгээний асуулгын хуудсыг *жишээ байдлаар* ашиглаж болно.



Уншиж судлах материал:

- ТХБ-II төсөл. (2020). "Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага ба өөрийн үнэлгээний арга зүй" Багц гарын авлага 1
- БСШУЯ. (2019). "Цэцэрлэг, ЕБС-ийн үйл ажиллагааг үнэлэх журам". БСШУС-ын сайдын 2019 оны А/803 тушаалын хоёрдугаар хавсралт.
- МХЕГ. (2020). "Ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас". МХЕГ-ын даргын 2020 оны А/32 тушаалын хавсралт.
- БСШУСЯ, Д.Б. (2019). "Боловсролын салбарт нийгмийн эгэх хариуцлыг бэхжүүлэх нь" Гарын авлага
- SDC, DDLGN (2017). "SDC's Approach to Governance". Sustainability and Education Academy. "Domain Framework for Whole System Approach to ESD". Canada WWF. (2014). "Whole School Approach Manual". India



Даалгавар 2. Сургуулийн тулгамдсан асуудлыг тодорхойлох

Сургуулийн тулгамдсан асуудлыг тодорхойлох арга замуудыг дэвшүүлэх нь энэ даалгаврын зорилго юм. Тухайлбал,

- сургуулиуд улсын болон анги дэвших шалгалтын үр дүнд шинжилгээ хийх
- суралцагчдын тааруу үнэлгээ авсан сэдэв, даалгаврыг тодорхойлон сурагчдын буруу хариултад шинжилгээ хийх
- тэдний суралцах чадвар, багшийн арга зүйд тулгамдаж буй асуудлын учир шалтгааныг анги тус бүрээр илрүүлэх
- сургуулийн удирдах ажилтан, багш, ажилтнууд хамтран өнгөрсөн хичээлийн жилийн сургуулийн зорилго биелэсэн эсэхийг хэлэлцэж асуудлаа илрүүлэх



Хамтарсан шийдвэр гаргах үйл явц:
Байгууллагын тодорхой төвлөрөл, ихэвчлэн сайн тодорхойлсон алсын хараа, зорилгын эргэн тойронд төвлөрдөг;
Инноваци, туршилтын заах арга зүйг ашиглах хурдасгуур болох бүтээлч хөгжлийн орон зайг бий болгодог;
Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг дэмжих үндэслэлд дараах зүйлс орно.

- ✓ Суралцагчид болон сургуулийн хамт олны хэрэгцээ, асуудал, зорилго, сонирхолд нийцсэн суралцах боломж, туршлагыг нэмэгдүүлэх;
- ✓ Суралцагчдын суралцах туршлагад орон нутгийн нөөцийг тодорхойлж, тусгах;
- ✓ Багш нарын уян хатан байдал, бүтээлч байдлыг нэмэгдүүлэх, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны шинэ санаа бодлыг тохируулсан сургалтын хөтөлбөр;
- ✓ Сургуулийн хамт олны шийдвэр гаргах үйл явцад ардчилсан туршлагыг нэвтрүүлэх;



Даалгавар 3. Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго тодорхойлох

Даалгавар 2-ийн үр дүнд тулгуурлан сургуулийн алсын хараа, эрхэм зорилго тодорхойлох арга замуудыг дэвшүүлнэ.

- сургууль тулгамдаж буй асуудлаа илрүүлсний дараа зорилгоо эргэж сайжруулах
- сургуулийн зорилгоо тодорхойлохдоо багш, суралцагч, гэр бүл, орон нутаг, тэдгээрийн нөхцөл байдал хийгээд сургуулийн асуудалд нийцүүлэн тодорхойлох гэх мэт



Уншиж судлах материал:

- ТХБ-II төсөл. (2020). “Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага” Багц гарын авлага 3. Хүний нөөцийн чадавхын хөгжил
- Сако Хидэказү. Сургуулийн менежмент. Сургуулийн судалгаа, хөгжлийн “Шинэ Монгол” төв
- БСШУСЯ., Жайка төсөл. (2018). Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал. УБ



Даалгавар 4. Сургуулийн менежментийн загвар болон агуулгын залгамж холбоо гаргах

Сургуульд хамааралтай бүх хүмүүс сургуулийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар нэгдмэл ойлголттой болох нь чухал бөгөөд үүний тулд “Сургуулийн менежментийн нэгдсэн зураглал”-ыг сургуулийн менежментийг сайжруулах PDCA (Plan-Do-Check-Action) загварын дагуу боловсруулна.



Сургуулийн менежементийн загвар гэдэг нь тухайн жилийн сургуулийн зорилго, зорилтууд болон түүнд хүрэх үйл ажиллагаа, мөн зорилго тодорхойлсон үндэслэл, нөхцөлийг товч тодорхой илэрхийлсэн зураглал юм.

Сургуулийн менежментэд дараах ойлголтуудыг багтаан төлөвлөнө. Үүнд:

- Төрөөс баримтлах бодлого – Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн жилд дэвшүүлсэн зорилго, зорилтод тусгагдсан боловсролын зорилгыг хэрэгжүүлэхээр тусгана.
- Тулгамдсан асуудал – Өнгөрсөн жилийн тулгамдсан асуудлыг тодорхойлохдоо шалгалтын үр дүнд шинжилгээ хийн, дэвшүүлсэн зорилго үйл ажиллагааны биелэлтийн явц, биелүүлээгүй ажлын талаар хэлэлцэж гол асуудлаа тодорхойлно.
- Хүсч буй хүүхдийн дүр төрх – Тухайн хичээлийн жилд дэвшүүлсэн зорилго биелэхийн цагт ямар хүүхэд бэлтгэгдсэн байх дүр, төрхийг бодитой ойлгомжтой байдлаар илэрхийлнэ.
- Сургуулийн зорилго – Тухайн хичээлийн жилд багш, ажилтан хамтдаа зөвхөн сурагчдад чиглэсэн зорилгын төлөө хичээл, үйл ажиллагаагаа явуулах байдлаар тодорхойлно.
- Тэргүүлэх зорилтууд – Сургуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай чухал асуудлуудаа логикийн зөв дараалалтай тодорхойлно.
- Сургуулийн үйл ажиллагаа – Сургуулийн зорилгыг хэрэгжүүлэхээр тэргүүлэх зорилт бүрээр тодорхой хийгдэх бодит үйл ажиллагаануудыг сурагчдын суралцахуйг дэмжих байдлаар төлөвлөнө.
- Үнэлгээний шалгуур – Сургуулийн зорилго, тэргүүлэх зорилтууд, үйл ажиллагааны үр дүнг үнэлэх шалгуурыг багш бүрийн хичээл, сургалтын үйл ажиллагаагаар тасралтгүй сайжрах боломжтойгоор боловсруулна.

Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн хувьд сургуулийн соёл, нэгдсэн бодлого давамгайлах бол хичээлийн хөтөлбөрийн хувьд хөтөлбөрүүдийн нэгдмэл зарчим, хичээл хоорондын холбоог түлхүү анхаарч үзэх нь чухал²

Агуулгын залгамж холбоо нь судлагдахууны нэгж хичээлийн залгамж холбоог (суралцах холбоос) харуулсан хүснэгт юм. Хичээлүүдийг хооронд нь холбох “шүхэр” болж чадах ТХБ-ын өргөн хүрээтэй сэдэв нь өөрчлөлт, нарийн төвөгтэй байдал, тодорхой бус байдал, эсвэл олон талт байдалд анхаарч болно.



Уншиж судлах материал:

- UNESCO. 2002. *ICT in Education: A Curriculum for Schools and Programme of Teacher Development*. Paris
- Government of Australia Quality Teacher Programme and Association of Independent Schools of South Australia (AISSA). 2006. *Government of Australia Quality Teacher Programme strategic plan*. Canberra, Government of Australia.
- Пүрэвдорж. Ч. 2013. *Багшлахуйн менежмент*. 267-306 дахь тал
- МННХ. 2001. *Сургуулийн шинэчлэл*. УБ
- Сако Хидэказү. *Сургуулийн менежмент*. *Сургуулийн судалгаа, хөгжлийн “Шинэ Монгол” төв*

² ТХБ-II төсөл. Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага: Багц гарын авлага 4. Сургалтын хөтөлбөр: Багшлахуй, суралцахуй



Даалгавар 5. Хичээл, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт хийх

“Сургуулийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө” нь анги тус бүрээр, судлагдахуунаар ямар нэгж хичээлийг хэзээ, хэр хугацаанд заах вэ гэдгийг тусгасан төлөвлөгөө юм. Мөн сургалтыг дэмжих үйл ажиллагааны цаг, сургуулийн хэмжээнд шийдвэрлэх агуулга, сургууль дээр зохион байгуулах арга хэмжээ зэргийг тусгана. Судлагдахуун хоорондын холбоо ба жилийн турш зохион байгуулагдах үйл ажиллагаа, сургуулийн арга хэмжээ ба судлагдахуун хоорондын хамаарал, заах агуулга ба өдөр тутмын сургууль дээр өнгөрөөх цаг хоорондын хамаарал, сургуулийн менежментийн нэгдсэн зураглал/загвараар дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд хийх үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө байх бөгөөд 1 жилийн турш хэрэгжүүлсний дараа сургуулийн зорилго ба үйл ажиллагаа нь биелэгдсэн байхаар тооцож хийнэ.



Уншиж судлах материал:

- Пүрэвдорж. Ч. 2013. *Багшлахуйн менежмент. 267-306 дахь тал*
- МННХ. 2001. *Сургуулийн шинэчлэл. УБ*
- Сако Хидэказү. *Сургуулийн менежмент. Сургуулийн судалгаа, хөгжлийн “Шинэ Монгол” төв*



Даалгавар 6. Хүний нөөцийн чадавхийн хөгжлийг дэмжих

Хүний нөөцийн чадавхийг дэмжих сургуулийн менежментийн зураглал, сургуулийн болон багшийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах нь энэ даалгаврын зорилго юм. Багшийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөг хаяг, үндсэн төлөвлөлт, баталгаажилт гэсэн үндсэн 3 хэсэгт тулгуурлан боловсруулах аргачлал, ямар үе шатаар хэрхэн төлөвлөх арга замыг тодорхойлно. Багшийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах талаар онлайн эх сурвалжийг уншиж танилцана уу.



Уншиж судлах материал:

- БСШУСЯ, Д.Б. (2019). “Боловсролын салбарт нийгмийн эгэх хариуцлыг бэхжүүлэх нь” *Гарын авлага*
- SDC, DDLGN (2017). “SDC’s Approach to Governance”. *Sustainability and Education Academy. “Domain Framework for Whole System Approach to ESD”. Canada WWF. (2014). “Whole School Approach Manual”. India*
- ТХБ-II төсөл. (2020). “Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага” *Багц гарын авлага 3. Хүний нөөцийн чадавхын хөгжил*
- <https://www.highspeedtraining.co.uk/hub/wp-content/uploads/2017/09/compressed-professional-development-planexample-template-high-speed-training.pdf>
- *Professional Development Plan*
- *Writing A Professional Development Plan – Example & Template.*



Бүтээгдэхүүн:

1. Сургуулийн өөрийн үнэлгээний хуудас
2. Сургуулийн тулгамдсан асуудлыг эрэмбэлсэн жагсаалт
3. Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго
4. Судлагдахууны агуулгын залгамж холбооны матриц

5. Судлагдахуун хоорондын агуулгын залгамж холбооны матриц
6. Хүний нөөцийн чадавхийг дэмжих сургуулийн менежментийн зураглал, сургуулийн хөгжлийн төлөвлөгөө

Үйл ажиллагаа 2. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх сургуулийн менежмент



Зорилго: Орон нутгийн болон суралцагчийн бодит байдлыг харгалзсан сургуульд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах цикл үйл ажиллагааг төлөвлөх үйл явцад дэмжлэг үзүүлэхэд оршино.



Даалгавар 1. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах

Үндэсний сургалтын хөтөлбөрт үндэслэн сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулахад дагаж мөрдөх алхмуудыг тодорхойлно. Тодорхойлохдоо дараах нийтлэг бүтцийг баримтална. Үүнд:

Сургуулийн бие даасан байдлыг хөгжүүлэх арга зам нь сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх явдал юм.

Үндэслэл

Энэ үе шатанд суралцагчид болон сургуулийн хамт олны хэрэгцээ, түүнчлэн бие бялдар, материаллаг ба хүний нөөцийг тодорхойлдог. Энэхүү үйл ажиллагаа нь давуу болон сул талуудын талаар маш тодорхой дүр зургийг олж авах боломжийг олгох зорилготой бөгөөд энэ нь хамтын ойлголцлын үндэс болж, тодорхой бодлого, зорилго, стратеги төлөвлөгөө боловсруулах боломжийг олгоно.

Зорилтууд

Зорилгуудыг тодорхой нэр томъёогоор тайлбарлах ёстой бөгөөд ингэснээр тэдгээр нь тухайн цаг хугацаанд ажиглагдах, хэмжигдэхүйц, биелэх боломжтой байх ёстой. Энэ үе шатанд төлөвлөсөн үр дүнг тодорхойлдог.

Агуулгын зохион байгуулалт

Агуулгыг суралцагчийн төлөв байдлыг харгалзан үзсэний дагуу зохион байгуулдаг. Үзэл баримтлалыг өмнө нь сурсан холбоотой ухагдахууны талаарх мэдлэг дээр тулгуурлах байдлаар зохион байгуулах ёстой.

Сурах туршлагыг сонгох, зохион байгуулах

Суралцагчдын холбогдох туршлагыг энгийнээс нийлмэл рүү, тодорхойгоос хийсвэр лүү тодорхойлсны дараа шатлан эрэмбэлсэн байх бөгөөд сургууль нь тухайн хичээлийн сэдэв, түүний нарийвчилсан түвшин, стандарт эсвэл ангийн түвшин бүрт хэрхэн заахыг санал болгох тал дээр хариуцлага хүлээх ёстой.

Үнэлгээ

Сургуулийн хувьд зорьсон зорилго эсвэл хүссэн үр дүндээ хэр хүрсэн бэ гэдгийг тодорхойлох нь чухал. Иймд сургуульд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцын үе шат бүрт тодорхойлсон зорилтын дагуу үнэлгээний хэрэглүүр үйлдвэрлэж, сурагчдад хэрэглэх шаардлагатай байна.



Уншиж судлах материал:

- *Bolstad, R. 2004. School-Based Curriculum Development: Redefining the Term for New Zealand Schools Today and Tomorrow. (Document presented in the conference of the New Zealand Council for Educational Research [NZCER], Wellington, 24–26 November 2004). <http://www.nzcer.org.nz/system/files/13514.pdf> (Accessed 13 September 2013).*
- *Training Tools for Curriculum Development – Module regarding school-based curriculum. Geneva, Switzerland, UNESCO International Bureau of Education. (In Spanish).*
- *БСШУСЯ, ШХА, & БМДИ. 2018. Тогтвортой хөгжлийн боловсролыг ерөнхий боловсролын сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй (Багшийн гарын авлага). Улаанбаатар: ТХБ төсөл.*
- *Вэсли Нулл. 2011. Куррикулум Хөтөлбөр.*
- *БХ, Жайка. 2019. Сургуулийн хөтөлбөрийн менежментийн аргачлал*



Даалгавар 2. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургууль ба сургалтын орчныг зураглах

Сургуулийн материаллаг болон материаллаг бус орчин нь цогц ойлголт бөгөөд харилцан бие биеэ нөхцөлдүүлж, тодорхойлж байдаг онцлогтой. Тиймээс шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургуулийн орчны нөхцөл байдлыг зураглаж гаргана.

Зураглалыг “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал” ерөнхий шаардлага, “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын орчин, үйлчилгээ”-ий ерөнхий шаардлагад нийцүүлэн хийхэд чиглүүлнэ.



Уншиж судлах материал:

- *SDC, DDLGN (2017). “SDC’s Approach to Governance”. Sustainability and Education Academy. “Domain Framework for Whole System Approach to ESD”. Canada WWF. (2014). “Whole School Approach Manual”. India*
- *БОМСТ. (2020). Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага гарын авлага. Сургууль ба сургалтын орчин. 10, 17 дахь тал*



Даалгавар 3. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшлахуйг хувирган өөрчлөх

Багшлахуйг хувирган өөрчлөхийн гол суурь хичээлийн бэлтгэл, тэр дундаа жил нэгж ээлжит хичээлийн төлөвлөлтийг чанартай сайн гүйцэтгэх бөгөөд анги, хичээл дээрх багш, сурагчийн хамтын үйл ажиллагааг “багш хэрхэн зааж, багш хэрхэн хичээлийг явуулах” гэсэн ганцхан талаас хандахгүй, харин “суралцагч хэрхэн сурдаг” талаар бодож төлөвлөхөд чиглэнэ.

Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш жил, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтөө хэрхэн хийх арга аргачлал, загвар бүтцийг энэхүү даалгаврын хүрээнд хийж гүйцэтгэнэ.



Уншиж судлах материал:

- *SDC, DDLGN (2017). “SDC’s Approach to Governance”. Sustainability and Education Academy. “Domain Framework for Whole System Approach to ESD”. Canada WWF. (2014). “Whole School Approach Manual”. India*

- БОМСТ. (2020). Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага гарын авлага. Сургууль ба сургалтын орчин. 10, 17 дахь тал
- БСШУЯ, 2003. Бага, дунд боловсролын стандартын ерөнхий зөвлөмж, хууд. 11. Улаанбаатар
- БСШУЯ. Тогтвортой хөгжлийн боловсрол, мэргэжил дээшлүүлэх модульт хөтөлбөр
- Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр



Даалгавар 4. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтын ажиллагаа, түншлэлийн чиглэл гаргах

Даалгаврын зорилго нь гадаад, дотоодын хамтран ажилладаг байгууллагуудтай төрийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэхэд нээлттэй, тэгш, харилцан ашигтай, хамтын хариуцлагатай, үр өгөөжтэй, үр дүнд баримжаалсан “ГЭРЭЭ” хийхэд чиглэгдэнэ. Түншлэлийн гэрээ нь орон нутгийн захиргааны байгууллага, сургууль нь олон нийтэд нутгийнхаа байгаль-экологийн тэнцвэрийг хангах, хүүхэд залуучуудад соёлын онцлог, бусдаас ялгарах дүр төрхийг бий болгож, нүүдэлчин соёл, өв уламжлалыг таниулах өргөн хэмжээний хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах, цэцэрлэгжилт сайтай үлгэр жишээ гудамж, талбайтай болж, хүүхдүүдэд экологийн боловсрол төлөвшүүлэхэд чиглэсэн байна.



Уншиж судлах материал:

- Global Humanitarian Platform, 12 July 2007
- Local Government and School Partnerships State Government Victoria, <http://www.eduweb.vic.gov.au/edulibrary/public/propmanfacility/SACF>
- ТХБ-II төсөл. (2020). “Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага” Багц гарын авлага 6. Түншлэл
- Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт -2030
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- Монгол Улсын Засгийн Газрын Гурван тулгуурт хөгжлийн бодлого
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Төр, хувийн хэвшлийн талаар төрөөс баримтлах бодлого
- Тогтвортой хөгжлийн төлөөх боловсрол үндэсний хөтөлбөр
- Төр, иргэний түншлэл, Марк Грамбергэр, Монголын нээлттэй нийгэм форум, 2001
- Humanitarian reform: Principles of partnership, 2010
- Global Humanitarian Platform, 12 July 2007
- UNESCO. (2015). A Guide for Gender Equality in Teacher Education Policy and Practices. UNESCO.
- БСШУС-ын сайдын 2019 оны А/119 тушаал
- Schools as Community Facilities: Policy Framework and Guidelines
- <http://www.education.vic.gov.au/management/infrastructure/facilitypartner.htm>
- <https://improvement.nhs.uk/documents/2143/conventional-process-mapping.pdf>



Бүтээгдэхүүн:

1. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн бүтэц дизайн гарна.
2. Сургуулийн орчны зураглал
3. Шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн ба нэгж, ээлжит хичээлийн төлөвлөгөө
4. Сургуулийн гадаад дотоодын байгууллагатай хамтран ажиллах чиглэл

Үйл ажиллагаа 3. Сургуулийн суурилсан хөтөлбөрийн хяналт- шинжилгээ, үнэлгээ



Даалгавар 1. Сургуульд суурилсан хичээлийн судалгаа хийх

Сургуульд суурилсан хичээлийн судалгаа нь сургууль бүр сургалтын чанар, суралцахуй ба багшлахуйд тулгамдаж буй асуудлыг илрүүлж, түүнийг хамтдаа шийдвэрлэх зорилготой сургуулийг бүхэлд хамардаг үйл ажиллагаа юм.

Даалгавраар хичээлийн судалгааг хэзээ, хэн, ямар хүрээнд зохион байгуулах урьдчилан төлөвлөгөө, хичээл ажиглалтын хуудсыг боловсруулна.

Даалгаврыг чиглүүлэхдээ судлаач Макото Ёшидагийн Японд зохион байгуулагдаж байгаа хичээлийн судалгааг хэлбэр, хамрах хүрээгээр нь сургууль дээрх, сургууль хоорондын гэж хоёр ангилж үзсэн ангилалыг санал болгож болно. Үүнд:

1. Сургууль дээрх (In school)
 - Хэд хэдэн хичээлийн багш нарын нэгдсэн бүлэг (Whole group)
 - Тодорхой хичээлийн багш нарын бүлгүүд (Content-area study groups)
2. Сургууль хоорондын (Across schools)
 - Бүс хооронд зохион байгуулсан (Regionally organized)
 - Шинэ багш нарт зориулсан сургалтаар зохион байгуулсан (Part of mandated beginning teacher education)
 - Сайн дурын үндсэн дээр байгуулагдсан клуб, дугуйлангаас зохион байгуулсан (Voluntarily organized clubs and circles)
 - Боловсролын байгууллага, нийгэмлэг болон холбоодоос зохион байгуулсан (Organized by educational associations and institutions)



Уншиж судлах материал:

- Modified from sources: What to Consider When Writing a Lesson Plan
- Багшлахуйн хөгжил: Хичээлийн судалгааны арга зүйн үндэс, 2013 он



Даалгавар 2. Сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

Хэрэгжилтэд “үр дүнд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээ”-г дараах асуултуудын хүрээнд хэлэлцэж, хөтөлбөрийн үр дүнд шинжилгээ хийх хяналтын хуудсыг боловсруулж болно. Үүнд:

- Бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийн явц, хяналт шинжилгээ үнэлгээний дүн, бусад мэдээлэл хэр нээлттэй, шуурхай байна вэ?
- Хэрэгжилтийн үр дүн, үр өгөөж, үр ашгийг оновчтой тооцож, ахиц дэвшлийг тодорхойлон, шаардлагатай зохицуулалтыг цаг тухайд нь хийж чадаж байна уу?
- Суралцагчдыг дэлхийн иргэн болгон хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийн үр дүн ямар байна вэ?
- Хүн бүр хүлээсэн үүрэг, хариуцсан ажлаа бүтээлчээр, санаачилгатай гүйцэтгэж хэвшсэн үү?



Уншиж судлах материал:

- O'Donnell, S. 2004. *International Review of Curriculum and Assessment Frameworks: Comparative tables and factual summaries – 2004, 14th edn.* London, Qualifications and Curriculum Authority and National Foundation for Educational Research. <http://www.inca.org.uk/pdf/comparative.pdf>
- Sinnema, C. 2011. *Monitoring and Evaluating Curriculum Implementation – Final Evaluation Report on the Implementation of the New Zealand Curriculum 2008-2009.* Auckland, New Zealand, University of Auckland

- Пүрэвдорж. Ч. 2013.Багшлахуйн менежмент. 267-306 дахь тал
- МННХ. 2001. Сургуулийн шинэчлэл.УБ
- Сако Хидэказү. Сургуулийн менежмент. Сургуулийн судлагаа, хөгжлийн “Шинэ Монгол” төв
- БСШУСС-ын 2019 оны А/528 дугаар тушаал - Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэл
- БСШУСС-ын 2019 оны А/803 дугаар тушаал - Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам
- БСШУСС-ын 2019 оны А/119 дугаар тушаал - Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлах үлгэрчилсэн чиглэл
- БХ, Жайка. 2019. Сургуулийн хөтөлбөрийн менежментийн аргачлал



Даалгавар 3. Сургуулийн соёл бий болгох

Сургууль өөрийн онцлогт үндэслэн багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагч зэрэг сургуульд хамааралтай хүмүүст нийтлэг байх үзэл санаа, үйл хөдлөлийн хэв шинжийг тодорхойлж гаргана. Даалгавраар сайн сургуулийг бүтээхийн тулд дээрээс доошоо чиглэлтэйгээр мэдээллийг дамжуулах бус багшаас эхлээд сургуульд хамааралтай хүмүүсийн арга ухааныг нэгтгэн, хамтын ажиллагаа чухал гэдгийг ойлгуулахад чиглэнэ.



Бүтээгдэхүүн:

1. Хичээл ажиглалтын хуудас
2. Хяналт шинжилгээний хуудас

МОДУЛЬ 8. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН БА СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ



Модулийн зорилго

Энэхүү модуль нь сургалтын хөтөлбөрийн болон суралцагчийн үнэлгээний үзэл баримтлал, арга зүйг (үнэлгээний зорилт, шалгуур, арга хэрэгсэл, даалгавар зэрэг) тодорхойлж, сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт/шинэчлэлд хэрхэн тусгах санал дэвшүүлэхэд оршино.

Түлхүүр үг:

- Student assessment: - Суралцагчийн үнэлгээ
- Diagnostic assessment-оношлох үнэлгээ
- Pre- assessment- урьдчилсан үнэлгээ
- Formative assessment- явцын үнэлгээ
- Summative assessment- үр дүнгийн үнэлгээ
- Assessment of learning outcomes in specific content areas- Тодорхой судлагдахууны сургалтын үр дүнгийн үнэлгээ
- Assessment instruments and tools -Үнэлгээний арга, хэрэгсэл
- Learning Outcomes- Суралцахуйн үр дүн
- Performance- Гүйцэтгэл
- Curriculum evaluation-сургалтын хөтөлбөрийн үнэлгээ
- Internal Evaluation- Дотоод хяналт үнэлгээ;
- External Evaluation- Гадаад хяналт үнэлгээ.



Хэрэгжүүлэх хугацаа

- *Суралцагчийн үнэлгээ (Student assessment):* Үндэсний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн жилээс сурагчийн сурлагын амжилтын үнэлгээг боловсролын түвшний анги бүрээр бүх судлагдахууныг хамруулан үнэлгээний шалгуураар үнэлж, мэдээллийн сан үүсгэнэ.
- *Тодорхой судлагдахууны сургалтын үр дүнгийн үнэлгээ (Assessment of learning outcomes in specific content areas):* Боловсролын түвшин бүрээр тодорхой судлагдахууны сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээний суралцахуйн хүлээгдэж буй үр дүнг үнэлж, дүн шинжилгээ хийнэ.
- *Үндэсний түвшний сургалтын хөтөлбөрийн үнэлгээ:* Үндэсний хэмжээнд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааг 5 жилд нэг удаа хийж, үр дүнд дүн шинжилгээ хийнэ.
- *Орон нутаг, сургуулийн түвшин дахь сургалтын хөтөлбөрийн үнэлгээ:* Орон нутаг, сургууль бүр жил тутам багшлах туршлагад тулгуурлан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдалд өөрийн үнэлгээ хийж, тайланг нэгтгэн танилцуулга хийнэ.



Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн үнэлгээ нь боловсролын чанар болон сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, хичээл, суралцахуйн явц, үр дүн зэрэг аливаа түвшний үнэлгээний амжилтын үндсэн хэмжүүр юм. Суралцагчид сургалтын хөтөлбөрт заасан үр дүнд хэр хүрсэн бэ? гэдгийг тогтоох нь сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, үнэлэх үндсэн суурь болно. Тиймээс суралцагчийн үнэлгээ нь сургалтын хөтөлбөрийн үнэлгээний чухал хэсэг бөгөөд боловсролын хөтөлбөрүүдийн үр нөлөө, үр дүнг ойлгох, сургалтын хөтөлбөрийг

тодорхой цагийн хуваарийн хүрээнд суралцах боломжтой эсэхийг шийдвэрлэхэд тусалдаг.

Суралцагчийн үнэлгээний үр дүн нь нөхцөл байдлаас хамааралтай ч сургалтын хөтөлбөрийн агуулга, сурган хүмүүжүүлэх арга зүйд хүчтэй нөлөө үзүүлдэг. Тиймээс суралцагчийн үнэлгээ нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тохиромжтой эсэх талаар санал хүсэлтийн чухал эх сурвалж болдог.

Оношлох, баталгаажуулах, хариуцлага үүрэх зэрэг тодорхой зорилгод хүрэхийн тулд янз бүрийн төрлийн үнэлгээний арга, хэрэгсэл, стратеги шаардлагатай. Суралцагчийн үнэлгээг сургалтын явцын үнэлгээ (урьдчилсан, сурахын төлөөх үнэлгээ зэрэг), үр дүнгийн үнэлгээ (шалгуурт суурилсан, нормд суурилсан гэх мэт) гэж ангилна. Мөн зорилго, арга зүйгээс хамааруулан стандарчилсан (standardized), гүйцэтгэлд суурилсан (performance-based), нормд суурилсан (norm based) үнэлгээ гэх мэт олон янзаар ангилна.

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ нь тухайн улсын боловсролын тогтолцооны зайлшгүй чухал хэсэг бөгөөд сургалтын хөтөлбөрийн бодлогын шийдвэр гаргах үндэс суурь болж, сургалтын хөтөлбөрийн тасралтгүй тохируулга, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явцын талаарх мэдээллийг өгдөг баримт бичиг юм.

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээний үндсэн зорилго нь:

- Боловсролын хөтөлбөрийн зорилго, зорилтод хүрэхийн төлөө чиглүүлэх
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд тулгамдаж байгаа бэрхшээл, асуудлуудыг илрүүлж, шийдвэрлэх арга замуудыг дэвшүүлэх, олон нийтэд таниулах, сурталчлах
- Төрийн бодлогыг боловсролын практикт нэвтрүүлэхэд үр дүнтэй нөхцөл байдлыг хангахад чиглэнэ.

Үнэлгээ (evaluation) гэсэн нэр томъёо нь үнэ цэнийн дүгнэлт гаргах үйл явцад ерөнхийдөө хамаатай. Боловсролын салбарт үнэлгээ (evaluation) гэсэн нэр томъёо нь сургалтын хөтөлбөр, арга хэмжээ, заах арга, зохион байгуулалтын хүчин зүйлүүд, түүнчлэн суралцагчдын сургалтын үр дүн, багшийн гүйцэтгэлтэй холбоотой үйл ажиллагааг илэрхийлж дүгнэлт гаргахад хэрэглэгддэг. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ нь хэрэгжсэн сургалтын хөтөлбөр (implemented curriculum) суралцагчийн суралцах явцад гарсан амжилтад үзүүлэх нөлөөг судлах зорилготой. Ингэснээр сургалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлж буй анги доторх багшлах, суралцах үйл явцыг дахин хянан үзэж, шаардлагатай бол засч залруулах боломжийг олгоно.

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээгээр дараах зүйлийг тогтооно.

- Сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилтийн онцлог давуу болон сул талууд;
- Багшлахуй болон суралцахуйг сайжруулахад оруулах хувь нэмэр

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ нь дотоод үйл ажиллагаа байж болно. Уг үйл явцыг боловсролын тогтолцооны янз бүрийн нэгжүүд өөрсдийн зорилгын үүднээс явуулж болно. Эдгээр нэгжид боловсролын яам, орон нутгийн боловсролын байгууллага, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний газар, сургууль, олон нийтийг багтаан ойлгоно.

Сургалтын хөтөлбөрийн хяналт үнэлгээ нь хөндлөнгийн байж болно, эсвэл захиалгат хянан шалгах үйл явцаар хэрэгжүүлж болно. Эдгээрийг сургалтын хөтөлбөрийн асуудал

хариуцсан хороо, газар, хэлтэс, ажлын хэсэг байгуулан тогтмол хийнэ. Мөн сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилтийн нөхцөл байдал, үр нөлөөний талаарх судалгаа хийнэ. Эдгээр үйл явц нь сургалтын хөтөлбөрийн агуулга, одоо байгаа сурган хүмүүжүүлэх арга зүй, сургалтын арга барил, багшлахуй, суралцахуй болон сурах бичиг, сургалтын материалын үр нөлөөг хянан нягтална.

Хүснэгт 8.1. Модуль 8-ын үйл ажиллагаа ба хэрэгжүүлэх даалгавар

Үйл ажиллагаа	Даалгавар	Бүтээгдэхүүн
1. Суралцагчийн үнэлгээ	Даалгавар 1. Суралцагчийн үнэлгээ хийх явцад тулгарч буй асуудал, бэрхшээлүүдийн жагсаалтыг гаргах	<ol style="list-style-type: none"> 1. Үнэлгээний сорилтуудын жагсаалт, үндэслэл 2. Манай оны нөхцөлд хэрэглэж болох үнэлгээний стратеги 3. PISA шалгалтын хүрээнд шинжлэх ухааны бичиг үсгийн арга барилыг үнэлсэн үр дүнгийн харьцуулсан жагсаалт болон таны улс орны өнөөгийн нөхцөл байдал
	Даалгавар 2. Улс орнуудын суралцагчийн үнэлгээний стратегийг судлах	
	Даалгавар 3. Сурагчийн үнэлгээний олон улсын хөтөлбөр (PISA)-ийн стратегийг судлах	
2. Тодорхой судлагдахууны сургалтын үр дүнгийн үнэлгээ	Даалгавар 1. 21-р зууны үр чадварыг үнэлэх кейсыг судлах: “Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх”	<ol style="list-style-type: none"> 4. “Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” үр дүнтэй ба үр дүнгүй туршлага 5. “Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” үнэлгээний төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудас 6. “Асуудал шийдвэрлэх ба бүтээлч сэтгэлгээг үнэлэх” үр дүнтэй ба үр дүнгүй туршлага 7. “Асуудал шийдвэрлэх ба бүтээлч сэтгэлгээг үнэлэх” үнэлгээний төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудас 8. “Хамтдаа нийгэмшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх” үр дүнтэй ба үр дүнгүй туршлага 9. “Хамтдаа нийгэмшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх” үнэлгээний төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудас
	Даалгавар 2. 21-р үр чадварыг үнэлэх кейсыг судлах: Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх	
	Даалгавар 3. 21-р зууны үр чадварыг үнэлэх кейсыг судлах: “Хамтдаа нийгэмшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх”	
	Даалгавар 4. 21-р зууны үр чадварыг үнэлэх кейсыг судлах Нийгэм- сэтгэл хөдлөлийн үр чадварыг үнэлэх	

		<p>10. Нийгэм- сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх үр дүнтэй ба үр дүнгүй туршлага</p> <p>11. Нийгэм- сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх үнэлгээний төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудас</p>
3. Үндэсний түвшин дэх сургалтын хөтөлбөрийн үнэлгээ	Даалгавар 1. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг үнэлэх төлөвлөгөөг боловсруулах	<p>12. Төлөвлөгөөний загвар, төлөвлөгөө</p> <p>13. Судалгааны арга зүй, арга хэрэгслүүд</p> <p>14. Үнэлгээний өгөгдөл, судалгааны тайлан</p>
	Даалгавар 2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх судалгааны арга зүй, үнэлэх арга хэрэгслийг боловсруулах	
	Даалгавар 3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа хийх	
4. Сургуулийн сургалтын хөтөлбөрийн үнэлгээ	Даалгавар 1. Улс орнуудын болон өөрийн орны сургуулийн үнэлгээний кейс, туршлага судлах	<p>15. Сургуулийн үнэлгээний практик жишээнүүд</p> <p>16. Сургуулийн үнэлгээний төлөвлөгөөний загвар (өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ багтана.)</p> <p>17. Турших, хэрэгжүүлэх арга зүй, арга хэрэгсэл (Сурагчийн үнэлгээ, асуулга, ярилцлага, ажиглалт гэх мэт)</p> <p>18. Сургуулийн өөрийн тайлангийн загвар, зөвлөмж</p>
	Даалгавар 2. Сургуулийн үнэлгээний төлөвлөгөөний загвар боловсруулах	
	Даалгавар 3. Сургуулийн үнэлгээг төлөвлөх, турших, хэрэгжүүлэх арга зүйг боловсруулах	
	Даалгавар 4. Сургуулийн үнэлгээний тайлангийн загвар боловсруулах	
4 үйл ажиллагаа	3+4+3+4=14 даалгавар	18 бүтээгдэхүүн

Үйл ажиллагаа 1. Суралцагчийн үнэлгээ



Зорилго. Энэхүү үйл ажиллагаа, санал болгож буй даалгаврууд нь суралцагчийн үнэлгээний загвар, үйл явцыг тодорхойлох, тэдгээрийг практикт нэвтрүүлэх эрсдэл, үр өгөөжийн талаар ойлголттой болоход тусална.



Тогтвортой, цаг тухайд нь үнэлэх нь суралцагчийн сургалтын амжилтыг дээшлүүлэх гол түлхүүр юм. "Үнэлгээ" (assessment) болон "шалгалт" ("examination) гэсэн нэр томъёо нь үндсэндээ суралцагчдыг сонгон шалгаруулах, баталгаажуулах зорилгоор ялгах зорилгоор ашигладаг үр дүнгийн үнэлгээний тодорхой хэлбэр тул "үнэлгээ" болон "шалгалт" гэсэн нэр томъёог хооронд нь ялгах нь маш чухал юм. Үнэлгээ нь олон улсын болон бүс нутгийн түвшинд мөн үндэсний, орон нутаг, сургууль ангийн түвшинд хийгдэж болно. Блэк нар санал болгосноор. (2004), үндэсний болон олон улсын үнэлгээ нь үр дүнгийн (summative) шинж чанартай байдаг. Багш нар анги танхимд явцын болон үр дүнгийн үнэлгээг хийх боломжтой байдаг.

Үнэлгээ нь боловсролын чанарыг оношлох, хянах, баталгаажуулах боломжийг олгоно. Ингэснээр боловсролын системд ажиллаж буй хүмүүст шийдвэр, стратегийг хэрэгжүүлэх, өөрчлөх боломжийг бүрдүүлж өгдөг.

Энэ хэсэгт суралцагчийн явцын болон үр дүнгийн үнэлгээний ялгааг тусгасан болно.

	Явцын үнэлгээ (Formative assessment)	Үр дүнгийн үнэлгээ (Summative assessment)
Зорилго	Суралцагч хэрхэн суралцаж байгааг оношлох, багшлах болон суралцах аргазүйг сайжруулах	Суралцагчийн амжилтыг үнэлэх, тогтоох
Хянах шалгуур	Шалгуурт суурилсан, суралцагчид суурилсан байх	Шалгуурт суурилсан эсвэл нормд суурилсан, шалгуурын дагуу нийт суралцагчдын мэдлэгийн өсөлтийг тогтоох
Арга	Суралцах үйл ажиллагааг ажиглах, суралцагчидтай ярилцах, бичгийн ажил болон бусад бүтээлийг хянан үзэх, суралцагчид өөрийгөө үнэлэх, үе тэнгийнхнээ үнэлэх	Нийт суралцагчдад зориулсан үнэлгээний шалгуураар бичгийн ажил болон бусад бүтээлүүд дээр үнэлэлт хийх

Source: Adapted from Harlen, W. and James, M. (1997, pp. 195–209); Black, P. J. et al. (2004).

Явцын үнэлгээ (formative assessment) хийснээр суралцагч бүр мэдээллийг хэрхэн хадгалж, боловсруулж байгааг хянаж, түүнд тулгарч буй бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд багш бүр заах арга барилаа тохируулах боломжтой болдог. Явцын үнэлгээ (formative assessment)-ний явцад багш, суралцагчийн хоорондын мэдээллийн солилцоо нь суралцагчийн сурлагын амжилт, гүйцэтгэлийг сайжруулж болох нотлох баримт болж байдаг.


Үр дүнтэй явцын үнэлгээг хийхэд хангалттай нөөц, үнэлгээний арга техникээр бэлтгэгдсэн багш нар, анги дүүргэлт харьцангуй бага байх шаардлага тулгардаг тул бодит байдал дээр хэрэгжилт муу, багш нарын ойлголт төлөвшихгүй байна.

Явцын үнэлгээг практикт нэвтрүүлэхдээ суралцагчид өөрийн ахиц дэвшлийг үнэлэх, сурлагын амжилтаа хэрхэн сайжруулах талаар эргэцүүлэн бодох боломжийг олгох суралцагчийн өөрийн үнэлгээнд тулгуурлах нь чухал. Мөн үе тэнгийнхний үнэлгээг бас чухалчилж болно. Иймд багш нар шалгуурт нийцсэн явцын үнэлгээний арга хэрэгсэлийг бэлтгэхэд цаг зарцуулах хэрэгтэй болно.

Үр дүн (Summative assessment)-гийн үнэлгээг ихэвчлэн суралцагчид боловсролын түвшинд дэвшиж, гэрчилгээ, диплом олгосон эсэхийг тодорхойлоход ашигладаг. Энэ нь ихэвчлэн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцыг өөрчлөхөд ашиглаж болох шалгалтад тулгуурладаг. Гэсэн хэдий ч боловсролын яамд явцын (formative) үр дүн

(summative)- гийн үнэлгээг хослуулсан тасралтгүй үнэлгээний үйл явц (continual assessment process)-ыг илүүд үзэж байна.

Суралцагчийн үнэлгээг боловсруулах уламжлалт үйл явц нь дараах байдалтай байна.



Source: Adapted from UNESCO (2005, pp. 30–37)

Суралцагчийн суралцахуйн үнэлгээг олон чиглэлээр хэрэглэж болно. Тухайлбал:

Сургалтын хөтөлбөрийн түвшинд:

1. Боловсролын зорилго, зорилтуудыг өнөөгийн бодит байдлын хүрээнд эргэн харж, суралцагчдын өсөлт хөгжилтийн алсын харааг бий болгох;
2. Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, шинэ агуулгын хүрээг тодорхойлох;
3. Сургалтын хөтөлбөрийн агуулгын хамрах хүрээг дахин нягтлах

Сургуулийн түвшинд:

1. Багш, суралцагчдын багшлахуй болон суралцахуй байдалд хяналт, шинжилгээ хийх
2. Багшлах, суралцахуйн стратегид шинэчлэл хийх, түүнд тохирсон сургалтын арга зүй, сурган хүмүүжүүлэх арга зүйг хөгжүүлэх
3. Сургуулийн системээр дамжуулан ахиц дэвшил гаргах арга, туршлагыг сонгох турших, нэвтрүүлэх боломжийг бий болгох.

Үндэсний түвшинд:

1. Ажил олгогч болон бусад оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг хангах үүднээс сургуулийн сургалтын үр дүнгийн нийгмийн хариуцлагыг хангах;
2. Боловсролын салбарын эрх мэдэл бүхий удирдлагууд сургуулиуд болон боловсролын системийн үйл ажиллагааг харьцуулан шинжилгээ хийх



Даалгавар 1. Суралцагчийн үнэлгээ хийх явцад тулгарч буй асуудал, бэрхшээлүүдийн жагсаалтыг гаргах

Суралцагчийн явцын болон үр дүнгийн үнэлгээ хийхэд тулгамдаж буй асуудлуудыг кейс судалгаанд үндэслэн эрэмбэлэн жагсаалт гаргана.

Дараах асуултуудыг ажиллах хүрээ болгон ашиглаж болно. Үүнд:

- Суралцагчийн үнэлгээний үндэсний бодлого бий юу?
- Суралцагчийн үнэлгээтэй холбоотой ямар асуудлуудыг тодорхойлж болох вэ?
- Эдгээр асуудлууд нь суралцагчийн үнэлгээнд ямар үр дагавар авчрах вэ?
- Та ямар өөрчлөлтүүдийг санал болгох вэ?



Уншиж судлах материал:

- Суралцагчийн болон сургуулийн өөрийн үнэлгээний журмууд
- Кембрижийн Үнэлгээний төв. (2014). Багш нарт зориулсан сургалтын зөвлөмж. УБ
- Явцын үнэлгээний аргачлал, арга хэрэгсэл, үр дүнд нь шинжилгээ хийсэн кейс
- Тухайн судлагдахууны сүүлийн 3 жилийн анги дэвших болон улсын шалгалтын материал



Даалгавар 2. Суралцагчийн үнэлгээнд туршин хэрэгжүүлж байгаа үнэлгээний стратегийг судлах

1. Канад- Альберта, Герман, Итали, АНУ-Массачусетс болон Шинэ Зеланд зэрэг улс орны үнэлгээний стратегийг унших
2. Дээрх 5 улс орнуудын үнэлгээний стратегийн өөрийн орны үнэлгээний стратегитай харьцуулсан мэдээллийг харуулсан хүснэгтийг гаргах.
3. “Анги танхим дахь үнэлгээ”-ний стратегийг дахин эргэцүүлэн бодох, Монгол оронд туршин хэрэгжүүлсэн кейс судалгааг хэлэлцэх

Гол санаанууд:

- Анги танхим дахь үнэлгээний зорилгыг тодорхойлох нь чухал;
 - Анги танхим дахь үнэлгээг зорилгод тулгуурлан төлөвлөх нь уялдаатай, үр дүнтэй байх болно;
 - Анги танхим дахь үнэлгээний практик нь нийгмийн хүлээлтэд гүн гүнзгий суурилдаг;
 - Анги танхим дахь үнэлгээ нь сурагчдын хэрхэн суралцах, тэдний сурах хүсэл эрмэлзэл, багш хэрхэн заах зэрэгт гол үүрэг гүйцэтгэдэг;
 - Чанарын асуудал (найдвартай байдал-reliability, лавлагаа, тохирц-validity ба бүртгэл хөтлөлт) анги танхим дахь үнэлгээнд чухал ач холбогдолтой;
 - Багш нар анги танхим дахь үнэлгээ хийхдээ олон янзын стратеги, хэрэглүүр ашиглаж болох бөгөөд тэдгээрийг сурагчдын зорилго, хэрэгцээнд тохируулан өөрчилж болно.
4. “Явцын болон үр дүнийн үнэлгээг нэгтгэх (OECD)” баримт бичигт санал болгосон дөрвөн дүгнэлтийг Монгол орон дахь кейс судалгаагаар гарсан стратегид хэрхэн туссан талаар дүгнэлт гаргах. Үүнд:
 - Шилдэг бодлого, туршлагын талаарх мэдлэгийг бий болгохын тулд явцын үнэлгээний өгөгдлийг ашиглах;
 - Багшийн мэргэжлийн ур чадварыг дэмжих;
 - Үнэлгээний илүү үр дүнтэй арга барилыг боловсруулах замаар зардлын үр ашгийг хангах;
 - Судалгаа, боловсруулалтын цоорхойг арилгах.
 5. Суралцагчийн үнэлгээний шинэ журмын төсөл боловсруулах



Уншиж судлах материал:

- Канад- Альберта, Герман, Итали, АНУ-Массачусетс болон Шинэ Зеланд зэрэг улс орны үнэлгээний стратеги
- Black, P. J. et al. 2004. Working Inside the Black Box: Assessment for Learning in the Classroom. London, nferNelson.
- БСШУЯ. (2019). “Цэцэрлэг, ЕБС-ийн үйл ажиллагааг үнэлэх журам”. БСШУС-ын сайдын 2019 оны А/803 тушаалын хоёрдугаар хавсралт.



Даалгавар 3. Сурагчийн үнэлгээний олон улсын хөтөлбөр (PISA)-ийн стратегийг судлах

Судлагдахууны бүлэг, багаар ажиллаж, шинжлэх ухааны бичиг үсгийн мэдлэгийг үнэлж байгаа өөрийн улс орны туршлагыг олон улсын туршлага Тухайлбал: Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (OECD)- Сурлагын амжилтын олон улсын үнэлгээ (PISA)-ний хүрээ (Assessment Framework)-тэй харьцуулан судална. Сургалтын хөтөлбөрийн үндэсний стандартууд болон OECD – PISA-ийн үнэлгээний стандартуудын хооронд ямар ялгаа, хамаарал байна вэ? Хоёр баганаас бүрдсэн жагсаалтыг гаргаж болно.

PISA-ийн тодорхойлолтод шинжлэх ухааны бичиг үсгийн мэдлэгийг онцолсон	Таны одоогийн сургалтын хөтөлбөрт онцолсон шинжлэх ухааны арга барил



Уншиж судлах материал:

- Сурагчийн үнэлгээний олон улсын хөтөлбөр (PISA)-ийн тайлан



Бүтээгдэхүүн:

1. Үнэлгээний сорилтуудын жагсаалт, үр дүн
2. Санал болгож буй журмын төсөл
3. PISA шалгалтын хүрээнд шинжлэх ухааны бичиг үсгийн арга барилыг үнэлсэн үр дүнгийн харьцуулсан жагсаалт болон таны улс орны өнөөгийн нөхцөл байдал

Үйл ажиллагаа 2. Тодорхой судлагдахууны сургалтын үр дүнгийн үнэлгээ



Зорилго. Энэхүү үйл ажиллагаа, санал болгож буй даалгаврууд нь

1. Шинжлэх ухаан, технологийн боловсрол (Science and Technology Education)-г үнэлэх.
2. Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээ (problem solving and creative thinking)-г үнэлэх
3. Хамтран нийгэмшиж амьдрахын төлөө суралцах (Learning to Live Together)-г үнэлэх
4. Нийгэм- сэтгэл хөдлөлийн ур чадвар (social and emotional skills)-ыг үнэлэх

гэсэн үнэлгээний шинэлэг арга туршлагыг судалж, судлагдахууны үнэлгээнд нэвтрүүлэхэд тусална.



Сургалтын үр дүнгийн үнэлгээ нь судлагдахуун тус бүрийн сургалтын хөтөлбөрт тусгасан агуулгыг үнэлэх үйл ажиллагааг авч үзэх болно. Иймд сургалтын хөтөлбөрт тусгасан шинэ агуулгын талбарууд нь унших, математик чадварыг бодвол үнэлгээний уламжлал бага хөгжсөн байдаг. Гэсэн хэдий ч эдгээр сургалтын салбарууд нь эдийн засгийн хөгжил, байгаль орчны тогтвортой байдал, нийгмийн эв

нэгдлийг дэмжихэд үзүүлэх нөлөөллийн хүлээгдэж буй үр нөлөөгөөр олон улсын агентлагуудад онцгой сонирхолтой байдаг.

1. Шинжлэх ухаан, технологийн боловсрол (STE)-ыг үнэлэх

Шинэ мянганы хувьд мэдлэг, технологи, мэдээлэл хурдасч, бүтцийн өөрчлөлт эрчимтэй явагдаж байна. Үүний үр дүнд бид илүү шинжлэх ухаан, технологид суурилсан нийгэмд ажиллаж, амьдарч сурч байна. Шинжлэх ухаан, технологийн сургалтын хөтөлбөр нь энэ төрлийн нийгмийн хүмүүсийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх хэрэгтэй болж байна.

Тархи судлалын шинжлэх ухаанд суралцах процесст хийсэн судалгаанаас харахад чадвар эзэмшихийн тулд суурь мэдлэгийг эзэмшсэн байх шаардлагатай ажээ. Юмсыг ухаалгаар цээжлэх, сэргээн санах дасгал хийх нь тухайн судлагдахууныг амжилттай судлахад чухал ач холбогдолтой байдаг байна. Судлагдахууны мэдлэг болон сэтгэх чадвар хоёрыг тэнцвэртэй эзэмших нь боловсрол болон Сурагчийн үнэлгээний олон улсын хөтөлбөр (PISA), Олон улсын математик, шинжлэх ухааны судалгааны чиг хандлагын судалгаа (TIMSS) -ны өмнө тулгарч буй нэгэн чухал сорилт юм.

Сурагчийн үнэлгээний олон улсын хөтөлбөр (PISA), Олон улсын математик, шинжлэх ухааны судалгааны чиг хандлагын судалгаа (TIMSS) зэрэг олон улсын харьцуулсан судалгаа, үнэлгээнүүд нь дэлхийн хэмжээнд тодорхой хэмжээний нөлөөлөл үзүүлснээр хэд хэдэн улс орон үнэлгээний бодлогоо өөрчилсөн байна. Эдгээр үнэлгээний ач холбогдол нь суралцагч/иргэн танин мэдэхүйн чадвараа бодит амьдрал дээр хэрхэн хэрэглэж байгааг судлаачийн байр сууринаас үнэлдэг явдал юм.

OECD- PISA-ийн үнэлгээний хүрээ	
Шинжлэх ухааны үнэлгээний гурван домэйн	<ul style="list-style-type: none"> Шинжлэх ухааны мэдлэг: тодорхой сэдвүүдэд хэрэглэх замаар үнэлдэг; Шинжлэх ухааны үйл явц: шинжлэх ухааны мэдлэгийг хамарсан; Нөхцөл (хэрэглэх талбарууд): шинжлэх ухааны үндэслэлтэй асуудлын мэдлэг, үйл явцыг үнэлдэг
дахь шинжлэх ухааны бичиг үсгийн түвшин:	<ul style="list-style-type: none"> Энд тодорхойлсон шинжлэх ухааны бичиг үсгийн мэдлэг нь өөртөө нотлох баримт цуглуулах чадвараас илүүтэйгээр шинжлэх ухааны мэдлэгийг ашиглан “нотолгоонд суурилсан дүгнэлт гаргахад” илүү ач холбогдол өгдөг. Суралцагч бүрийн цуглуулсан нотлох баримт нь хэр үндэслэлтэй байна вэ, ямар ач холбогдолтой эсэх, хэрхэн цуглуулсан гэхээс илүүтэйгээр нотлох баримтыг дүгнэлттэй холбох чадвар, өөрөөр хэлбэл хувь хүний, нийгмийн эсвэл дэлхийн түвшний тодорхой үйл ажиллагааны асуудлыг нотлох баримттай харьцуулж, дүгнэх чадвартай байхыг чухалчилна.

Source: Organisation for Economic Co-operation and Development (OECD, 2004)

2. Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээ (problem solving and creative thinking)-г үнэлэх

2015 оны PISA үнэлгээнд анх удаа асуудлыг хамтран шийдвэрлэх чадварыг хэмжээсжүүлэн нийгмийн чадварыг үнэлсэн нь олон улсын үнэлгээний хувьд анхны тохиолдол байсан. Иймд асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх даалгаврын үе шат, хэмжээсжүүлэлтийг PISA-ийн даалгавраас судлах боломжтой юм.

3. Хамтран нийгэмшин амьдрахын төлөө суралцах (LLT)-г үнэлэх

"Хамтран амьдрахын тулд суралцах" гэдэг нь ЮНЕСКО-гийн гол эрхэм зорилго боловсролын дөрвөн тулгуур баганын нэг юм. Тухайлбал:

"Мэдэхийн тулд суралцах", "Хийж бүтээхийн тулд суралцах", "Оршин байхын тулд суралцах", "Хамтран нийгэмшин амьдрахын төлөө суралцах" гэдэг нь тэгш байдлыг үндсээр нь хүлээн зөвшөөрөхөд үндэслэсэн, ойлгох, хүлээн зөвшөөрөхийг чухалчилдаг бүх хүмүүсийн нэр төр, ялгаатай байдал, олон талт байдлыг үнэлэх ба бусдыг хүндэтгэхэд чиглэсэн концепци юм. Сүүлийн жилүүдэд ЭЗХАХБ-аас зохион байгуулдаг үнэлгээний хүрээгээ өргөжүүлэн, сургалтын амжилтыг үнэлэхдээ академик мэдлэгийн үндсэн айгаас давж бусад онц чухал айг багтаах болсон. 2015 оны PISA үнэлгээнд анх удаа асуудлыг хамтран шийдвэрлэх чадварыг хэмжээсжүүлэн нийгмийн чадварыг үнэлсэн нь олон улсын үнэлгээний хувьд анхны тохиолдол байлаа.

Манай улс Азийн онуудыг төлөөлөн оролцсон ЮНЕСКО болон АНУ-ын Брүүкингс судалгааны хүрээлэнгийн дэмжлэгтэй хэрэгжүүлсэн Бүх нийтийн үнэлгээний (Optimizing Assessment for All) төсөл нь 21-р зууны чадвар эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа, түүний үнэлгээний чанарыг дээшлүүлэхэд судалгаанд хамрагдсан.. Ази тивээс Монгол, Камбожи, Непал гэсэн 3 орон оролцсон бөгөөд асуудал шийдвэрлэх, хамтран ажиллах, шүүн тунгаах чадваруудыг 5-р ангийн хүн-нийгэм, хүн-байгаль, математикийн хичээлүүдийн агуулгуудаар үнэлэх туршилт төслийн судалгааг амжилттай хэрэгжүүлсэн. Энэхүү төслийн ажилд оролцохдоо чадваруудыг хэмжихүйц тодорхойлолтыг гаргаж даалгавруудыг боловсруулсан. Түүнээс хамтран ажиллах чадварын тодорхойлолт болон даалгаврын жишээг танилцуулж байна.

. Хамтран ажиллах чадвар /Operational definition/

Чадварын бүрдүүлбэр	Дэд бүрдүүлбэрүүд
Оролцоо	Багийн гишүүдтэй харилцах
	Хариуцлага хүлээх
	Уян хатан байх
Харилцаа	Мэдээлэл, санал бодлоо хуваалцах
	Бусдыг сонсох
	Бусдад хариулах
	Сэтгэл хөдлөлөө зөв илэрхийлэх
Хэлцэл	Зөрчилдөөнийг ялган таних
	Учир шалтгаанаа тайлбарлах
Хүлээн зөвшөөрөл	Бусдыг хүлээн зөвшөөрөх
	Бусдад хариу санал хэлэх
	Бусдын саналд зохицох
Шийдвэр гаргалт	Үүргээ хуваарилах
	Төлөвлөгөө гаргах
	Боломжит хувилбарыг тодорхойлох

5 дугаар ангийн хүн-байгаль хичээлээр хамтран ажиллах чадвар үнэлэх даалгавар

Өгөгдөл:



Усны байцаа нь хагас усны, халуун орны навчит ургамал юм. Энэ ургамлыг хоолонд хэрэглэдэг. Та нарын даалгавар бол гурваараа нэг баг болоод энэхүү ургамлыг тариалах төлөвлөгөө зохиох. Багийн гишүүн бүр тодорхой үүрэг хүлээх ба усны байцаа ургуулахад хамгийн чухал үр дүнтэй ямар арга байж болох талаар хоорондоо ярилцах

Даалгавар 1: Тодорхой үүрэг хүлээсэн багийн гишүүдийг томилох

Баг дотроо гишүүн бүр ямар дүр авахаа ярилцаад, үүргийг нь тодорхойлж өгөх. Хүснэгтэд ямар дүр авсан нь ямар үүрэг хүлээхийг тодорхойлон бичнэ үү. Багийн аль гишүүн ямар дүр яагаад хүлээснийг тайлбарлана уу. Хүлээх үүргүүдийн жишээг дор жагсаасан ба, нэмэлт үүрэг оруулж болох юм. Багийн гишүүн бүр заавал дүр авах ба давхардуулахгүй байхыг анхаарна уу.

- багийн бүх үйл ажиллагааг зохицуулах
- санал бодол дээр үндэслэж дүгнэлт гаргах
- санаа бодол, мэдээллээ хуваалцах
- бусад гишүүдэд хариу хэлэх
- гишүүдийн санал бодлыг бичиж авах
- харилцан зөвшилцөх үйлдэл хийх

Дүр А – Багийн ахлагч	Дүр В – Тэмдэглэл хөтлөгч	Дүр С - Дамжуулагч
Ямар үүрэг хүлээх вэ?	Ямар үүрэг хүлээх вэ?	Ямар үүрэг хүлээх вэ?
Хэн, яагаад?	Хэн, яагаад?	Хэн, яагаад?

Даалгавар 2: Баг дотроо мэдээлэл болон санаагаа хуваалцах

Ургамал тарьж ургуулахад шаардлагатай зүйлсийн жагсаалт гаргаж баг дотроо санал бодлоо хуваалцана уу. Санаа гарах болгонд хэн уг санааг гаргасан (хэн санаа нэмсэн) талаар тайлбар бичнэ үү.

Ургамал тарьж ургуулахад анхаарах зүйлс	Тайлбар	Санаа гаргагч, дэмжигч

Даалгавар 3: Даалгавар гүйцэтгэхийн тулд баг дотроо ярилцах

Хамгийн үр дүнтэй санааг гаргаж ирэхийн тулд хамтран ажиллана уу. Санаануудыг хамгийн сайнаас эхлэн жагсааж бичээд яагаад гэдгээ тайлбарлан бичнэ үү.

Ургамал тарьж ургуулахад анхаарах зүйлс	Тайлбар	Нэмж санал хэлсэн


Даалгавар 4: Төлөвлөгөө гаргах

Хамгийн сүүлд сонгосон санаануудаас ямар гол санаа нь 3 үе шатыг дамжихыг тодорхойл: тарих бэлтгэл, ургуулах болон хянах хураах үе. Дараа нь, даалгавраа гүйцэтгэж ургамлаа тарих үйл ажиллагааны төлөвлөгөө гаргана уу. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд ямар мэдээлэл болон бусад эх сурвалж шаардлагатай вэ?


Бэлтгэл үе шат	Ургах болон хянах үе шат	Хураах үе шат
Гол даалгавар ----- ----- -----	Гол даалгавар ----- ----- -----	Гол даалгавар ----- ----- -----
Хэрэгжүүлэх төлөвлөгөө ----- ----- -----	Хэрэгжүүлэх төлөвлөгөө ----- ----- -----	Хэрэгжүүлэх төлөвлөгөө ----- ----- -----
Төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд чамд ямар мэдээлэл, өөр эх сурвалжууд хэрэг болох? ----- ----- -----	Төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд чамд ямар мэдээлэл, өөр эх сурвалжууд хэрэг болох? ----- ----- -----	Төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд чамд ямар мэдээлэл, өөр эх сурвалжууд хэрэг болох? ----- ----- -----

Даалгавар 5: Төлөвлөгөөнд хариу саналаа хэлэх


Багууд бие биедээ төлөвлөгөөгөө танилцуулна. Үе шат бүрээр нь бусад багуудын төлөвлөгөөнд өгсөн саналаа доорх хүснэгтэд бичнэ үү.



Бэлтгэл үе



Ургуулах болон хянах үе



Хураах үе

4. *Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадвар (social and emotional skills)-ыг үнэлэх*

Мэдлэг, чадвар болон зан чанар дангаараа хүний суралцахуйг бүрдүүлдэггүй. Суралцахуйн нэн чухал бас нэгэн ай бол үнэ цэнэ, ёс суртахууны хэм хэмжээгээр дамжуулан ёс зүйг төлөвшүүлэх явдал билээ.

Нийгэм сэтгэл хөдлөлийн чадварт суралцах нь танин мэдэхүйн айтай адил чухал юм. ЭЗХАХБ-аас Нийгмийн болон Сэтгэл Хөдлөлийн Чадварын (SSES-Survey of Social and Emotional skills) судалгааг зохион байгуулсан нь нийгэм болон сэтгэл хөдлөлийн чадварт суралцахуйн анхны олон улсын үнэлгээ болсон. Энэхүү судалгаа нь суралцагчдын нийгэм, сэтгэл хөдлөлийн дараах 5 айд харгалзах 19 ур чадварын талаар мэдээлэл цуглуулжээ. Үүнд:

1. Даалгаврын гүйцэтгэл – өөрийгөө хянах, хариуцлагатай байх, тууштай байх
2. Сэтгэл хөдлөлөө хянах - стрессийг тэсвэрлэх, өөдрөг үзэл, сэтгэл хөдлөлөө хянах
3. Хамтын ажиллагаа – өрөвдөх сэтгэл, итгэлцэл, хамтын ажиллагаа
4. Нээлттэй сэтгэлгээ – хүлээцтэй байдал, сониуч зан, бүтээлч байдал
5. Бусадтай харилцах – нийтэч, тууштай, эрч хүчтэй байх

Нийгэм болон сэтгэл хөдлөлийн чадварыг эзэмшүүлэх үүргийг гэр бүл, олон нийт, үе тэнгийнхэн болон сургууль хамтран хүлээнэ. Сургууль энэ чадварыг дангаараа эзэмшүүлэх боломжгүй юм. Танин мэдэхүйн чадвараас ялгаатай нь нийгмийн чадварыг хөгжүүлэхийн тулд олон талын харилцаанд орж, олон янзын нөхцөл байдалд суралцах шаардлагатай. Сургуулиас гадуурх болон спортын үйл ажиллагаанд оролцох, олон нийтийн болон сайн дурын ажил хийх гэх мэт нь хүүхэд, залуучуудыг “сургаж” байдаг.

Нийгэм, сэтгэл хөдлөлийн суралцахуйг анхааралдаа авахыг сануулсан гол дохио нь цар тахал байлаа. Сургуулиуд үйл ажиллагаа, арга барилаа огцом өөрчлөхөд уян хатан, тууштай, зорилгодоо үнэнч, өөрийгөө удирдах чадвартай сурагчдын хувьд эдгээр чанар нь давуу тал болж байв. Хямралын нөхцөл байдал үүсэхэд тухайн нийгмийн үзүүлэх хариу үйлдэл нь иргэдийн итгэл, хариуцлагатай байдал, бусдын оронд өөрийгөө тавьж үзэх сэтгэлээр тодорхойлогдоно.

Ёс суртахууны ганхашгүй, гүн бат хэм хэмжээ, үнэ цэнийг эзэмшүүлэхэд танин мэдэхүйн болон танин мэдэхүйн бус хүчин зүйлс хэрхэн нөлөөлдгийг илүү нарийвчилсан судалгаагаар тогтоох нь зүйтэй. Бусдын оронд өөрийгөө тавьж үзэх, бусдад итгэх, хариуцлага үүрэх, бусдыг хүлээн зөвшөөрөх зэрэг нийгэм, сэтгэл хөдлөлийн чадварууд үнэ цэнийг төлөвшүүлэх үндэс суурийг тавьж өгдөг. Жишээлбэл, PISA 2018 глобал цогц чадамжийн судалгаанд залуу үеийнхний нийгэм, сэтгэл хөдлөлийн айн хүчин зүйлсийг судалсан бөгөөд бусад соёлыг хэрхэн ойлгож, үнэлж хүндэлдэг болон соёл хоорондын хэлэлцүүлэгт хэрхэн үр бүтээлтэй оролцоход суралцах уялдаа холбоог авч үзсэн билээ.



Даалгавар 1. Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх

1. **“Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” кейсыг судалж, мэдээлэлд дүн шинжилгээ хийх**

Сургууль, багш нар болон үндэсний түвшинд өмнө хэрэгжүүлсэн сургалтын хөтөлбөрийн хүрээнд “Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” даалгаврыг хэрэглэсэн туршлага, түүнийг гүйцэтгэсэн сурагчдын гүйцэтгэл, үр дүнд хийсэн шинжилгээг нэгтгэн дүгнэлт гаргана.

Дараах асуултуудыг ажиллах хүрээ болгон ашиглаж болно. Үүнд:

- Өнөөгийн манай боловсролын системд “Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” нь сургалтын хөтөлбөрүүдэд хэрхэн туссан байна вэ?
- Энэ чиглэлээр суралцагчийг үнэлсэн туршлага, үр дүн ямар байна вэ?
- “Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” агуулга сургалтын хөтөлбөрүүдэд ямар түвшинд байгаасай гэж хүсэж байна вэ?
- Таны бодлоор “Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” нь сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй болгож чадах болов уу?

2. **“Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” үнэлгээний даалгавар, хариултын болон хяналтын хуудас” боловсруулах**

Судлагдахууны багаар ажиллаж, дараах 2 чиглэлээр жишиг загвар боловсруулна.

- “Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” үнэлгээний даалгавар боловсруулах төлөвлөлт (bluprint), үнэлгээний даалгавар ямар бүтэцтэй байх вэ?
- “Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” үнэлгээний даалгаврын хариултын хуудас (markchem), хяналтын хуудас (checklist) ямар бүтэцтэй байх вэ?

3. **“Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” сэдэв, агуулгыг хэрэгжүүлэх саналыг хөгжүүлэх**

Үнэлгээний даалгавар боловсруулах төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудас нь

- Хандлага, сонирхол, анхаарал халамж
- Мэдлэг, ойлголт
- Шинжлэх ухааны сэтгэлгээ
- Харилцаа холбоо
- Шинжлэн судлах чадвар
- Удирдах байдал ба үйл ажиллагааг тусгасан эсэхийг нягтална.

Сургалтын хөтөлбөрт туссан сэдэв, агуулгын хүрээтэй уялдуулан “Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” үр дүнтэй саналууд бүхий үнэлгээний төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудсуудыг хөгжүүлнэ. Сургалтын хөтөлбөрт туссан сэдэв, агуулгын хүрээтэй уялдуулан боловсруулна.



Уншиж судлах материал:

- Боловсролын үнэлгээний төв. (2018-2022). Боловсролын чанарын үнэлгээний судалгааны тайлан. Бага, суурь, бүрэн дунд боловсрол. УБ
- АХБ. (2021). Сурагч төвтэй, тэгш хамруулах, оролцоонд суурилсан бүтээлч арга зүй., цахим сургалтын модуль.



Даалгавар 2. Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх

1. **“Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх” кейсыг судалж, мэдээлэлд дүн шинжилгээ хийх**

Сургууль, багш нар болон үндэсний түвшинд өмнө хэрэгжүүлсэн сургалтын хөтөлбөрийн хүрээнд “Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх” даалгаврыг хэрэглэсэн

туршлага, түүнийг гүйцэтгэсэн сурагчдын гүйцэтгэл, үр дүнд хийсэн шинжилгээг нэгтгэн дүгнэлт гаргана.

Дараах асуултуудыг ажиллах хүрээ болгон ашиглаж болно.Үүнд:

- Өнөөгийн манай боловсролын системд “Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх” нь сургалтын хөтөлбөрүүдэд хэрхэн туссан байна вэ?
- Энэ чиглэлээр суралцагчийг үнэлсэн туршлага, үр дүн ямар байна вэ?
- “Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх” агуулга сургалтын хөтөлбөрүүдэд ямар түвшинд байгаасай гэж хүсэж байна вэ?
- Таны бодлоор “Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх” нь сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй болгож чадах болов уу?

2. “Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх” үнэлгээний даалгавар, хариултын болон хяналтын хуудас” боловсруулах

Судлагдахууны багаар ажиллаж, дараах 2 чиглэлээр жишиг загвар боловсруулна.

- “Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх” үнэлгээний даалгавар боловсруулах төлөвлөлт (blurprint), үнэлгээний даалгавар ямар бүтэцтэй байх вэ?
- “Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх” үнэлгээний даалгаврын хариултын хуудас (markchem), хяналтын хуудас (checklist) ямар бүтэцтэй байх вэ?

3. “Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх” сэдэв, агуулгыг хэрэгжүүлэх саналыг хөгжүүлэх

Сургалтын хөтөлбөрт туссан сэдэв, агуулгын хүрээтэй уялдуулан “Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх” үр дүнтэй саналууд бүхий үнэлгээний төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудсуудыг хөгжүүлнэ. Сургалтын хөтөлбөрт туссан сэдэв, агуулгын хүрээтэй уялдуулан боловсруулна.



Уншиж судлах материал:

- Esther Care, Helyn Kim, Alvin Vista, and Kate Anderson.(2019). Education system alignment for 21st century skills Focus on assessment. Optimizing assessment for all.
- Боловсролын үнэлгээний төв. (2019). Бүх нийтийн үнэлгээ төсөл. www.eec.mn
- Боловсролын үнэлгээний төв. (2018-2022). Боловсролын чанарын үнэлгээний судалгааны тайлан. Бага, суурь, бүрэн дунд боловсрол. УБ



Даалгавар 3. Хамтдаа нийгэмшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх

1. “Хамтдаа нийгэмшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх” кейсыг судалж, мэдээлэлд дүн шинжилгээ хийх

Сургууль, багш нар болон үндэсний түвшинд өмнө хэрэгжүүлсэн сургалтын хөтөлбөрийн хүрээнд “хамтдаа нийгэмшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх” даалгаврыг хэрэглэсэн туршлага, түүнийг гүйцэтгэсэн сурагчдын гүйцэтгэл, үр дүнд хийсэн шинжилгээг нэгтгэн дүгнэлт гаргана.

Дараах асуултуудыг ажиллах хүрээ болгон ашиглаж болно.Үүнд:

- Өнөөгийн манай боловсролын системд “Хамтдаа нийгмэшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх” гэсэн туршлага байна уу?
- “Хамтдаа нийгмэшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх” агуулга, арга зүйг сургалтын хөтөлбөрүүдэд ямар түвшинд тусгаж, хэрхэн хэрэгжүүлсэн байна вэ?
- Энэ чиглэлээр суралцагчийг үнэлэх ямар хүлээлт байна вэ?
- Таны бодлоор “Хамтдаа нийгмэшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх” нь сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй болгож чадах болов уу?

2. “Хамтдаа нийгэмшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх” үнэлгээний төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудас” боловсруулах

Судлагдахууны багаар ажиллаж, дараах 2 чиглэлээр жишиг загвар боловсруулна.

- “Хамтдаа нийгмэшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх” үнэлгээний даалгавар боловсруулах төлөвлөлт (blueprint), үнэлгээний даалгавар ямар бүтэцтэй байх вэ?
- “Хамтдаа нийгмэшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх” үнэлгээний даалгаврын хариултын хуудас (markchem), хяналтын хуудас (checklist) ямар бүтэцтэй байх вэ?

3. “Хамтдаа нийгэмшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх” сэдэв, агуулгыг хэрэгжүүлэх саналыг хөгжүүлэх

Дээрх боловсруулсан жишиг загварт үндэслэн шинээр боловсруулсан сургалтын хөтөлбөрт тусгасан сэдэв, агуулгын жагсаалт гаргаж, “Хамтдаа нийгмэшин амьдрахын төлөө сурсныг үнэлэх” үр дүнтэй саналууд бүхий үнэлгээний төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудсуудыг хөгжүүлнэ. Сургалтын хөтөлбөрт туссан сэдэв, агуулгын хүрээтэй уялдуулан боловсруулна.



Уншиж судлах материал:

- Esther Care, Helyn Kim, Alvin Vista, and Kate Anderson.(2019). Education system alignment for 21st century skills Focus on assessment. Optimizing assessment for all.
- Боловсролын үнэлгээний төв. (2019). Бүх нийтийн үнэлгээ төсөл. www.eec.mn
- Боловсролын үнэлгээний төв. (2018-2022). Боловсролын чанарын үнэлгээний судалгааны тайлан. Бага, суурь, бүрэн дунд боловсрол. УБ



Даалгавар 4. Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх

1. “Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх” кейсыг судалж, мэдээлэлд дүн шинжилгээ хийх

Сургууль, багш нар болон үндэсний түвшинд өмнө хэрэгжүүлсэн сургалтын хөтөлбөрийн хүрээнд “Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх” даалгаврыг хэрэглэсэн туршлага, түүнийг гүйцэтгэсэн сурагчдын гүйцэтгэл, үр дүнд хийсэн шинжилгээг нэгтгэн дүгнэлт гаргана.

Дараах асуултуудыг ажиллах хүрээ болгон ашиглаж болно.Үүнд:

- Өнөөгийн манай боловсролын системд “Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх” гэсэн туршлага байна уу?

- “Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх” агуулга, арга зүйг сургалтын хөтөлбөрүүдэд ямар түвшинд тусгаж, хэрхэн хэрэгжүүлсэн байна вэ?
- Энэ чиглэлээр суралцагчийг үнэлэх ямар хүлээлт байна вэ?
- Таны бодлоор “Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх” нь сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй болгож чадах болов уу?

2. “Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх” үнэлгээний төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудас” боловсруулах

Судлагдахууны багаар ажиллаж, дараах 2 чиглэлээр жишиг загвар боловсруулна.

- “Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх” үнэлгээний даалгавар боловсруулах төлөвлөлт (blueprint), үнэлгээний даалгавар ямар бүтэцтэй байх вэ?
- “Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх” үнэлгээний даалгаврын хариултын хуудас (markchem), хяналтын хуудас (checklist) ямар бүтэцтэй байх вэ?

3. “Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх” сэдэв, агуулгыг хэрэгжүүлэх саналыг хөгжүүлэх

Дээрх боловсруулсан жишиг загварт үндэслэн шинээр боловсруулсан сургалтын хөтөлбөрт тусгасан сэдэв, агуулгын жагсаалт гаргаж “Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх” үр дүнтэй саналууд бүхий үнэлгээний төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудсуудыг хөгжүүлнэ. Сургалтын хөтөлбөрт туссан сэдэв, агуулгын хүрээтэй уялдуулан боловсруулна.



Бүтээгдэхүүн:

4. “Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” үр дүнтэй ба үр дүнгүй туршлага, кейсийн жагсаалт
5. “Шинжлэх ухаан, технологийн боловсролыг үнэлэх” үнэлгээний даалгавар боловсруулах төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудас
6. “Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх” үр дүнтэй ба үр дүнгүй туршлага, кейсийн жагсаалт
7. “Асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг үнэлэх” үнэлгээний даалгавар боловсруулах төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудас
8. “Хамтдаа амьдарч сурсныг үнэлэх” үр дүнтэй ба үр дүнгүй туршлага, кейсийн жагсаалт
9. “Хамтдаа амьдарч сурсныг үнэлэх” үнэлгээний даалгавар боловсруулах төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудас
10. “Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх” үр дүнтэй ба үр дүнгүй туршлага, кейсийн жагсаалт
11. “Нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварыг үнэлэх” үнэлгээний даалгавар боловсруулах төлөвлөлт, даалгавар, хариултын болон хяналтын хуудас

Үйл ажиллагаа 3. Үндэсний түвшин дэх сургалтын хөтөлбөрийн үнэлгээ



Зорилго. Энэхүү үйл ажиллагаа болон санал болгож буй даалгаврууд нь сургалтын хөтөлбөрийн давуу болон сул талуудыг үнэлэх стратегийг судлахад оролцогчдод туслах болно.



Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ нь сургалтын ач холбогдлын талаар үнэ цэнтэй дүгнэлт гаргах үйл явц юм.

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээний мөн чанар нь зорилго болон түүнийг үзэж судлаж буй субъектээс ихээхэн хамаардаг.

Сургалтын хөтөлбөрийг дараах бүлгүүд үзэж судалдаг. Үүнд:

- Бодлого боловсруулагчид болон бусад оролцогч талууд (Боловсролын салбарын удирдлага, багш, суралцагчид, эцэг эх, олон нийт) - ирээдүйн үйл ажиллагааг мэдээлэх;
- Хандивлагчид – санхүүжилт татах буюу зарцуулсан хөрөнгийн талаар тайлагнах;
- Судлаачид – олон улсын харьцуулалт болон үр дүнтэй туршлагыг тодорхойлох зорилгоор.

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ нь дараах зүйлсээс ихээхэн хамааралтай байдаг.

- Сургалтын хөтөлбөрийн бүтэц, агуулга,
 - ✓ Сүүлийн үеийн нийгэм, технологи, эдийн засаг, шинжлэх ухааны өөрчлөлтүүд;
 - ✓ Боловсролын судалгаа, боловсролын парадигмын сүүлийн үеийн дэвшил;
- Сургалтын хөтөлбөрийг боловсруулах үйл явц;
- Сургалтын хөтөлбөрийн үр нөлөө:
 - ✓ Суралцагч бүр, тэдний хэрэгцээ, оролцооны түвшин, гүйцэтгэл;
 - ✓ Сургалтын стратеги, сургуулийн динамик үйл явц;
 - ✓ Нийгэмд, түүний дотор үнэт зүйлс, харилцаа холбоо, төлөвшсөн хандлага, олон нийтийн сэтгэл ханамжийн зохистой байдал;
 - ✓ Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт болох эдийн засаг, түүний дотор хөдөлмөрийн зах зээлийн тухай;
- Сургалтын хөтөлбөрийг өөрчлөх ирээдүйн боломжит чиглэлүүд.



Даалгавар 1. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг үнэлэх төлөвлөгөөг боловсруулах

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг үнэлэх үйл явц нь судалгаанд суурилсан байна.

1. Олон улсын сургалтын хөтөлбөр болон үндэсний сургалтын хөтөлбөрийн уламжлал, шинэчлэл, хэрэгжилтийн нөхцөл байдлыг харьцуулан судлахын тулд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгааг 5 жил тутамд тогтмол хийнэ.
2. Харин шинэ сургалтын хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр хойш дуусгавар болох хүртэл хугацааг урьдчилан төлөвлөж, энэ хугацаанд боловсролын түвшин бүрийн бүх судлагдахуунаар суралцагчийн сурлагын амжилтын үнэлгээг 2-3 удаа хийж, мэдээллийн сан үүсгэн, дүн шинжилгээ хийсэн байна.



Уншиж судлах материал:

- Боловсролын хүрээлэн. (2019). Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгааны тайлан. УБ
- БСШУСЯ., Жайка төсөл. (2018). Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал. УБ
- Шинэ сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал



Даалгавар 2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгааны арга зүй, арга хэрэгсэлийг боловсруулах

Сургалтын хөтөлбөр хэрэгжих хугацаанд дараах судалгааг хийж, нотлох баримт цуглуулсан байна.

1. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа (5 жил тутам)
2. Тухайн судлагдахууны агуулга, арга зүй, үнэлгээний хөгжил болон өнөөгийн нөхцөл байдлын судалгаа (жил бүр тогтмол хийнэ)

Дараах асуултуудыг судалгааны ажлын цар хүрээ болгон ашиглаж судалгааны арга зүй арга хэрэгсэлийг боловсруулна Үүнд:

- Судалгаа нь сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцад ямар хувь нэмэр оруулах вэ?
- Сургуулийн сургалтын хөтөлбөрийн давуу болон сул талуудыг хэрхэн үнэлэх вэ?
- Сургалтын хөтөлбөр болон сурагчдын сурах чадвар хоёрын хооронд үл нийцэх хүчин зүйл байна уу?
- Хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ямар арга хэрэгсэл, шалгуураар үнэлэх вэ?
- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий удирдамж болон тусгай сэдвийг анги танхимд заах, хэрэгжүүлэх удирдамжийн хоорондын ялгааг арилгахын тулд ямар стратеги ашиглаж болох вэ?
- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ?



Уншиж судлах материал:

- Боловсролын хүрээлэн. (2019). Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгааны тайлан. УБ
- БСШУСЯ., Жайка төсөл. (2018). Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал. УБ



Даалгавар 3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа хийх

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэний дараа буюу 3 дахь жил, мөн шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс 2 жилийн өмнө тухайн хэрэгжүүлсэн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгааг тогтмол хийж, хүн ам зүй, нийгэм эдийн засаг, боловсролын салбарын өөрчлөлт, шинэчлэлт нь суралцагчийн сурлагын амжилтад хэрхэн нөлөөлж буйг илрүүлж, шийдвэр гаргах дүгнэлт хийнэ. Тухайлбал.

Судалгааны үр дүн, дүгнэлтэд тулгуурлан

- Боловсролын бодлого, шинэчлэлийн чиглэл, төлөвлөлтийг тодорхойлох
- Мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Багшийг бэлтгэх, давтан сургах
- Сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хангалт, хүртээмж, ашиглалтад анхаарах
- Орон нутгийн оролцоо, олон нийтийн дэмжлэгийг хөхүүлэн дэмжих гэх мэт



Уншиж судлах материал:

- Боловсролын хүрээлэн. (2019). Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгааны тайлан. УБ
- БСШУСЯ., Жайка төсөл. (2018). Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал. УБ



Бүтээгдэхүүн:

12. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг үнэлэх төлөвлөгөө
13. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг үнэлэх судалгааны арга зүй, арга хэрэгсэл
14. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгааны тайлан

Үйл ажиллагаа 4. Сургуулийн түвшин дэх сургалтын хөтөлбөрийн үнэлгээ



Зорилго. Энэхүү үйл ажиллагаа болон санал болгож буй даалгаврууд нь төлөвлөсөн болон хэрэгжсэн сургалтын хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хэмжих арга болох сургуулийн сургалтын хөтөлбөрийн үнэлгээний талаар илүү гүнзгий ойлголттой болоход оролцогчдод туслах болно.



Улс орнууд сургуулиудын өөрийн үнэлгээ эсвэл гадаад болон дотоод үнэлгээний практикийг хослуулан сурталчлах нь улам бүр нэмэгдсээр байна.

Сургуулийн үнэлгээ нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд хамааралтай тодорхой нөхцөл байдлын талаар чухал мэдээллийг гаргаж өгдөг.

Сургуулийн үнэлгээ нь:

1. Системчилсэн байдлаар цуглуулсан нотлох баримтад үндэслэсэн байх;
2. Нотлох баримт нь ихэвчлэн хоёрдмол утгатай байдаг тул өгөгдлийг тайлбарлах арга зүйг ашиглах;
3. Заасан болон сурсан зүйлсийн хоорондын хамаарлын талаар мөн сургалтын ирээдүйн үр нөлөөний талаар дүгнэлт гаргах
4. Сургуулийн хүрээнд үйл ажиллагааг чиглүүлэх, илүү сайн туршлага, бодлогыг сурталчлах

зэрэгт анхаарал хандуулж чадвал системийг бүхэлд нь сайжруулахад тусалж чадна.

Сургуулийн дотоод болон гадаад үнэлгээг хэд хэдэн аргаар нэгтгэж болно.

- Зэрэгцээ үнэлгээ (Parallel evaluation): гадаад болон дотоод үнэлгээний системүүд нь бие даасан, тус бүр нь тодорхой протокол, журам, шалгуур, чиглэлтэй байдаг;
- Дараалсан үнэлгээ (Sequential evaluation): хөндлөнгийн үнэлгээчид сургуулиас гаргасан өөрийн үнэлгээний тайланг эхлэл болгон авдаг;
- Хамтын үнэлгээ (Cooperative evaluation): хөндлөнгийн үнэлгээчид сургуулийн ажилтнуудтай хамтран үнэлгээний нэгдсэн арга барилыг боловсруулдаг.

Зэрэгцээ үнэлгээ нь олон тооны сургуулиудын сургалтын хөтөлбөрийн талаар мэдээлэл цуглуулж, цаашдын дүн шинжилгээ хийх, шинэ хөгжил, сайжруулах үйл явцын үндэс болох дүгнэлт гаргах шаардлагатай үед ашигтай байж болно.

Дараалсан болон хамтын үнэлгээ нь сайжруулах шаардлагатай үед тодорхой сургуулиудад илүү хангалттай хөндлөнгийн оролцоог хангах боломжийг олгодог.



Даалгавар 1. Сургалтын чанарыг сайжруулах сургуулийн өөрийн үнэлгээ хийх төлөвлөгөө боловсруулах

Сургууль бүр сургалтын чанарыг сайжруулах өөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлт бүхий хяналтын хуудсыг боловсруулна. Энэ нь суралцагч нэг бүрийн сурлагын ахиц, амжилт, багшийн заах арга зүйг өөрчлөх шаардлага, хэрэгцээ байгааг илрүүлэхүйц боловсруулагдсан байна. Дараа нь хяналтын хуудсаар сургуулийн өөрийн үнэлгээ хийх, календарчилсан төлөвлөгөөг боловсруулна. Сургуулийн өөрийн үнэлгээг хавар хичээлийн жилийн төсгөлд хийж, намар үр дүнг хамт олны хурлаар хэлэлцэж, хэрэгжүүлэх нь манай орны хувьд тохиромжтой байж болох юм. Сургалтын чанарыг сайжруулах сургуулийн өөрийн үнэлгээг жил бүр хийх нь ямар хичээлийн аль бүлэг сэдвийн агуулга, арга зүйгээр сурагчид хоцрогдоод эсвэл амжилттай суралцаж байна, ямар хичээлийн багшийн арга зүйг сайжруулах эсвэл сайн туршлагыг нь түгээн дэлгэрүүлэх шаардлагатай байна гэдгийг илрүүлж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх сайн талтай.



Уншиж судлах материал:

- Дэлхийн банк. (2020). “Багшлахуй” ажиглагчийн гарын авлага. teach@worldbank.org
- БШУЯ., Жайка төсөл. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал (2018). УБ
- Сургуулийн өөрийн үнэлгээний журам, сайн туршлагууд
- ТХБ-II төсөл. (2020) Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага. Багц гарын авлага. УБ



Даалгавар 2. Сургалтын чанарыг сайжруулах сургуулийн өөрийн үнэлгээ хийх арга зүй, арга хэрэгсэлийг боловсруулж, хамт олны хурлаар хэлэлцэх

Сургалтын чанарыг сайжруулах сургуулийн өөрийн үнэлгээ хийхийн тулд сургуулийн түвшинд мэдээллийн эх сурвалжийг тодорхойлж, мэдээлэл цуглуулах хангалттай аргыг сонгох хэрэгтэй.

Мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох: Холбогдох мэдээллийг хэн эсвэл юунаас цуглуулахаа тодорхойлно. Тухайлбал:

- Дүүргийн удирдлагууд
- Сургуулийн удирдах зөвлөлийн гишүүд
- Сургуулийн удирдлагууд
- Захиргааны ажилтнууд
- Ангийн багш нар
- Эцэг эх, олон нийтийн бусад гишүүд
- суралцагчид
- Баримт бичиг (шалгалтын онооны тайлан, бодлогын баримт бичиг гэх мэт)

Мэдээлэл цуглуулах аргуудыг сонгох: Мэдээллийг цуглуулах арга хэрэгсэл, шалгуурыг боловсруулж, мэдээлэлийг бүрэн цуглуулна. Тухайлбал:

- Ярилцлага
- Ажиглалт
- Судалгаа
- Баримт бичгийн шинжилгээ

Сургалтын хөтөлбөрийн асуудал	Ярилцлага	Судалгаа	Ажиглалт	Шинжилгээ хийх баримт бичиг
Төлөвлөлт нь сургалтын хөтөлбөртэй нийцдэг эсэх				Багш нарын хичээлийн төлөвлөгөө
Сонгосон сурах бичиг тохиромжтой эсэх		30 багш		
Сургалтын хөтөлбөрт заасан агуулгыг заадаг эсэх				Оюутны тест, дасгалын ном
Сургалтын арга зүй хангалттай эсэх	Захирал		10 багш	
Улсын стандартад нийцүүлэх	5 багш			Оюутнуудын тестүүд

Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх: Цуглуулсан мэдээлэл нь арга тус бүрийн шалгууруудыг хэр хангаж байгааг үнэлэх замаар өгөгдөлд дүн шинжилгээ хийж, тайланг хамт олны хурлаар хэлэлцэж, цаашид сайжруулах арга замыг тодорхойлно.



Уншиж судлах материал:

- Дэлхийн банк. (2020). “Багшлахуй” ажиглагчийн гарын авлага. teach@worldbank.org
- БСШУСЯ., Жайка төсөл. (2018). Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал. УБ
- Сургуулийн өөрийн үнэлгээний журам, сайн туршлагууд
- ТХБ-II төсөл. (2020) Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага. Багц гарын авлага. УБ



Даалгавар 3. Сургалтын чанарыг сайжруулах сургуулийн өөрийн үнэлгээ хийх

Сургалтын хөтөлбөрийг уялдуулах: Төлөвлөсөн сургалтын хөтөлбөр (intended curriculum) (стандарт ба сургалтын төлөвлөгөө) болон гүйцэтгэсэн сургалтын хөтөлбөр (performed curriculum) (заавар, үнэлгээ) хоорондоо хэр зэрэг нийцэж байгааг тодорхойлно. Төлөвлөлт ба заах үйл явц нь сургууль, тэнхим, багш нарын хүрээнд янз бүрийн түвшний сургалтын хөтөлбөрийг хэд хэдэн удаа тайлбарлах замаар явагддаг тул уялдуулах түвшин нь сургууль, хичээлээс хамаарч өөр өөр байж болно. Хичээлийн хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад багш нар өөрсдөө өөрсдийн санаа зовоосон асуудалд нийцүүлэн тогтсон сургалтын хөтөлбөрийг (prescribed curriculum) өөрчлөн тохируулж, сурагчдынхаа хэрэгцээг тусгасан агуулгаар эрэмбэлдэг. Иймд багшийн заасан хичээл, шалгалтын даалгаврын түүврийг үндэсний сургалтын хөтөлбөртэй уялдсан эсэхийг харьцуулж, багш нарт сар бүр арга зүйгээ сайжруулах бусад багш нартай хамтран хичээлээ төлөвлөж заах талаар зөвлөмж өгнө. Үүний тулд сургуулиуд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын чанарын үр нөлөөг мэдээлж байх дараах нотлох баримтуудыг бэлтгэсэн байна. Үүнд

- Хяналтын хуудас, өөрийгөө болон үе тэнгийнхний үнэлгээний хуваарь;
- Явцын тайлан;
- Багш, оюутан, төгсөгчидтэй хийсэн ярилцлага;
- Судалгаа, асуулга;
- Багшийн хичээлийн төлөвлөлт;
- Сурагчдын ирц, анги дэвших хувь;
- Хичээлийн ажиглалт, зураг авалт, бичлэг хийх;
- Объектив буюу стандартчилсан туршилтууд;
- Гэрэл зураг
- Эцсийн тайлан гэх мэт



Уншиж судлах материал:

- Дэлхийн банк. (2020). “Багшлахуй” ажиглагчийн гарын авлага. teach@worldbank.org
- БШУЯ., Жайка төсөл. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал (2018). УБ
- Сургуулийн өөрийн үнэлгээний журам, сайн туршлагаууд
- ТХБ-II төсөл. (2020) Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага. Багц гарын авлага. УБ



Бүтээгдэхүүн:

15. Сургуулийн өөрийн үнэлгээний практик жишээнүүд
16. Сургуулийн өөрийн үнэлгээний төлөвлөгөө
17. Судлагдагдахуун бүрийн шалгалтын даалгаврын гүйцэтгэлийн жишээ
18. Сургуулийн өөрийн үнэлгээний явцын болон эцсийн тайлан, багшид өгөх зөвлөмж

ДҮГНЭЛТ

1. Багшийн мэргэжлийн хөгжил гол төлөв дараах гурван үе шаттайгаар явагддаг.
 - Сургуулиудад томилогдох, томилогдохын өмнө бэлтгэл буюу багшаар бэлтгэгдэх;
 - Албан ёсоор ажиллах (ихэвчлэн багшлах эхний гурван жил)
 - Багшийн мэргэжлийн карьерын туршид явагддаг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах

Иймд багш бэлтгэх, давтан сургах үйл ажиллагааг хамгийн үр дүнтэй зохион байгуулахад багшийн хөгжлийн гурван үе шат бүрийг өмнөх үе шатны сургамж, багшийн мэргэжлийн туршлага дээр үндэслэх, уялдуулах нь чухал байна.

2. Шинэ сургалтын хөтөлбөрийг “турших, хэрэгжүүлэх загвар”-ыг боловсруулахдаа турших түүврийн хэмжээ, турших шинэ агуулга, арга зүйн шинэлэг санаа нь санал болгож буй сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд боломжтой эсэхийг үнэлэх туршилт хийх, практикт туршсан сайн үр дүнд тулгуурлан чанарыг сайжруулах ажлыг эрчимжүүлэх, тэдгээрийг хэрэгжүүлэх хүний, санхүүгийн, материалын нөөцийг тооцох нь боловсролын бодлогод эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой.
3. Сургууль бүр үндэсний сургалтын хөтөлбөр, орон нутаг, сургуулийн шийдвэрлэвэл зохих асуудал, суралцагчийн хэрэгцээнд үндэслэсэн сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх, сургуулийн өөрийн үнэлгээ хийх арга аргачлал, хэрэгжүүлэх менежментийг дэмжиж, түгээн дэлгэрүүлэх нь үндэсний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд чухал нөлөө үзүүлэх ач холбогдолтой болно.
4. Сургууль бөгөөд үндэсний түвшинд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг үнэлэх судалгааг хөгжүүлж, нотлох баримтуудыг цуглуулах нь боловсролын бодлого, шинэчлэлийн чиглэл, төлөвлөлтийг тодорхойлох; мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; багшийг бэлтгэх, давтан сургах; сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хангалт, хүртээмж, ашиглалтад анхаарах; орон нутгийн оролцоо, олон нийтийн дэмжлэгийг хөхүүлэн дэмжих сайн талтай.

САНАЛ

1. Чадавхийг хөгжүүлэх нь нэг удаагийн сургалт биш, тасралтгүй явагдах үйл явц тул багш, сургуулийн бусад ажилтны мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг сургууль, сургалтын төв, мэргэжлийн байгууллагууд, их дээд сургуулиудад утга учиртай, тогтвортой мөрдөх нэгдсэн загварыг санал болгон хэрэгжүүлэх хэрэгтэй. Тухайлбал:
 - Багш бэлтгэх хөтөлбөрт багшийн компетенци/ур чадваруудыг тусган хэрэгжүүлэх
 - Багшийн хөгжлийг практик нөхцөлд нь дэмжих, өөрөөр хэлбэл менторын удирдлага дор явагдах практик сургалтыг чухалчилах. Ингэснээр тэд суралцахуйг өөрсдийн нөхцөл байдалд нийцүүлэн, илүү өргөн зарчим, мэдлэг, сэдвийн хүрээнд харилцан ярилцаж, орон нутгийн соёл, бүх нийтийн мэдлэгийг тэнцвэржүүлэх боломжтой болох тул сургуульд суурилсан багшийн хөгжлийг үндэсний болон орон нутгийн нэгдсэн бодлогоор дэмжих.
 - Үндэсний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарах бэрхшээл, тэдгээрийг даван туулах арга зам, дэмжлэгийг өөрийнхөө хариуцдаг

судлагдахууны сургалтын хөтөлбөрт буулган хэрэгжүүлэхийн тулд багш бүр хувь хүний хөгжил, мэргэжил дээшлүүлэх болон ёс суртахууны сургалтад хамрагдах зэргийг багшийн хөгжлийн загварт нягт уялдуулан тусгах шаардлагатай байна.

2. Сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд түүнийг турших арга техникийн талаар багш нарт мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт явуулах, шаардлагатай нөөцүүдийг зөв хуваарилах гэх мэт бэлтгэл ажлуудыг урьдчилан төлөвлөж, хангалттай зохион байгуулах шаардлагатай. Орон нутаг, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх туршилтын хамтын ажиллагааны загварт оюутан сурагч, багш, сургуулийн захирал, хөтөлбөр боловсруулагч, сэдвийн мэргэжилтнүүд, төрийн албан хаагчдыг хамруулсан "доороос дээш чиглэсэн хамтын ажиллагаа"-ны хандлага бүхий "Туршилт ба судалгаа", "Туршилт ба үнэлгээ" , "Туршилт ба инновац"-ийн сорилыг туршин хэрэгжүүлэх боломжтой юм. Чанартай, хүртээмжтэй, тогтвортой боловсрол нь маш их үр ашиг өгдөг болох нь тодорхой боловч энд санхүүжилт байнга дутагдаж байдаг. Иймд сургалтын хөтөлбөрийг турших, хэрэгжүүлэхэд зарцуулах дотоодын санхүүжилтийг улсын төсөвт тусгах, нэмэгдүүлэх нь чухал юм.
3. Сургуульд хамааралтай бүх хүмүүс сургуулийн зорилго, хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны талаар нэгдмэл ойлголттой болох нь чухал бөгөөд үүний тулд PDCA (Plan-Do-Check-Action) загварт үндэслэсэн "Сургуулийн менежментийн нэгдсэн зураглал"-ыг боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй. Сургуулийн менежментийн нэгдсэн зураглалд бүс нутгийн өвөрмөц шаардлага, орон нутгийн нөхцөл байдал, соёл, түүх, уламжлалд үндэслэн сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээ, судлагдахууны болон судлагдахуун хоорондын агуулгын залгамж холбоо, хичээл, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлтийг тусгахыг чухалчлах хэрэгтэй. Сургууль бүр сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хичээлийн судалгаа, хяналтын хуудсаар үнэлж жил бүр сургуулийн нэгдсэн тайланг боловсруулж, жилийн зорилго, зорилтоо хэр хэмжээнд биелүүлж, ямар амжилт гаргаснаа оролцогч талуудад тайлагнах нь нэгдсэн ойлголтод хүрэх сайн тал юм.
4. 21-р зуунд шинжлэх ухааны мэдлэг ойлголтыг үнэлэхээс гадна асуудал шийдвэрлэх бүтээлч сэтгэлгээ, хамтран суралцахуй болон нийгэм- сэтгэл хөдлөлийн гэх мэт зөөлөн ур чадваруудыг үнэлэхэд голлон анхаарч байгаа тул боловсролын түвшин бүрийн судлагдахууны үнэлгээний практикт турших, хэрэгжүүлэх, өргөнөөр нэвтрүүлэх хэрэгцээ бий болоод байна